




Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

**IRIM** **ONGOLIA**  
Independent Research Institute

# ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БИЧИЛ УУРХАЙГААС ОРУУЛЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ: СУУРЬ СУДАЛГАА



“Ай Ар Ай Эм” ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, 44 Байр, 4 тоот  
Утас/факс: 976-70117101,  
E-mail: [contact@irim.mn](mailto:contact@irim.mn)  
<http://www.irim.mn>

Улаанбаатар 2015

# АГУУЛГА

|                                                                                  |           |
|----------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>АГУУЛГА .....</b>                                                             | <b>1</b>  |
| <b>ДҮРС, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....</b>                                           | <b>4</b>  |
| <b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b>                                            | <b>7</b>  |
| <b>1. Хураангуй .....</b>                                                        | <b>8</b>  |
| <b>2. Суурь судалгааны индикаторууд .....</b>                                    | <b>11</b> |
| <b>3. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ .....</b>                                              | <b>13</b> |
| <b>4. АРГА ЗҮЙ .....</b>                                                         | <b>15</b> |
| 4.1 Суурь судалгааны зорилтууд .....                                             | 15        |
| 4.2 Судалгааны дизайн болон мэдээлэл цуглуулах арга зүй .....                    | 15        |
| 4.3 Ажлын хамрах хүрээ .....                                                     | 17        |
| 4.4 Мэдээллийн дүн шинжилгээ .....                                               | 18        |
| 4.5 Судалгааны хязгаарлалтууд .....                                              | 20        |
| 4.6 Ес зүйн журам .....                                                          | 22        |
| <b>5. ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД НӨЛӨӨ .....</b>                                         | <b>23</b> |
| 5.1 Хөдөлмөр эрхлэлт .....                                                       | 23        |
| 5.1.1 Бичил уурхайчид, ченжийн бий болгож буй ажлын байрны тоо .....             | 24        |
| 5.1.1 Бичил уурхайн үйл ажиллагаанаас олох орлого .....                          | 28        |
| 5.2 Татвар болон төлбөр хураамж .....                                            | 36        |
| 5.2.1 Татвар .....                                                               | 36        |
| 5.2.1 Төлбөр, хураамж .....                                                      | 39        |
| 5.2.1 Нийгмийн даатгал .....                                                     | 41        |
| 5.2.1 Эрүүл мэндийн даатгал .....                                                | 44        |
| 5.2.1 Роялти (Ашигт малтмалын нөөцийн төлбөр) .....                              | 47        |
| 5.2.1 Татвар болон төлбөр хураамжийн нэгтгэл тойм .....                          | 48        |
| 5.3 Ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт .....       | 50        |
| 5.4 Олон нийтэд хандсан хөрөнгө оруулалтын зардал .....                          | 53        |
| 5.5 Бичил уурхайчид, ченжийн үзүүлж буй эдийн засгийн шууд нөлөөллийн тойм ..... | 58        |
| <b>6. ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД БУС ХУВЬ НЭМЭР .....</b>                                | <b>61</b> |
| 6.1 Ажил эрхлэлт .....                                                           | 61        |
| 6.2 Ханган нийлүүлэгчдийн үйлчлүүлэгчид болон орлогын байдал .....               | 62        |
| 6.3 Жижиг, дунд хэмжээний бизнесүүдийн үйл ажиллагааны зардлууд .....            | 65        |
| 6.4 Татвар, төлбөр хураамж .....                                                 | 66        |
| 6.5 Шууд бус нөлөөллийн тойм .....                                               | 67        |
| <b>7. ЭДИЙН ЗАСГИЙН ДАМ НӨЛӨӨЛӨЛ .....</b>                                       | <b>70</b> |
| 7.1 Өрхийн хэрэглээ .....                                                        | 70        |
| 7.2 Малчдын хэрэглээ .....                                                       | 72        |
| 7.3 Дам нөлөөллийн тойм .....                                                    | 74        |

|                                                                                                              |           |
|--------------------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>8. Бичил уурхайчид, ченжийн үзүүлж буй үржигдэх нөлөөний орон нутгийн эдийн засаг дахь нөлөөлөл .....</b> | <b>77</b> |
| <b>9. ДҮГНЭЛТ .....</b>                                                                                      | <b>81</b> |
| <b>10. ЗӨВЛӨМЖҮҮД.....</b>                                                                                   | <b>84</b> |
| <b>11. ХАВСРАЛТ.....</b>                                                                                     | <b>88</b> |
| 11.1 Суурь судалгааны хураангуй .....                                                                        | 88        |
| 11.2 Terms of Reference.....                                                                                 | 91        |
| 11.3.1 Хэрэглэгдэхүүн: Албан болон албан бус бичил уурхайчид.....                                            | 94        |
| 11.3.2 Хэрэглэгдэхүүн: Малчид .....                                                                          | 100       |
| 11.3.3 Хэрэглэгдэхүүн: Орон нутгийн засаг захиргаа .....                                                     | 102       |
| 11.3.4 Хэрэглэгдэхүүн: Ченж.....                                                                             | 109       |
| 11.3.5 Хэрэглэгдэхүүн: ЖДБ эрхлэгчид .....                                                                   | 112       |
| 11.3.6 Хэрэглэгдэхүүн: ТББ .....                                                                             | 115       |

## ДҮРС, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|                                                                                                                    |    |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Дүрс 1. Мэдээлэл боловсруулах арга зүй .....                                                                       | 19 |
| Дүрс 2 Уурхайчдын өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал (96 өрхийн мэдээлэл) .....                               | 25 |
| Дүрс 3 Ченж нарын өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал.....                                                     | 25 |
| Дүрс 4Бичил уурхайчдын өрхийн гишүүдийн олборлолтонд оролцох хэлбэрүүдийг хувиар харуулав.....                     | 26 |
| Дүрс 5Улирлын чанартай бичил уурхайн олборлолтын өөрчлөлтүүд .....                                                 | 27 |
| Дүрс 6 Улирлын чанартай ченжийн үйл ажиллагааны өөрчлөлтүүд .....                                                  | 27 |
| Дүрс 7 Ашигт малтмалын худалдааны ахиуц ашиг- ченж нарын мэдээлэл .....                                            | 33 |
| Дүрс 8 Бичил уурхайчид болон ченж нарын дундаж орлогын харьцаа .....                                               | 34 |
| Дүрс 9 Татвар төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт .....                                    | 38 |
| Дүрс 10 Хураамж төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт .....                                  | 41 |
| Дүрс 11 Нийгмийн даатгал төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт .....                         | 44 |
| Дүрс 12 Эрүүл мэндийн даатгал төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт .....                    | 46 |
| Дүрс 13 Худалдан авалтын зардал - ТББ-ын мэдээлэл .....                                                            | 50 |
| Дүрс 14 ТББ-ын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд.....                                                          | 56 |
| Дүрс 15 Бичил уурхайчдын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд .....                                               | 57 |
| Дүрс 16 Ченж нарын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд .....                                                     | 58 |
| Дүрс 17. Улирлын чанартай ЖДБ эрхлэгчдийн бизнесийн мөчлөгүүд.....                                                 | 63 |
| Дүрс 18.Улирлын чанартай бичил уурхайчид болон малчидын хоорондох худалдааны мөчлөгүүд.....                        | 64 |
| <br>Хүснэгт 1 Нийт Эдийн засгийн болон үржүүлэхийн нөлөөлөл - Сумдын түвшинд.....                                  | 9  |
| Хүснэгт2. Тогтвортой бичил уурхай төслийн хамаарах бүрэлдэхүүн хэсгүүдийн (Үе шат 4) логфрейм .....                | 14 |
| Хүснэгт 3 Судалгаанд хамрагдагсад .....                                                                            | 16 |
| Хүснэгт 4ТББ-ын мэдээлсэн бичил уурхайчин, ченжийн тоо .....                                                       | 24 |
| Хүснэгт 5 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (ТББ-ын өгсөн тооны хувьд).....                               | 28 |
| Хүснэгт 6 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (нийт уурхайчдын хувьд) .....                                 | 29 |
| Хүснэгт 7 Нийт болон ТББ-ын өгсөн уурхайчдын сарын дундаж орлогын зөрүү.....                                       | 29 |
| Хүснэгт 8 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (судалгаанд хамрагсадын түвшинд).....                         | 30 |
| Хүснэгт 9 Бичил уурхайн олборлолт, ашигт малтмалын үнэ (судалгаанд хамрагсадын түвшинд).....                       | 31 |
| Хүснэгт 10 Ченж нарын ашигт малтмалын худалдаанаас олсон орлого - Судалгаанд хамрагсадын түвшинд .....             | 31 |
| Хүснэгт 11 Ченж нарын ашигт малтмалын худалдаанаас олсон орлого –Сумын түвшинд..                                   | 32 |
| Хүснэгт 12 Бичил уурхайчид болон ченж нарын бичил уурхайн нийт цэвэр орлого - судалгаанд хамрагсадын түвшинд ..... | 34 |

|                                                                                                                      |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 13 Бичил уурхайчид болон ченж нарын бичил уурхайн нийт цэвэр орлого - сумын түвшинд.....                     | 35 |
| Хүснэгт 14 Ажил эрхлэлтийн шууд хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн.....                                                  | 36 |
| Хүснэгт 15 Бичил уурхайчид болон ченжийн татвар төлөлт - судалгаанд хамрагсадын түвшинд.....                         | 37 |
| Хүснэгт 16 Бичил уурхайчид болон ченж нарын татвар төлөлт - сумын түвшинд .....                                      | 38 |
| Хүснэгт 17 Татвар төлөлтийн нэгдсэн дүн .....                                                                        | 39 |
| Хүснэгт 18 Бичил уурхайчид болон ченж нарын хураамж төлөлт - судалгаанд хамрагсадын түвшинд.....                     | 39 |
| Хүснэгт 19 Бичил уурхайчид болон ченж нарын хураамж төлөлт - сумын түвшинд .....                                     | 40 |
| Хүснэгт 20 Бичил уурхайчид, ченжийн хураамж төлөлтийн нэгдсэн дүн.....                                               | 41 |
| Хүснэгт 21 Бичил уурхайчид, ченж нарын нийгмийн даатгал төлөлтийн байдал - судалгаанд хамрагсадын түвшинд .....      | 42 |
| Хүснэгт 22 Бичил уурхайчид, ченж нарын нийгмийн даатгал төлөлтийн байдал – сумын түвшинд.....                        | 43 |
| Хүснэгт 23 Бичил уурхайчид, ченжийн нийгмийн даатгал төлөлтийн нэгдсэн дүн.....                                      | 44 |
| Хүснэгт 24 Бичил уурхайчид, ченж нарын эрүүл мэндийн даатгал төлөлтийн байдал – судалгаанд хамрагсадын түвшинд ..... | 45 |
| Хүснэгт 25 Бичил уурхайчид, ченж нарын эрүүл мэндийн даатгал төлөлтийн байдал – сумын түвшинд .....                  | 46 |
| Хүснэгт 26 Бичил уурхайчид, ченжийн эрүүл мэндийн даатгал төлөлтийн нэгдсэн дүн.....                                 | 47 |
| Хүснэгт 27 Татвар болон хураамж төлөлтийн нэгдсэн дүн - судалгаанд хамрагсадын түвшинд.....                          | 48 |
| Хүснэгт 28 Татвар болон хураамж төлөлтийн нэгдсэн дүн – сумын түвшинд .....                                          | 49 |
| Хүснэгт 29 Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардал - судалгаанд хамрагсадын түвшинд .....              | 51 |
| Хүснэгт 30. Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардал - сумын түвшинд ..                                 | 52 |
| Хүснэгт 31. Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардалын нэгдсэн дүн ....                                 | 52 |
| Хүснэгт 32 ТББ-ын олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт.....                                                           | 54 |
| Хүснэгт 33 Бичил уурхайчдын орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ.....                                      | 55 |
| Хүснэгт 34. Investments made by traders in public activities.....                                                    | 55 |
| Хүснэгт 35 Бичил уурхайчид, ченжийн шууд нөлөөллийн нэгдсэн дүн - сумын хэмжээнд ...                                 | 59 |
| Хүснэгт 36. Бичил уурхайчид, ченжийн шууд нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсадын хэмжээнд .....             | 60 |
| Хүснэгт 37 Жижиг дунд бизнесд бий болсон ажлын байр, цалин хөлс.....                                                 | 62 |
| Хүснэгт 38 ЖДБ эрхлэгчдийн худалдан авагчдын ангилал.....                                                            | 62 |
| Хүснэгт 39. ЖДБ эрхлэгчдийн үйл ажиллагааны зардал.....                                                              | 65 |
| Хүснэгт 40. ЖДБ эрхлэгчдийн татвар, хураамж төлөлт.....                                                              | 66 |
| Хүснэгт 41 Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн - судалгаанд хамрагсадын түвшинд .....                                    | 67 |
| Хүснэгт 42. Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсадын түвшинд.....                                    | 67 |
| Хүснэгт 43 Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн – сумын түвшинд.....                                                      | 68 |
| Хүснэгт 44 Бичил уурхайчин, ченжийн дам нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд.....                               | 71 |
| Хүснэгт 45 Бичил уурхайчин, ченжийн дам нөлөөлөл - сумын түвшинд.....                                                | 72 |
| Хүснэгт 46. Малчидын дам нөлөөлөл – судалгаанд хамрагсадын түвшинд .....                                             | 73 |

|                                                                                                                                   |    |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 47 Малчидын дам нөлөөлөл – сумын түвшинд .....                                                                            | 73 |
| Хүснэгт 48 Дам нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсадын түвшинд .....                                                      | 75 |
| Хүснэгт 49. Дам нөлөөллийн нэгдсэн дүн – сумын түвшинд .....                                                                      | 75 |
| Хүснэгт 50 Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд .....  | 78 |
| Хүснэгт 51. Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд ..... | 78 |
| Хүснэгт 52. Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - сумын түвшинд .....                  | 79 |
| Хүснэгт 53. Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - сумын түвшинд .....                  | 79 |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|               |                                                  |
|---------------|--------------------------------------------------|
| <b>ББС</b>    | Баримт бичгийн судалгаа                          |
| <b>БУ</b>     | Бичил уурхай                                     |
| <b>ДНБ</b>    | Дотоодын нийт бүтээгдэхүүн                       |
| <b>ЖД</b>     | Жижиг дунд                                       |
| <b>ЖДБ</b>    | Жижиг дунд бизнес эрхлэгч                        |
| <b>ЖДҮ</b>    | Жижиг дунд үйлдвэрлэгч                           |
| <b>ИНБ</b>    | Иргэний нийгмийн байгууллагууд                   |
| <b>МБ</b>     | Монгол банк                                      |
| <b>МТ</b>     | Мэдээллийн төв                                   |
| <b>МУ</b>     | Монгол улс                                       |
| <b>ОУСХ</b>   | Олон улсын социологийн хүрээлэн                  |
| <b>ОҮИТБС</b> | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг санаачлагч |
| <b>СЯ</b>     | Сангийн яам                                      |
| <b>ТББ</b>    | Төрийн бус байгууллага                           |
| <b>ТБУТ</b>   | Тогтвортой бичил уурхай төсөл                    |
| <b>ТБ</b>     | Төрийн байгууллага                               |
| <b>ШХА</b>    | Швейцарын хөгжлийн агентлаг                      |
| <b>IRIM</b>   | “Ай Ар Ай Эм” ХХК                                |
| <b>ToR</b>    | Terms of Reference                               |

# 1. Хураангуй

Бичил уурхай, гар аргаар ашигт малтмал олборлох явдал нь Монгол улсад 20 гаруй жилийн өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт эхэлж, байгалийн гамшгийн улмаас олон тооны мал хорогдон ядуурал, ажилгүйдэл нүүрлэн, газар авсанаас үүдэн анхлан эхэлжээ. Бичил уурхайгаар болон гар аргаар ашигт малтмал олборлох нь орон нутгийн ард иргэдийн хувьд орлогын гол эх үүсвэрүүдийн нэг нь болж, ядуурлыг бууруулах боломжуудыг ханган өгөх болжээ. Бичил уурхайг албан ёсны болгон баталгаажуулсанаар уурхайчдын зүгээс орон нутгийн бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх боломжийг нээж, орон нутгийн бизнесийн бусад боломжуудыг мөн бий болгожээ. Үндэсний түвшинд бичил уурхай болон гар аргаар олборлосон алтны худалдаа нь гадаад валютын орлогыг нэмэгдүүлж буй ч бичил уурхай, гар аргаар ашигт малтмал олборлох салбар нь ханган нийлүүлэлтийн сүлжээн дэхь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд шууд болон шууд бусаар баялаг бүтээх боломжийн хувьд хараахан бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй буй юм.

Судалгааг “Тогтвортой бичил уурхай” төслийн зүгээс захиалан хийлгэсэн бөгөөд судалгааны зорилго нь гар аргаар ашигт малтмал олборлогч бичил уурхайчдын үзүүлж буй эдийн засгийн нөлөө, хөдөө орон нутгийн эдийн засгийн өсөлтөд хамаарах боломжийг судлан тогтоох явдал байсан. Энэхүү судалгаа нь суурь үнэлгээ бөгөөд Тогтвортой бичил уурхай төслийн хүрээндцаашид гарах ахиц дэвшлийг хэмжин үнэлэх эхлэл цэг нь болох юм. Мөн тус судалгаа нь бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутгийн (сум), бүс нутгийн (аймаг) болон үндэсний хэмжээний амьжиргааг сайжруулах чиглэлд үзүүлж буй нөлөөг нь илүү өргөн хүрээнд илтгэн харуулах Тогтвортой бичил уурхай төслийн үр дүнгийн нэгээхэн хэсэг болох юм.

Бичил уурхай эрхлэгчдийн үзүүлж буй эдийн засгийн нийт хувь нэмэр нь шууд, шууд бус болон дам нөлөөлөл хэмээн хуваагдана. Шууд нөлөөлөл нь ашигт малтмалын олборлолттой холбоотой мөнгө хөрөнгийг зарцуулалтыг хамрах бөгөөд үүнд хөдөлмөр эрхлэлтийгбий болгох, татвар, материал хангамж болон капитал хөрөнгө оруулалт зэргийг хамруулна. Хоёрдогч буюу шууд бус нөлөөлөл нь бичил уурхай эрхлэгчдэд ханган нийлүүлэлт хийж буй жижиг, дунд бизнесийн байгууллагууд, малчидтай холбоотой зарцуулалтыг хамарна. Эцэст нь дам нөлөө нь бичил уурхай эрхлэгчид өрхийн хэрэгцээнд зориуланбараа, үйлчилгээ худалдан авах болон орон нутгийн захиргааны зүгээс тэдэнд хандсан үйл ажиллагаа зэргийг хамруулдаг. Бичил уурхай эрхлэгчид, ашигт малтмалын

худалдаачдын бий болгож буй эдийн засгийн өсөлтөд хамаарах шаардлагатай мэдээлэл байхгүйн улмаас эдийн засгийн өсөлтийг бүрэн хэмжээнд тодорхойлон гаргаагүй.

Мэдээлэл цуглуулахдаа хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг бичил уурхайчид (96 оролцогч), малчид (36 оролцогч), жижиг дунд бизнес эрхлэгчид (24 оролцогч), ашигт малтмалын худалдаачид (15 оролцогч)(цаашид **чөж** гэх) болон бичил уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын (12 оролцогч) төлөөлөлтэй хийсэн. Орон нутаг дахь мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг 2015 оны 7 болон 8 дугаар саруудад 7 аймаг, 12 суманд хийж гүйцэтгэсэн. Тухайн сонгосон 7 аймгийг Тогтвортой бичил уурхай төслийн зүгээс бичил уурхайгаас хамааралтай аймгууд хэмээн тогтоосон.

Судалгаанд тулгарсан нэг гол хязгаарлалт нь төсвийн хомсдлоос үүдэлтэйгээрсудалгаанд хамрагдах хүмүүсийн түүвэрлэлт дээртэднийг бүрэн төлөөлөхүйц түүврийн хэмжээ хязгаартай байсны улмаас цуглуулсан мэдээллийн ихэнх нь ТББ-ууд болон төрийн байгууллагуудын гарган өгсөн мэдээлэлд үндэслэгдсэн явдал юм. ТББ-уудын цуглуулсан мэдээллийн хэмжээ, чанар нь сумдаас хамааран ихээхэн ялгаатай байв. Түүнчлэн орон нутгийн төрийн байгууллагууд нь бичил уурхайтай холбоотой орлого, зарлагаа дэлгэрэнгүй задаргаатай бүртгэдэггүй тул энэ талаар мэдээлэл цуглуулах боломжгүй байв. Эдийн засгийн нөлөөллийн үнэлгээнд ашигласан мэдээллийн ихэнх хэсгийг ТББ-уудаас цуглуулсан бөгөөд цаашид хийгдэх судалгаанд орон нутгийн төрийн байгууллагуудын ажилтнуудыг илүүтэй татан оруулж, мэдээлэл цуглуулах шаардлагатай.

Хүснэгт 1 дээр харуулсан мэдээлэл нь бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутгийн эдийн засагт (сумын түвшний) үзүүлж буй хувь нэмэр болон үржигдэх нөлөөллийг нь харуулсан. Хүснэгт 1 дээр үзүүлсэн мэдээллийг сар тутмын байдлаар харуулсан.

**Хүснэгт 1 Нийт Эдийн засгийн болон үржүүлэхийн нөлөөлөл - Сумдын түвшинд**

| Байршил    |           | Нийт эдийн засгийн нөлөөлөлтөгрөг/сар |                   |              | Үржүүлэх |          |              |       |
|------------|-----------|---------------------------------------|-------------------|--------------|----------|----------|--------------|-------|
| Аймаг      | Сум       | Шууд нөлөөлөл                         | Шууд бус нөлөөлөл | Дам нөлөөлөл | Шууд     | Шууд бус | Дам нөлөөлөл | Нийт  |
| Баянхонгор | Баян-Овоо | 676,233,660                           | 630,000           | 198,174,968  | 1        | 0.001    | 0.293        | 1.294 |
|            | Бөмбөгөр  | 1,259,449,330                         | 380,238           | 250,277,517  | 1        | 0.000    | 0.199        | 1.199 |
| Говь-Алтай | Есөнбулаг | 1,842,947,368                         | 20,742,019        | 210,288,400  | 1        | 0.011    | 0.114        | 1.125 |
|            | Бигэр     | Na                                    | 1,030,625         | 62,891,752   | 1        | Na       | Na           | Na    |
| Дорноговь  | Айраг     | 253,377,201                           | 6,977,857         | 76,060,534   | 1        | 0.028    | 0.300        | 1.328 |
| Дундговь   | Хулд      | 577,582,836                           | 9,673,769         | 114,564,733  | 1        | 0.017    | 0.198        | 1.215 |

|          |           |               |             |               |   |       |       |       |
|----------|-----------|---------------|-------------|---------------|---|-------|-------|-------|
|          | Өлзийт    | 463,954,546   | 1,177,193   | 161,902,533   | 1 | 0.003 | 0.349 | 1.351 |
| Сэлэнгэ  | Мандал    | 337,493,576   | 144,900,350 | 113,387,917   | 1 | 0.429 | 0.336 | 1.765 |
|          | Шарын гол | 1,829,290,604 | 5,366,660   | 152,115,122   | 1 | 0.003 | 0.083 | 1.086 |
|          | Орхонтуул | 342,049,200   | 5,623,200   | 36,343,971    | 1 | 0.016 | 0.106 | 1.123 |
| Төв      | Заамар    | 410,077,345   | 4,513,596   | 81,633,904    | 1 | 0.011 | 0.199 | 1.210 |
|          | Борнуур   | 106,758,000   | 6,085,310   | 67,287,171    | 1 | 0.057 | 0.630 | 1.687 |
| Нийт дүн |           | 8,099,213,666 | 207,100,817 | 1,326,753,554 | 1 | 0.026 | 0.164 | 1.189 |

- Сумын түвшинд үзүүлж буй нийт шууд нөлөөлөл нь (Хүснэгт 1) 8,099,213,666 төгрөг байв. Үүнд олон нийтийн үйл ажиллагаанд зориулан хөрөнгө оруулалт хийсэн 801, 857, 000 төгрөгийг (капитал хөрөнгө оруулалт) оруулан тооцоогүй. Энэхүү хөрөнгө оруулалтыг сар тутмын байдлаар тооцон гаргах боломжгүй учир нь бүхий л хөрөнгө оруулалт нь тухайн оролцогчийн үйл ажиллагааны бүхий л он жилүүдэд хийгдсэн байдаг.
- Сумын түвшин дэхь нийт шууд бус нөлөөлөл нь сард 207,100,817 төгрөг байна.
- Бичил уурхайчид, малчдын зүгээс сумын хэмжээнд үзүүлж буй нийт дам нөлөөлөл нь сард 1,326,753,554 төгрөг байна. Энэхүү тооцоонд малчдыг багтаасан шалтгаан нь ихэнх тохиолдолд малчид ч мөн гар аргаар ашигт малтмал олборлож, нэмэлт орлого олдогтой холбоотой.
- Бичил уурхайчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй үржигдэх нөлөө 1.189 байна.

## 2.Суурь судалгааны индикаторууд

| Индикатор                                            | Мөнгөн дүн (төгрөг/сар) |
|------------------------------------------------------|-------------------------|
| <b>Ажлын байр</b>                                    |                         |
| Баянхонгор                                           |                         |
| Баян-Овоо                                            | 832                     |
| Бөмбөгөр                                             | 2,112                   |
| Говь-Алтай                                           |                         |
| Есөнбулаг                                            | 19,35                   |
| Бигэр                                                | NA                      |
| Дорноговь (Айраг)                                    | <b>165</b>              |
| Дундговь                                             |                         |
| Хулд                                                 | 489                     |
| Өлзийт                                               | 392                     |
| Дархан-Уул (Шарын гол)                               | <b>534</b>              |
| Сэлэнгэ                                              |                         |
| Мандал                                               | 851                     |
| Орхонтуул                                            | 301                     |
| Төв                                                  |                         |
| Заамар                                               | 150                     |
| Борнуур                                              | 152                     |
| Нийт ажлын байр                                      | <b>7,917</b>            |
| <b>Нийт олборлолт</b>                                |                         |
| Баянхонгор                                           | <b>9,240,000</b>        |
| Баян-Овоо                                            | 2,860,000               |
| Бөмбөгөр                                             | 6,380,000               |
| Говь-Алтай                                           | <b>8,450,000</b>        |
| Есөнбулаг                                            | 3,060,000               |
| Бигэр                                                | 5,390,000               |
| Дорноговь (Айраг)                                    | <b>15,220,000</b>       |
| Дундговь                                             | <b>15,482,000</b>       |
| Хулд                                                 | 9,854,000               |
| Өлзийт                                               | 5,628,000               |
| Дархан-Уул (Шарын гол)                               | <b>4,100,000</b>        |
| Сэлэнгэ                                              | <b>10,910,000</b>       |
| Мандал                                               | 2,740,000               |
| Орхонтуул                                            | 8,170,000               |
| Төв                                                  | <b>11,530,000</b>       |
| Заамар                                               | 7,530,000               |
| Борнуур                                              | 4,000,000               |
| Нийт                                                 | <b>74,932,000</b>       |
| <b>Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл</b> |                         |
| <b>Шууд нөлөөлөл</b>                                 | <b>8,099,213,666</b>    |
| Ажил эрхлэлт                                         | 3,077,628,875           |
| Татвар, хураамж                                      | 138,028,401             |
| Худалдан авалт                                       | 4,883,556,390           |
| Олон нийтийн хөрөнгө оруулалт                        | 801,857,400 (overtime)  |
| <b>Шууд бус нөлөөлөл (жигжиг дунд бизнес)</b>        | <b>207,100,817</b>      |

|                                                        |                        |
|--------------------------------------------------------|------------------------|
| Ажил эрхлэлт                                           | 84,753,700             |
| Үйл ажиллагааны зардал                                 | 1,079,023,95           |
| Татвар, хураамж                                        | 14,444,722             |
| <b>Дам нөлөөлөл</b>                                    | <b>1,524,928,522</b>   |
| Бичил уурхайчид, ченжийн өрхийн зардал                 | 648,531,412            |
| Бичил уурхайчид, ченжийн өрхөд хийсэн хөрөнгө оруулалт | 223,340,000 (overtime) |
| Малчидын өрхийн зардал                                 | 876,398,239            |
| <b>Эдийн засгийн үржүүлэгч</b>                         | <b>1.189</b>           |
| Шууд нөлөөллийн үржүүлэгч                              | 1                      |
| Шууд бус нөлөөллийн үржүүлэгч                          | 0.026                  |
| Дам нөлөөллийн үржүүлэгч                               | 0.164                  |

### 3. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Бичил болон гар аргаар ашигт малтмал олборлох явдал Монгол улсад 20 гаруй жилийн өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилт эхэлж, байгалийн гамшгийн улмаас олон тооны мал хорогдон ядуурал, ажилгүйдэл нүүрлэн, газар авсанаас үүдэн анхлан эхэлжээ. Бичил болон гар аргаар ашигт малтмал олборлолт хөдөө орон нутгийн ард иргэдийн хувьд орлогын гол эх үүсвэрүүдийнх нь нэг болж, ядуурлыг бууруулах боломжуудыг ханган өгөх болжээ.

Өнөөдөр бичил уурхайн үйл ажиллагаа нь Монгол улсын олон аймгуудад түгээмэл явагдах болж, эдийн засагт жин дарах болсон бөгөөд энэ салбарт ойролцоогоор 100,000<sup>1</sup> хүн хамрагдаж байна. Бичил уурхайг албан ёсны болгон баталгаажуулсан нь уурхайчдын зүгээс орон нутгийн бизнесийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх боломжийг нээн, орон нутгийн бизнесийн хөгжлийн боломжуудыг мөн бий болгожээ. Үндэсний түвшинд бичил уурхай, гар аргаар олборлосон алтны худалдаа нь гадаад валютын орлогыг нэмэгдүүлж буй ч бичил уурхай, гар аргаар ашигт малтмал олборлох салбар нь ханган нийлүүлэлтийн сүлжээн дэхь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд шууд болон шууд бусаар баялаг бүтээх боломжийн хувьд хараахан бүрэн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөөгүй юм.

Швейцарын Хөгжлийн Агентлагийн хэрэгжүүлж буй Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) нь анх 2005 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2015 оны 1 дүгээр сараас тус төслийн 4 дүгээр үе шат эхэлж, нийт гурван жилийн хугацаанд хэрэгжих юм. Тогтвортой бичил уурхай төслийн нийтлэг зорилго нь Монгол улсад эдийн засгийн хувьд тогтвортой, байгаль орчны хувьд хариуцлагатай, хүний эрхэд суурилсан бичил уурхайн салбарыг бий болгож, дэлхий нийтийн хэмжээний гар аргаар болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тэргүүлэх туршлагаудыг ашиглан үр шимийг нь хүртэх, хувь нэмэр оруулах явдал юм.

Тогтвортой бичил уурхай төслийн 4 дүгээр үе шат нь доор дурдсан гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байна:

1. Хүний эрхэд суурилсан бичил уурхайн бодлого, орон нутгийн бичил уурхайчдыг дэмжих үйл ажиллагаа

<sup>1</sup>Мэдээллийг Тогтвортой бичил уурхай төслийн баримт бичгүүдээс цуглуулсан. 4 дүгээр үе шат, 2015-2018, хуудас 10

2. Нийлүүлэлтийн албан ёсны сүлжээнд оролцогч талуудын эдийн засгийг бэхжүүлэх
3. Мэдлэг хуваалцах ба БУ-н талаар дэлхийн хэмжээний бодлогын хэлэлцүүлэг

Энэхүү судалгаа нь Тогтвортой бичил уурхай төслийн 4 дүгээр үе шатны Үр дүн 2-ын хүрээнд хийгдсэн. Тогтвортой бичил уурхай төслийн 4 дүгээр үе шатны логфрейм дээр дурдагдсан хамаарах үр дүн, гарц, шалгуур үзүүлэлт болон үйл ажиллагааг Хүснэгт 2 дээр харууллаа.

**Хүснэгт2. Тогтвортой бичил уурхай төслийн хамаарах бүрэлдэхүүн хэсгүүдийн (Үе шат 4) логфрейм**

| Логфреймын бүрэлдэхүүн хэсгүүд | Тайлбар                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|--------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үр дүн 2                       | Нийлүүлэлтийн сүлжээний бүх талуудын оролцоотойгоор бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалын орон нутгийн, бүсийн болон үндэсний хэмжээнд эдийн засгийг бэхжүүлэх, амьжиргааны түвшинг сайжруулахад оруулдаг хувь нэмэр мэдэгдэхүйцээр нэмэгдсэн байна                                                                                                               |
| Гарц 2.4                       | Орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэх – Тогтвортой бичил уурхайн байгууллагууд болон ашигт малтмалын ченж нь орон нутгийн амьжиргаа, эдийн засгийн төрөлжилт, уян хатан байдалд оруулах хувь нэмрээ нэмэгдүүлж, оролцогч талууд нь эдгээр хувь нэмэр болон нөлөөллийн талаар мэдлэгтэй болсон байх                                                                       |
| Үзүүлэлтүүд                    | Уурхайчид (эрэгтэй болон эмэгтэй) болон ченжийн зүгээс эдийн засгийн бусад салбаруудад хийж буй нийт хөрөнгө оруулалт жил тутамд 20%-иар нэмэгдсэн байх                                                                                                                                                                                                                 |
| Үйл ажиллагаа                  | Гуравдагч талууд нь зохистой, нөлөө бүхий, олон цар хүрээг хамрах харилцаа холбооны сувгуудаар дамжуулан бичил уурхай нь орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж буй талаарх мэдээллийг олж, хэвлэн нийтлэн, бичил уурхайн үзүүлж буй нөлөөллийг үнэлэхдээ эерэг болон сөрөг үйл ажиллагааны тэнцлийг хангахыг баталгаажуулж байдаг болсон байх |


## 4.АРГА ЗҮЙ

### 4.1 Суурь судалгааны зорилтууд

Суурь судалгааны үндсэн зорилт нь бичил болон гар аргаар ашигт малтмал олборлогчдын зүгээс орон нутгийн (аймаг) эдийн засаг, эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй хувь нэмрийг тодорхойлох, улмаар ирээдүйд үзүүлэх тухайн хувь нэмрийг тогтоох үзүүлэлтүүдийг тодорхойлон гаргахад шаардлагатай суурь мэдээллийг ханган өгөх явдал байв.

### 4.2 Судалгааны дизайн болон мэдээлэл цуглуулах арга зүй

Судалгааны дизайн нь “өмнөх болон дараах” төслийн үнэлгээний төрөлд суурилсан. Тус судалгаа нь бичил уурхай эрхлэгчдийн зүгээс үзүүлж буй өнөөгийн хувь нэмрийг тогтоогоод зогсохгүй мөн цаашдын ирээдүйд хийгдэх үнэлгээний жишгийг тогтооход төвлөрсөн юм. Тиймээс энэхүү судалгаа нь ирээдүйн ахиц дэвшил, амжилтыг харьцуулан хэмжин үнэлэх эхлэл цэг болох юм.



Ялангуяа энэхүү судалгаа нь доор дурдсан суурь нөхцөл байдлыг тогтооход зорьсон:

1. Бичил уурхай эрхлэгчдийн орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр
2. Бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын төрөл, эзлэх хувь хэмжээ
3. Бичил уурхай эрхлэгчдийн зүгээс үзүүлж буй нөлөөллийн үр шимийг хүртгэгчид
4. Орон нутгийн эдийн засагт үзүүлж буй өсөлтийн хувь нэмэр
5. Бичил уурхай эрхлэгчдийн орлогыг төрөлжүүлэх боломжууд
6. Орлогыг төрөлжүүлэх арга замууд

#### Бичиг баримтын судалгаа

IRIM судалгааны хүрээлэн болон ШХА нь энэхүү судалгааг үндэсний хэмжээний судалгаа болгохгүй байхаар тохирсон бөгөөд учир нь үндэсний хэмжээнд судалгаа хийхийн тулд нэг аймагт хамгийн багадаа 360 өрх бүхий түүврийн хэмжээ шаардагдах юм. Талуудын

харилцан тохирсоноор энэхүү үндэсний хэмжээнд судлах хандлага нь зохион байгуулалтын хувьдажил ихтэй, зардлын хувьд өндөр байх юм. Тийм учраас IRIM судалгааны хүрээлэн нь орон нутгийн ТББ-уудаас цуглуулан авсан мэдээллийг судлах, дүн шинжилгээ хийх бичиг баримтын судалгаанд төвлөрөн ажилласан. Энэхүү мэдээллийг бичил уурхай эрхлэгчдийн тоог тогтоох, тэдний төлж буй татвар, төлбөр хураамжийн хэмжээг тооцоход ашигласан.

### Мэдээлэл цуглуулах

Хагас бүтэцлэгдсэн ярилцлага ашиглан судалгааны мэдээллийг цуглуулсан. Ярилцлагыг 2015 оны 7 болон 8 дугаар саруудад сонгон авсан 7 аймагт хийсэн. Эдгээр долоон аймгийг сонгохдоо Тогтвортой бичил уурхай төслийн ажилтнуудтай зөвлөлдөж, гар аргаар ашигт малтмал олборлогчдын тоо хамгийн өндөр буй аймгуудыг сонгон, судалгаанд хамруулсан. Мэдээлэл цуглуулах үндсэн ярилцлага нь доор дурдсан 6 төрөлд хамаарах хүмүүст төвлөрөн хийгдсэн:

1. Уурхайчид;
2. Малчид;
3. Ашигт малтмалын ченж;
4. Орон нутгийн бизнес эрхлэгчид;
5. Орон нутгийн гар аргаар ашигт малтмал олборлогчид, бичил уурхайчдын ТББ-ууд;
6. Орон нутгийн төрийн байгууллагын ажилтнууд.

Тухайн бүлэг нэг бүрт зориулсан, хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг боловсруулан, тавигдах асуултуудыг тухайн судалгаанд хамрагдаж буй этгээдийн мэдлэг бүхий салбарт чиглүүлэн гаргасан (Хавсралтыг үзнэ үү). Тогтвортой бичил уурхай төслийн зүгээс баталгаажуулсан арга зүйн хувьд IRIM судалгааны хүрээлэн нь сум нэг бүрээс судалгаанд хамрагдах хүмүүсийн төрөл, тоог Хүснэгт 3 дээр харуулсаны дагуу сонгон, тогтоосон.

Хүснэгт 3 Судалгаанд хамрагдагсад

| Маршрут    |           | Түүврийн хэмжээ |        |             |      |     |                 |      |
|------------|-----------|-----------------|--------|-------------|------|-----|-----------------|------|
| Аймаг      | Сум       | Бичил уурхайч   | Малчид | ЖДБ эрхлэгч | Ченж | ТББ | Нутгийн захирга | Нийт |
| Баянхонгор | Баян-Овоо | 8               | 3      | 2           | 1    | 1   | 2               | 33   |
|            | Бөмбөгөр  | 8               | 3      | 2           | 2    | 1   |                 |      |
| Говь-Алтай | Есөнбулаг | 8               | 3      | 2           | 2    | 1   | 2               | 33   |
|            | Бигэр     | 8               | 3      | 2           | 1    | 1   |                 |      |
| Дорноговь  | Айраг     | 16              | 6      | 4           | 1    | 1   | 2               | 32   |

|                 |           |           |           |           |           |           |           |            |
|-----------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|------------|
| Дундговь        | Хулд      | 8         | 3         | 2         | 1         | 1         | 2         | 33         |
|                 | Өлзийт    | 8         | 3         | 2         | 1         | 1         |           |            |
| Сэлэнгэ         | Мандал    | 6         | 2         | 1         | 1         | 1         | 2         | 34         |
|                 | Шарын гол | 5         | 2         | 2         | 1         | 1         |           |            |
|                 | Орхонтуул | 5         | 2         | 1         | 1         | 1         |           |            |
| Төв             | Заамар    | 8         | 3         | 2         | 2         | 1         | 2         | 33         |
|                 | Борнуур   | 8         | 3         | 2         | 1         | 1         |           |            |
| <b>Нийт дүн</b> |           | <b>96</b> | <b>36</b> | <b>24</b> | <b>15</b> | <b>12</b> | <b>12</b> | <b>195</b> |

Доор дурдсан арга зүйг ашиглан судалгаанд хамрагдагчдыг сонгон авсан:

- Бичил уурхай эрхлэгчдийг тухайн үйл ажиллагаа явуулж буй уурхай дээр буй хүмүүсээс санамсаргүй сонголтоор түүвэрлэсэн;
- Ярилцлагад хамрагдах малчдыг сонгохдоо, судлаачид нь уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газруудад хамгийн ойр амьдарч буй малчдыг сонгохоор хичээсэн;
- Ашигт малтмалын ченжийн хувьд орон нутгийн ТББ-уудын дэмжлэгтэйгээр холбоо барьж, ярилцлагад хамруулсан.
- Бизнес эрхлэгчдийн төлөөллийгуурхайн үйл ажиллагаа явагдаж буй газар дээрх эсвэл ойролцоох бизнес эрхлэгчдийн дундаас эсвэл тухайн газар дээрх сонгон авсан бизнес эрхлэгчидтэй шууд ярилцлага хийх замаар сонгон авсан. Хэрэв судлаачдын сонгосон тухайн уурхай дээр ямар нэгэн бизнес эрхлэгч байхгүй, үйл ажиллагаа явуулдаггүй бол тухайн газраас хамгийн ойр буй сумын төвийн бизнес эрхлэгчдийн дундаас сонголт хийсэн. Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчид нь үндсэндээ жижиг хэмжээний хүнсний дэлгүүр ажиллуулдаг иргэд байв.
- Сум нэг бүрээс гар аргаар ашигт малтмал олборлогчдын нэг ТББ-ыг сонгон судалгаанд хамруулсан. Тэдгээр ТББ-уудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Бичил уурхайчдын үндэсний дээвэр холбооноос авсан.
- Хамаарах албаны дарга нарт тухайн үйл ажиллагааны тухай тайлбар, шаардлагатай мэдээллийг гарган өгсөний дараагаар судалгаанд хамрагдах төрийн албан хаагчдыг сонгон авсан.

### 4.3 Ажлын хамрах хүрээ

Судалгааны ажлын хамрах хүрээнд доорх зүйлс багтсан:

- Бичил уурхай эрхлэгчдийн зүгээс эдийн засагт үзүүлж буй нөлөөг судлан үзэх баримт бичгийн судалгаа

- Үндсэн зорилтуудын сэдвийг хамарсан хагас бүтэцлэгдсэн ярилцлагыг боловсруулан гаргах
- Тогтвортой бичил уурхай төслийн тодорхойлсон 7 аймагт хийх судалгааны төлөвлөгөөг боловсруулах
- Судалгааны үр дүнг тоймлон харуулсан тайланг Англи хэл дээр бэлтгэх
- Судалгааны үр дүнг Тогтвортой бичил уурхай төслийн ажилтнуудын оролцох семинар дээр танилцуулах

#### 4.4 Мэдээллийн дүн шинжилгээ


##### Эдийн засгийн нөлөөлөл

Бичил болон гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас үзүүлж буй эдийн засгийн нөлөөллийг үнэлэхийн тулд IRIM судалгааны хүрээлэн нь шууд, шууд бус болон дам нөлөөллийг тус тусад нь тоон хэлбэрээр тооцон гаргасан бөгөөд эдгээрийг доорх байдлаар тодорхойлсон:

- **Шууд нөлөөлөл** – Орон нутгийн захиргааны төвлөрүүлсэн орлого, бичил уурхай эрхлэгчид, ченжийн хийж буй худалдан авалт, ажилтнуудад төлж буй цалин хөлс болон нийтэд хандсан үйл ажиллагаанд зарцуулж буй бусад зардлын нийлбэр;
- **Шууд бус нөлөөлөл** – Бичил уурхай эрхлэгчид, ченжтэй хийж буй бизнесийн үйл ажиллагааныхаа үр дүнд ханган нийлүүлэгчдийн төлж буй татвар болон бий болгож буй ажлын байр (жижиг дунд бизнес эрхлэгчид болон малчид);
- **Дам нөлөөлөл** – Ажилтнууд, ханган нийлүүлэгч нар болон бусад талуудын зүгээс өөрийн орлогоос зарцуулах замаар орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр, бичил уурхай эрхлэгчид, ченж болон тэдний ханган нийлүүлэгч нарын татварын мөнгөөр хийж буй төрийн худалдан авалт.

Гар аргаар ашигт малтмал олборлох салбарт эдгээр нөлөөллийг үүсгэж буй үйл ажиллагааны төрлүүдийг **Error! Reference source not found.** дээр тоймлон харууллаа.

## Дүрс 1. Мэдээлэл боловсруулах арга зүй



### Нэмэлт мэдээлэл

Дээр дурдсан тооцон гаргасан нөлөөллөөс гадна IRIM судалгааны хүрээлэн нь мөнгөн утгыг тухайн нөхцөл байдалд хөрвүүлэх зорилгоор доор дурдсан нэмэлт мэдээллүүдийг цуглуулсан, ашигласан:

- Шууд нөлөөлөл
  - Албан болон албан бус уурхайчдын тоо;
  - Бичил уурхай эрхлэгчдийн жендэрийн харьцаа;
  - Бичил уурхай эрхлэгчид, ченжийн гэр бүлийн бусад гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал;
  - Ашигт малтмалын олборлолт болон борлуулалтын үйл ажиллагааны улирлын өөрчлөлт;
  - Бичил уурхайчдын мэдээлсэн ашигт малтмалын үнэ;
  - Ченжийн олж буй ахиуц ашиг;
  - Олон нийтийн үйл ажиллагаанд хийх хөрөнгө оруулалтын талаарх гурван талт гэрээний (бичил уурхай эрхлэгчид, ченж, ТББ-ууд) үр дүн;
- Шууд бус нөлөөлөл
  - Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн бий болгож буй хоёрдогч ажлын байрууд;

- Бизнесийн үйл ажиллагаа, бичил уурхай эрхлэгчидтэй хийх худалдааны улирлын өөрчлөлт;
  - Уул уурхайн үйл ажиллагаанаас хамаарсан орлогын өөрчлөлт;
  - Бичил уурхай эрхлэгчид бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа түлхүү хэрэглэдэг аргачлал (жишээ нь бэлэн мөнгө, зээл гэх мэт).
- Дам нөлөөлөл
    - Бичил уурхай эрхлэгчид, ченж болон малчдын өрхийн түвшний зарцуулалт;
    - Олон нийтэд зориулсан хөрөнгө зарцуулалт, улсын төсөв.

## 4.5 Судалгааны хязгаарлалтууд

Судалгаанд тулгарсан хязгаарлалтууд нь үндсэндээ судалгаанд хамрагдагсадын өгч буй мэдээлэл хомс байсантай холбоотой бөгөөд үүнд:

- Эдийн засгийн өсөлтийн хэмжээг “ДНБ (2014) – ДНБ (2013) = Эдийн засгийн өсөлт” гэсэн аргачлалаар тооцож болно. Хэдий энэхүү суурь судалгааны зорилго нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тооцох зорилготой ч доор дурдсан хоёр саад тотгорын улмаас судалгааны баг нь тухайн тооцооллыг хийж чадаагүй:
  - Нэгдүгээрт сумын статистик мэдээлэл болон төрийн байгууллагуудын аль ч эх үүсвэрт сумын түвшний ДНБ-ний тоон мэдээлэл байхгүй байсан<sup>2</sup>. Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь мэдээлэл байхгүйн улмаас бичил уурхай эрхлэгчид болон ченжийн бий болгож буй эдийн засгийн өсөлтийг тооцох боломжгүй болсон;
  - Хоёрдугаарт орон нутгийн эдийн засагт бичил уурхай эрхлэгчид, ченжийн үзүүлж буй хувь нэмрийг тооцохын тулд сумын түвшний ДНБ-ийг тооцоолсон дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай болсон. Гэвч тухайн дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй, бичил уурхай эрхлэгчид, ченжээс төвлөрүүлдэг бүх татварыг (татвар, нөөцийн төлбөр, нийгмийн даатгал болон төлбөр хураамж гэх мэт) татвар, статистик эсвэл бусад хариуцсан аль нэг төрийн байгууллага дээр тусгайлан бүртгээгүй байна.

<sup>2</sup>ДНБ-ийг сүүлийн жилүүдэд Үндэсний статистикийн газрын мэдээллийн дагуу зөвхөн аймгийн түвшинд л гаргаж байна.

Дээрх хоёр хүчин зүйлсийн улмаас судалгааны баг нь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн зүгээс орон нутгийн эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй хувь нэмрийг тооцож чадаагүй болно. Гэхдээ цаашид хийгдэх судалгаагаар мэдээлэл хангалттай байх тохиолдолд тухайн үзүүлж буй хувь нэмрийг нөхөн тооцох бүрэн боломжтой болно.

- Шаардлагатай түүврийн хэмжээ нь аймаг бүр дээр хамгийн багадаа 360<sup>3</sup> өрх байх ёстой ч, зардлын хязарлалтаас үүдэн энэхүү түүврийн хэмжээнд бүрэн хүрээгүй;
- Төрийн байгууллага, албан тушаалтан нь гар аргаар ашигт малтмал ашиглахтай холбоотой ямар нэгэн мэдээлэлгүй байна. Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь доорх төрлийн мэдээллийг цуглуулж чадаагүй:
  - Бичил уурхайчдын төлсөн нийгмийн болон эрүүл мэндийн даатгал;
  - Орон нутгийн захиргааны зүгээс бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой гаргасан зардлууд жишээ нь бичил уурхайчдын зөрчилдөөний үеэр хууль сахиулах эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх зэрэгт гарсан зардлуудын тухай мэдээлэл.
- ТББ-уудад төлсөн татварын тухай мэдээллийг баталгаажуулах боломжгүй байсан ба учир нь үүнийг батлах хэмжээний мэдээлэл орон нутгийн төрийн байгууллагууд дээр байгаагүй;
- Говь-Алтай амйгийн Бигэр суманд бичил уурхай эрхлэгчдийг удирдан, зохион байгуулалтаар хангадаг ТББ байхгүй. Тиймээс ТББ-аас авах зарим мэдээллийгдутуу авсан. Судалгааны баг нь хамаарах мэдээллийг бусад эх сурвалжаас жишээ нь төрийн байгууллагын ажилтнууд болон төрийн байгууллагуудаас цуглуулах оролдлого хийсэн ч тухайн байгууллага, албан тушаалтанд тэрхүү мэдээлэл байхгүй байв. Тиймээс зарим тооцоолол дээр Бигэр сумын тооцообагтаж ороогүй болно;
- Олон тооны бичил уурхайчид, ченж өөрсдийн өрхийн хэрэглээ, орлого зэрэг мэдээллийг гарган өгөхийг хүсэхгүй байсан;
- Ченжнар өөрсдийн ахиуц ашгийн хэмжээг мэдэгдэхийг хүсэхгүй байсан ч орон нутгийн ТББ-уудаас хоёрдогч мэдээллийг цуглуулан авсан;
- Судалгаанд хамрагдсан хүмүүс нь сар тутам олон нийтийн үйл ажиллагаанд хийдэг хөрөнгө оруулалтын талаар ямар нэгэн мэдээлэл гарган өгч чадаагүй. Тиймээс үүнийг нийт дүнгээр нь илэрхийлсэн.

<sup>3</sup> Үндсэндээ хамгийн бага түүвэрлэлтийн хэмжээ нь 360 байж статистикын хувьд хүчин төгөлдөр болно.

Орон нутагт ажилласан судлаачид нь хамаарах төрийн байгууллагын албан тушаалтнуудтай холбоо барих тал дээр олон сорилтуудтай тулгарсан. Судалгааны баг нь шаардлагатай бүхий л хүмүүстэй холбоо барьж чадсан ч IRIM судалгааны хүрээлэнгийн зүгээс цааш цаашдын үйл ажиллагаанд доор дурдсан зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай хэмээн үзэж байна:

- Орон нутаг дахь судалгааг Наадмын дараагийн долоо хоногт хийж гүйцэтгэсэн бөгөөд үүний улмаас олон тооны төрийн албан тушаалтнууд амралтаа авсан үе таарсан;
- Айраг, Шарын-Гол, Баян-Овоо сумд Наадмын дараа ойн баяраа тэмдэглэсэн тул төрийн албан хаагчид эзгүй, тэр ч байтугай баярын дараагийн долоо хоногт ч ажил дээрээ ирээгүй;
- Орон нутгийн төрийн байгууллагын албан тушаалтнууд нь Тогтвортой бичил уурхай төслийн талаар ихэнх тохиолдолд мэдээлэлгүй байсан.


#### 4.6 Ес зүйн журам

Судалгааг хийхдээ IRIM судалгааны хүрээлэн нь доор дурдсан ёс зүйн зарчмуудыг баримталсан болно:

1. **Оролцогчдын нууцлалыг хадгалах** –Судалгаандоролцогчдын хувийн мэдээлэл, нууцлал нь IRIM судалгааны хүрээлэнгээс гаргасан судлаачдад зориулсан гарын авлагад дурдагдсан байдаг. Түүнчлэн IRIM судалгааны хүрээлэнгийн бүх ажилтнууд нь Олон улсын социологын холбооны гишүүнчлэлтэй бөгөөд тухайн холбооны дүрэм журам, стандартын дагуу судалгааны ажлыг явуулдаг. Мөн IRIM судалгааны хүрээлэн нь Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан ажилладаг бөгөөд өөрийн олж авсан мэдээллийн нууцлалыг чандлан хадгалдаг.
2. **Оролцооны хандлага** –Судалгааны ажилтнууд хөдөө орон нутаг, хот суурин газруудын эмзэг бүлгийн хүн амтай ажиллаж буй тул тухайн орчны талаар мэдрэмжтэй байх, хүйс, орлого болон боломж зэргээс үл хамааран бүхий л хүмүүсийг хамруулах талаарх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.
3. **Эрх зүй, ёс зүйн зохицуулалт**- IRIM судалгааны хүрээлэнгийн үндсэн баг нь Олон улсын социологийн холбооны гишүүд бөгөөд (ISA, 2011 оноос хойш), өөрийн үйл ажиллагааг тус холбооны дүрэм журам, зарчимд нийцүүлэн явуулдаг. Судалгааны ёс зүй мөн судлаачийн сургалтын модульд чухал байр суурийг эзэлдэг сэдэв юм. Түүнчлэн IRIM судалгааны хүрээлэн нь Монгол улсын Статистикын тухай хууль болон бусад хууль журмыг даган мөрдөж, бүхий л хувийн мэдээллийг чандлан нууцалдаг.

## 5. ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД НӨЛӨӨ

Энэхүү судалгаанд IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй эдийн засгийн шууд нөлөөллийг тооцохдоо хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд бий болгож буй мөнгөн дүн (бичил уурхай эрхлэгчид, ченжийн цэвэр мөнгөн орлого), төлж буй татвар, төлбөр хураамж (орон нутгийн захиргааны төвлөрүүлж буй орлого), худалдан авалтын мөнгөн дүн (ашигт малтмал олборлох болон худалдаалах үйл ажиллагаанд хамаарах зардал) болон олон нийтийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын (бичил уурхайчид, ченжийн олон нийтийн үйл ажиллагаанд зарцуулж буй мөнгөн дүн) нийлбэр хэмээн тодорхойлон авч үзсэн. Эдгээр дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг доорх бүлэгт дэлгэрэнгүй үнэлсэн болно.



### 5.1 Хөдөлмөр эрхлэлт

Ерөнхийдөө хөдөлмөр эрхлэлтээс үүдэн гарч буй эдийн засгийн шууд нөлөөллийг гар аргаар ашигт малтмалолборлох салбарын бий болгосон ажлын байрны тоо болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зардлыг ашиглан тооцдог. Гэхдээ энэ нөхцөлд цалинтай холбоотой хоёр янзын зардал гарч буй бөгөөд учир нь бичил уурхайчид болон ченж нь бие даан хөдөлмөр эрхлэгч байдаг. Тиймээс энэхүү хэсэг дээр IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхай эрхлэгчид болон ченж нь өөрсдийн олж буй орлогыг ашиглан бий болгосон ажлын байрыг тооцон үзсэн. Энэхүү тооцоонд IRIM судалгааны хүрээлэн нь бичил

уурхайчид, худалдаачид хэдэн ажлын байр бий болгосон, тэд ашигт малтмалын олборлолтоос хэдий хэмжээний орлогыг сард олдог болох дээр түлхүү төвлөрөн судалсан.

### 5.1.1 Бичил уурхайчид, ченжийн бий болгож буй ажлын байрны тоо

Доор харуулсан Хүснэгт 4 дээр албан болон албан бус уурхайчдын жендэр болон тооны талаарх мэдээллийг тусган харуулсан бөгөөд энэ нь ТББ-ын өгсөн мэдээлэл дээр суурилсан. Нийтдээ 2,772 албан ёсны бичил уурхайчин, 5,073 албан бус бичил уурхайчин, 72 ченж зорилтот 12 суманд байна. Албан ёсны уурхайчдын ойролцоогоор 38% нь эмэгтэйчүүд байна. Мөн 72 ченж эдгээр 12 суманд ашигт малтмалын худалдаа эрхэлж байна.

Хүснэгт 4ТББ-ын мэдээлсэн бичил уурхайчин, ченжийн тоо

| Байршил    |           | Жендерийн харьцаа (эр/эм) | Албан ёсны уурхайчдын тоо | Албан бус уурхайчдын тоо | Нийт уурхайчид | Нийт ченж | Нийт уурхайчид, ченжүүд |
|------------|-----------|---------------------------|---------------------------|--------------------------|----------------|-----------|-------------------------|
| Аймаг      | Сум       |                           |                           |                          |                |           |                         |
| Баянхонгор | Баян-Овоо | 1.7                       | 550                       | 280                      | 830            | 2         | 832                     |
|            | Бөмбөгөр  | 1.1                       | 800                       | 1,300                    | 2100           | 12        | 2,112                   |
| Говь-Алтай | Есөнбулаг | 1.3                       | 120                       | 1,800                    | 1920           | 5         | 1,935                   |
|            | Бигэр     | NA                        | NA                        | NA                       | NA             | NA        | NA                      |
| Дорноговь  | Айраг     | 4.0                       | 125                       | 40                       | 165            | 4         | 169                     |
| Дундговь   | Хулд      | 2.1                       | 188                       | 300                      | 488            | 1         | 489                     |
|            | Өлзийт    | 0.8                       | 280                       | 108                      | 388            | 4         | 392                     |
| Сэлэнгэ    | Мандал    | 3.3                       | 130                       | 400                      | 530            | 4         | 534                     |
|            | Шарын гол | 2.3                       | 346                       | 500                      | 846            | 5         | 851                     |
|            | Орхонтуул | 4.5                       | 120                       | 180                      | 300            | 1         | 301                     |
| Төв        | Заамар    | -                         | 30                        | 100                      | 130            | 20        | 150                     |
|            | Борнуур   | 5.4                       | 83                        | 65                       | 148            | 4         | 152                     |
| Нийт дүн   |           |                           | 2,772                     | 5,073                    | 7845           | 72        | 7,917                   |

(а) ТББ-уудын эрэгтэй болон эмэгтэй гишүүдийн тоонд үндэслэсэн.

Нийтдээ 7,917 бичил уурхай эрхлэгч болон ченж буй хэмээн тооцсон бөгөөд эдгээр 12 сумдад нийт 7,947 ажлын байр бий болжээ. Аймаг бүр дээрх бичил уурхайчдын тоог хувьчлан харуулбал:

- Баянхонгор - 37%
- Говь-Алтай – 24%
- Сэлэнгэ – 21%
- Дундговь – 11%
- Төв – 3.5%


- Дорноговь – 2%

Судалгаанд хамрагдсан бичил уурхайчид дунджаар энэ чиглэлд 8 жил ажиллаж байгаа бол хамгийн олон жил ажилласан нь 21 жил, хамгийн цөөн жил ажилласан нь 1 жил байна. Судалгаанд хамрагдсан ченж нь тухайн салбартаа дунджаар 5 жил ажилласан бөгөөд хамгийн олон жил ажилласан нь 10 жил, хамгийн бага хугацаанд ажилласан нь 7 сар ажилласан байна.

Дунджаар бичил уурхайчин-өрхийн гишүүдийн 1.7 гишүүн нь ажил эрхэлдэг бөгөөд ченж-өрхийн 2 гишүүн нь ажил эрхлэж байна.

Зураг 2 дээр судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын гэр бүлийн бусад гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харууллаа.

Дүрс 2 Уурхайчдын өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал (96 өрхийн мэдээлэл)




Зураг 3 дээр судалгаанд хамрагдсан ченжийн гэр бүлийн бусад гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харуулав.

Дүрс 3 Ченж нарын өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийн байдал



Зураг 4 нь бичил уурхайчин өрхийн бусад гишүүд ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хэр хэмжээнд оролцож буйг тусгасан. Өрхийн гишүүдийн зүгээс бичил уурхайн ажилд оролцох гол оролцоо нь үндсэндээ гэр бүлийн гишүүддээ туслах байдлаар илэрч байна. Судалгаанд хамрагдсан бүх бичил уурхайчдын 56% нь гэр бүлийнх нь гишүүд үйл ажиллагаан идэвхтэй оролцдог хэмээн мэдүүлсэн (удирдах, хамтдаа ажиллах, туслах гэх мэтээр). Түүнчлэн бичил уурхайчдын гуравны нэг нь гэр бүлийнх нь гишүүд ажилд нь огт оролцдоггүй хэмээн хэлжээ.


Дүрс 4 Бичил уурхайчдын өрхийн гишүүдийн олборлолтонд оролцох хэлбэрүүдийг хувиар харуулав




Доор буй хоёр зураг дээр (5, 6) бичил уурхайчид болон ченжийн үзсэнээр ашигт малтмал олборлох үйл ажиллагааны мөчлөгийг харуулсан байна.

Ашигт малтмал олборлох үйл ажиллагаа нь улирлаас маш өндөр хамааралтай байдаг. Бичил уурхай эрхлэгчид болон ченж нар уул уурхайн үйл ажиллагааны мөчлөгийг үнэлсэнээс үзвэл ашигт малтмал олборлох үндсэн үйл ажиллагаа нь хавар эхэлж, намар удаашран, өвөл бүр мөсөн зогсдог байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 11% нь ашигт малтмал олборлох үйл ажиллагаа өвлийн улиралд нэмэгддэг гэсэн нь тэд зун өөр бусдажил эрхэлдэг (хөдөө аж ахуй гэх мэт) тул завгүй байдагтай холбоотой байна. Тиймээс тэдний хувьд хөдөө аж ахуйн чиглэлийн ажил зогсдог өвлийн улирал хамгийн тохиромжтой байдаг ажээ. Үүнийтэй ижил төстэй логик ченж дээр мөн харагдаж байна (Зураг 5, 6).

Дүрс 5 Улирлын чанартай бичил уурхайн олборлолтын өөрчлөлтүүд



Дүрс 6 Улирлын чанартай ченжийн үйл ажиллагааны өөрчлөлтүүд



Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын 30% нь ашигт малтмал олборлох болон өөр бусад хоёрдогч ажилтай байдаг ажээ.

Ашигт малтмал олборлох үйл ажиллагаа удаашрах эсвэл зогсолт хийхэд нийт бичил уурхай эрхлэгчдийн тал орчим хувь нь ямар нэг ажил хийдэггүй, 37% нь хувийн жижиг бизнесээ эрхэлдэг, 6% нь малаа хариулдаг, 4% нь өөр газар шилжин ажилладаг бол үлдэх хэсэг нь төр, хувийн байгууллагуудад ажил эрхэлдэг байна. Харин ченжийн хувьд ашигт малтмал олборлох үйл ажиллагаа хязгаарлагдмал эсвэл зогссон үед 69% нь хувийн жижиг бизнес эрхэлдэг, 23% нь огт ажил хийдэггүй бол үлдэх хэсэг нь малаа малладаг байна.

Ихэнх бичил уурхай эрхлэгч нар бусадтай хамтран, нөхөрлөл болж ажилладаг байна. Нийт бичил уурхайчдын 70 орчим хувь нь 5 хүртэлх тооны бусад бичил уурхайчидтай хамтран ажилладаг байна. Нэг тохиолдолд нийт 62 бичил уурхай эрхлэгч хамтран ашигт малтмалын олборлолт хийж байв. Эдний дунд олсон орлогоо тэгш хуваах нь хамгийн түгээмэл байна.

### 5.1.1 Бичил уурхайн үйл ажиллагаанаас олох орлого

#### Бичил уурхайчдын орлого

IRIM судалгааны хүрээлэн нь ТББ-уудаас цуглуулсан мэдээлэл дээр суурилан бичил уурхайн үйл ажиллагаанаас олж буй нийт орлогыг ойролцоогоор тооцон гаргасан. IRIM судалгааны хүрээлэнгийн үзэж буйгаар аль нэг суманд үйл ажиллагаа явуулж буй бичил уурхайчин нь тухайн суманд үйл ажиллагаа явуулж буй бусад уурхайчдын дундажтай ойролцоо хэмжээний орлогыг олдог байна.

Хүснэгт 5 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (ТББ-ын өгсөн тооны хувьд)

| Байршил    |           | Дундаж бичил уурхайн орлого (төгрөг/сар) <sup>(a)</sup> | Бичил уурхайчдын тоо <sup>(b)</sup> | Нийт орлого (мянган төгрөг/сар) <sup>(c)</sup> | Нийт татвар, хураамж (мянган төгрөг/сар) | Нийт цэвэр ашиг (мянган төгрөг/сар) <sup>(d)</sup> |
|------------|-----------|---------------------------------------------------------|-------------------------------------|------------------------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------|
| Аймаг      | Сум       |                                                         |                                     |                                                |                                          |                                                    |
| Баянхонгор | Баян-Овоо | 300,000                                                 | 830                                 | 249,000                                        | 1,367.6                                  | 247,632.4                                          |
|            | Бөмбөгөр  | 200,000                                                 | 2,100                               | 420,000                                        | 2,259.8                                  | 417,740.2                                          |
| Говь-Алтай | Есөнбулаг | 450,000                                                 | 1,920                               | 864,000                                        | 2,157.1                                  | 861,842.8                                          |
| Дорноговь  | Айраг     | 650,000                                                 | 165                                 | 107,250                                        | 500                                      | 106,750                                            |
| Дундговь   | Хулд      | 800,000                                                 | 488                                 | 390,400                                        | 1,936                                    | 388,463.9                                          |
|            | Өлзийт    | 900,000                                                 | 388                                 | 349,200                                        | 8,222.8                                  | 340,977.2                                          |
| Сэлэнгэ    | Мандал    | 300,000                                                 | 530                                 | 159,000                                        | 207.1                                    | 158,792.9                                          |
|            | Шарын гол | 250,000                                                 | 846                                 | 211,500                                        | 3,469.4                                  | 208,030.6                                          |
|            | Орхонтуул | 400,000                                                 | 300                                 | 120,000                                        | 1,382.4                                  | 118,617.6                                          |
| Төв        | Заамар    | 800,000                                                 | 130                                 | 104,000                                        | 355.6                                    | 103,644.3                                          |
|            | Борнуур   | 300,000                                                 | 148                                 | 44,400                                         | 213                                      | 44,187                                             |
| Нийт дүн   |           | 5,350,000                                               | 7,845                               | 3,018,750                                      | 22,070.9                                 | 2,996,679                                          |

(a) Бичил уурхайчдын сарын дундаж орлогыг ТББ-ын мэдээлэл дээр үндэслэн бодсон

(b) Албан болон албан бус уурхайчдыг хамт тооцон бодсон

(c) Бичил уурхайчдын тоо болон сарын дундаж орлогыг ТББ-ын мэдээлэл дээр үндэслэн бодсон

(d) Нийт цэвэр ашгийг нийт орлогоос нийт татвар хураамжийг хасаж тооцсон

ТББ-уудын гарган өгсөн мэдээллээс үзвэл эдгээр 12 сумын бичил уурхайчид нь сард ойролцоогоор татварын дараах хэмжээгээр 3 сая орчим төгрөгийн орлоготой байдаг (Хүснэгт 5-ыг үзнэ үү) ба үүнээс албан ёсны бичил уурхайчид 1 сая орчим, албан бус уурхайчид 1.9 сая орчим төгрөгийн орлого (сард) олдог байна. Доорх хүснэгт дээр (Хүснэгт

б) судалгаанд хамрагдсан хүмүүсийн өгсөн мэдээлэлд үндэслэн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас олдог дундаж орлогыг харууллаа.

**Хүснэгт 6 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (нийт уурхайчдын хувьд)**

| Байршил         |           | Дундаж бичил уурхайн орлого (төгрөг/сар) <sup>(a)</sup> | Бичил уурхайчдын тоо <sup>(b)</sup> | Нийт орлого (мянган төгрөг/сар) <sup>(c)</sup> | Нийт татвар, хураамж (мянган төгрөг/сар) | Нийт цэвэр ашиг (мянган төгрөг/сар) <sup>(d)</sup> |
|-----------------|-----------|---------------------------------------------------------|-------------------------------------|------------------------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------|
| Аймаг           | Сум       |                                                         |                                     |                                                |                                          |                                                    |
| Баянхонгор      | Баян-Овоо | 395,125                                                 | 830                                 | 327,953.7                                      | 1,367.60                                 | 327,952.3                                          |
|                 | Бөмбөгөр  | 490,286                                                 | 2,100                               | 1,029,600.6                                    | 2,259.80                                 | 1,029,598.3                                        |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 328,000                                                 | 1,920                               | 629,760                                        | 2,157.10                                 | 629,757.8                                          |
| Дорноговь       | Айраг     | 701,674                                                 | 165                                 | 115,776.2                                      | 500                                      | 115,775.7                                          |
| Дундговь        | Хулд      | 1,185,913                                               | 488                                 | 578,725.5                                      | 1,936                                    | 578,723.6                                          |
|                 | Өлзийт    | 587,363                                                 | 388                                 | 227,896.8                                      | 8,222.80                                 | 227,888.6                                          |
| Сэлэнгэ         | Мандал    | 219,083                                                 | 530                                 | 116,113.9                                      | 207.1                                    | 116,113.7                                          |
|                 | Шарын гол | 512,000                                                 | 846                                 | 433,152                                        | 3,469.40                                 | 433,148.5                                          |
|                 | Орхонтуул | 393,480                                                 | 300                                 | 118,044                                        | 1,382.40                                 | 118,042.6                                          |
| Төв             | Заамар    | 366,750                                                 | 130                                 | 47,677.5                                       | 355.6                                    | 47,677.1                                           |
|                 | Борнуур   | 338,250                                                 | 148                                 | 50,061                                         | 213                                      | 50,060.7                                           |
| <b>Нийт дүн</b> |           | <b>501,629</b>                                          | <b>7,845</b>                        | <b>3,674,761.4</b>                             | <b>22,070.9</b>                          | <b>3,674,739.4</b>                                 |

(a) Бичил уурхайчдын сарын дундаж орлогыг ТББ-ын мэдээлэл дээр үндэслэн бодсон

(b) Албан болон албан бус уурхайчдыг хамт тооцон бодсон

(c) Бичил уурхайчдын тоо болон сарын дундаж орлогыг ТББ-ын мэдээлэл дээр үндэслэн бодсон

(d) Нийт цэвэр ашгийг нийт орлогоос нийт татвар хураамжийг хасаж тооцсон

Бичил уурхайчдын өгсөн мэдээллээс үзвэл тухайн зорилтот 12 сумын бичил уурхай эрхлэгч нь сард татварын дараах байдлаар ойролцоогоор 3.6 сая төгрөгийн орлогыг олдог ажээ. ТББ-уудын өгсөн мэдээлэл дээр үндэслэн гаргасан цэвэр орлого нь бичил уурхайчдын цэвэр орлогыг багаар тооцсон байна.

Түүнчлэн IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхайчдын өгсөн мэдээлэл болон ТББ-уудын өгсөн мэдээлэл зөрүүтэй буйг тогтоосон. Доорх Хүснэгт 7 дээр судалгаанд хамрагдагсадын (бичил уурхайчдын) өгсөн орлогын тухай мэдээлэл нь Заамар суманд ТББ-ын өгсөн мэдээллээс 46% бага, Бөмбөгөр сумын ТББ-ын өгсөн мэдээллээс 245% их буйг харуулж байна.

**Хүснэгт 7 Нийт болон ТББ-ын өгсөн уурхайчдын сарын дундаж орлогын зөрүү**

| Байршил    |           | ТББ-ын өгсөн уурхайчдын сарын дундаж орлого (төгрөг/сар) | Нийт уурхайчдын сарын дундаж орлого (төгрөг/сар) | Нийт уурхайчин / ТББ-ын мэдээлэл (%) |
|------------|-----------|----------------------------------------------------------|--------------------------------------------------|--------------------------------------|
| Аймаг      | Сум       |                                                          |                                                  |                                      |
| Баянхонгор | Баян-Овоо | 300,000                                                  | 395,125                                          | 132                                  |
|            | Бөмбөгөр  | 200,000                                                  | 490,286                                          | 245                                  |
| Говь-Алтай | Есөнбулаг | 450,000                                                  | 328,000                                          | 73                                   |

|           |           |         |           |     |
|-----------|-----------|---------|-----------|-----|
| Дорноговь | Айраг     | 650,000 | 701,674   | 108 |
| Дундговь  | Хулд      | 800,000 | 1,185,913 | 148 |
|           | Өлзийт    | 900,000 | 587,363   | 65  |
| Сэлэнгэ   | Мандал    | 300,000 | 219,083   | 73  |
|           | Шарын гол | 250,000 | 512,000   | 205 |
|           | Орхонтуул | 400,000 | 393,480   | 98  |
| Төв       | Заамар    | 800,000 | 366,750   | 46  |
|           | Борнуур   | 300,000 | 338,250   | 113 |

Доор үзүүлсэн Хүснэгт 8 нь нийт орлого болон судалгаанд хамрагдсан ашигт малтмалын олборлолт эрхлэдэг өрхүүдийн олборлолтын үйл ажиллагаанаас олсон орлогыг харуулсан. IRIM судалгааны хүрээлэн нь судалгаанд хамрагдсан 96 өрх нь ойролцоогоор сард 46.5 сая төгрөгийн орлого олж буйг тогтоосон.

**Хүснэгт 8 Бичил уурхайчдын олборлолтоос олсон орлого (судалгаанд хамрагсадын түвшинд)**

| Байршил     |           | Олборлолтоос олсон өрхийн дундаж орлого (төгрөг/сар) | Өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) | Олборлолтоос олсон өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Олборлолтоос олсон өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) |
|-------------|-----------|------------------------------------------------------|---------------------------------|----------------------------------|----------------------------------------------------|-----------------------------------------------------|
| Аймаг       | Сум       |                                                      |                                 |                                  |                                                    |                                                     |
| Баянхонгор  | Баян-Овоо | 395,125                                              | 3,662,000                       | 3,395,940                        | 3,161,000                                          | 2,936,611                                           |
|             | Бөмбөгөр  | 490,286                                              | 6,820,000                       | 6,700,080                        | 3,432,000                                          | 3,357,964                                           |
| Говь-Алтай  | Есөнбулаг | 328,000                                              | 3,100,000                       | 2,492,099                        | 1,640,000                                          | 1,085,213                                           |
|             | Бигэр     | 316,364                                              | 5,760,000                       | 6,124,000                        | 3,480,000                                          | 3,886,480                                           |
| Дорноговь   | Айраг     | 701,674                                              | 15,486,000                      | 15,230,151                       | 11,226,790                                         | 11,058,223                                          |
| Дундговь    | Хулд      | 1,185,913                                            | 12,682,000                      | 11,942,720                       | 9,487,300                                          | 8,979,211                                           |
|             | Өлзийт    | 587,363                                              | 7,546,000                       | 6,695,187                        | 4,698,900                                          | 4,143,323                                           |
| Сэлэнгэ     | Мандал    | 219,083                                              | 3,290,000                       | 3,258,530                        | 1,314,500                                          | 1,291,124                                           |
|             | Шарын гол | 512,000                                              | 3,800,000                       | 3,694,594                        | 2,560,000                                          | 2,472,719                                           |
|             | Орхонтуул | 393,480                                              | 3,412,000                       | 3,327,870                        | 1,967,400                                          | 1,903,856                                           |
| Төв         | Заамар    | 366,750                                              | 4,630,000                       | 4,454,095                        | 2,934,000                                          | 2,848,484                                           |
|             | Борнуур   | 338,250                                              | 3,790,000                       | 3,656,170                        | 2,706,000                                          | 2,590,170                                           |
| <b>Нийт</b> |           | <b>501,629</b>                                       | <b>73,978,000</b>               | <b>70,971,436</b>                | <b>48,607,890</b>                                  | <b>46,553,378</b>                                   |

Энэхүү олж буй орлогоос хэдий хэмжээний мөнгө орон нутгийн эдийн засагт шингэн үлдэж буйг тодорхойлох зайлшгүй шаардлагатай юм. Судалгаанд хамрагдсан бүх бичил уурхайчдын 81% нь тухайн орон нутгийн иргэд байна. Тиймээс сард ойролцоогоор 37.7 сая төгрөг орон нутагт үлдэж байна хэмээн үзэж болно.

Хүснэгт 9 нь бичил уурхайчдын өгсөн хариулт дээр үндэслэн ашигт малтмалын олборлолт болон бүтээгдэхүүний үнийг тоймлон харуулсан. Ашигт малтмалын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хувьд судалгаанд хамрагдсан бичил уурхайчид нь сард 74.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Ашигт малтмалын нийт үйлдвэрлэлийн хэмжээ нь өрхүүдийн татварын өмнөх орлогын хэмжээтэй ижил тэнцүү байна. Ашигт малтмалын үйлдвэрлэлийн

дундаж үнийн дүн нь 794,518 төгрөг, алтны зах зээлийн дундаж үнэ нь эдгээр сумдад грамм нь 61,691 төгрөг байна.

Сар тутмын ашигт малтмалын олборлолтын хэмжээ нь Орхонтуул, Заамар болон Хулд сумдад бусад сумдаас өндөр байсаны зэрэгцээ жонш олборлолт явагддаг Айраг болон Хулд сумдад бүтээгдэхүүний үнэ нь өндөр байна.

**Хүснэгт 9 Бичил уурхайн олборлолт, ашигт малтмалын үнэ (судалгаанд хамрагсадын түвшинд)**

| Байршил         |           | Нийт бичил уурхайн олборлолт (төгрөг/сар) | Дундаж бичил уурхайн олборлолт (төгрөг/сар) | Дундаж ашигт малтмалын үнэ (төгрөг/грам) |
|-----------------|-----------|-------------------------------------------|---------------------------------------------|------------------------------------------|
| Аймаг           | Сум       |                                           |                                             |                                          |
| Баянхонгор      | Баян-Овоо | 2,860,000                                 | 357,500                                     | 56,133                                   |
|                 | Бөмбөгөр  | 6,380,000                                 | 797,500                                     | 56,000                                   |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 3,060,000                                 | 655,000                                     | 60,330                                   |
|                 | Бигэр     | 5,390,000                                 | 485,800                                     | 55,000                                   |
| Дорноговь       | Айраг     | 15,220,000                                | 951,250                                     | 101,818                                  |
| Дундговь        | Хулд      | 9,854,000                                 | 1,231,750                                   | 83,571                                   |
|                 | Өлзийт    | 5,628,000                                 | 703,500                                     | 49,375                                   |
| Сэлэнгэ         | Мандал    | 2,740,000                                 | 456,666                                     | 56,500                                   |
|                 | Шарын гол | 4,100,000                                 | 820,000                                     | 60,480                                   |
|                 | Орхонтуул | 8,170,000                                 | 1,634,000                                   | 53,333                                   |
| Төв             | Заамар    | 7,530,000                                 | 941,250                                     | 53,000                                   |
|                 | Борнуур   | 4,000,000                                 | 500,000                                     | 54,750                                   |
| <b>Нийт дүн</b> |           | <b>74,932,000</b>                         | <b>794,518</b>                              | <b>61,691</b>                            |

Мэдээллийн эх үүсвэр: Бичил уурхайчтай хийсэн хагас бүтэцлэгдсэн ярилцлага

Судалгааны мэдээллээс үзвэл бичил уурхай эрхлэгчдийн 56% нь өөрсдийн бүтээгдэхүүнийг ченж борлуулдаг бол 20% нь жижиглэн худалдааны дэлгүүрүүдэд, 18% нь компаниудад, үлдэх хувь нь (6%) нь бусад жижиг хэмжээний уурхай эрхлэгчдэд борлуулдаг байна.

**Ченжийн орлого**

Ченжийн (нийт 15 хүн) дунд хийсэн судалгаагаар тэдгээр хүмүүс нь ойролцоогоор 13.7 сая төгрөгийн орлогыг сард олдог байна (татварын дараах байдлаар). Хүснэгт 10 дээр судалгаанд хамрагдсан ченжийн нийт болон цэвэр орлогыг тоймлон харууллаа.

**Хүснэгт 10 Ченж нарын ашигт малтмалын худалдаанаас олсон орлого - Судалгаанд хамрагсадын түвшинд**

| Байршил    |           | Өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) | Ашигт малтмалын худалдаанаас олсон өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Ашигт малтмалын худалдаанаас олсон өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) |
|------------|-----------|---------------------------------|----------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| Аймаг      | Сум       |                                 |                                  |                                                                    |                                                                     |
| Баянхонгор | Баян-Овоо | 1,100,000                       | 1,100,000                        | 110,000                                                            | 110,000                                                             |

| Байршил    |           | Өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) | Ашигт малтмалын худалдаанаас олсон өрхийн нийт орлого (төгрөг/сар) | Ашигт малтмалын худалдаанаас олсон өрхийн цэвэр орлого (төгрөг/сар) |
|------------|-----------|---------------------------------|----------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------|
| Аймаг      | Сум       |                                 |                                  |                                                                    |                                                                     |
|            | Бөмбөгөр  | 2,200,000                       | 2,157,025                        | 1,144,000                                                          | 1,139,235                                                           |
| Говь-Алтай | Есөнбулаг | 2,600,000                       | 2,503,365                        | 1,520,000                                                          | 1,464,689                                                           |
|            | Бигэр     | 600,000                         | 599,333                          | 600,000                                                            | 599,333                                                             |
| Дорноговь  | Айраг     | 1,500,000                       | 1,252,333                        | 1,050,000                                                          | 876,634                                                             |
| Дундговь   | Хулд      | 2,000,000                       | 1,224,960                        | 200,000                                                            | 122,496                                                             |
|            | Өлзийт    | 407,000                         | 367,455                          | 219,780                                                            | 198,426                                                             |
| Сэлэнгэ    | Мандал    | 1,200,000                       | 1,186,549                        | 1,200,000                                                          | 1,186,549                                                           |
|            | Шарын гол | 1,500,000                       | 1,499,170                        | 1,500,000                                                          | 1,499,170                                                           |
|            | Орхонтуул | 650,000                         | 609,600                          | 650,000                                                            | 609,600                                                             |
| Төв        | Заамар    | 4,900,000                       | 4,895,846                        | 4,900,000                                                          | 4,895,846                                                           |
|            | Борнуур   | 1,000,000                       | 1,000,000                        | 1,000,000                                                          | 1,000,000                                                           |
| Нийт       |           | 19,657,000                      | 18,395,636                       | 14,093,780                                                         | 13,701,978                                                          |

Судалгаанд хамрагдсан ченжийн 80% нь орон нутгийн иргэд байсан тул ашигт малтмалын бүтээгдэхүүний худалдаанаас ойролцоогоор 11 сая төгрөг сар тутам **орон нутгийн эдийн засагт** шингэн үлдэж байна хэмээн үзэж болно..

IRIM судалгааны хүрээлэн нь сумддахь ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас ченжийн олж буй цэвэр орлогыг ойролцоогоор тооцсон ба энэхүү тооцоонд ченжийн сар тутмын дундаж цэвэр орлогыг суурь болгон авсан. Хүрээлэнгийн үзэж буйгаар суман дахь ченж нэг бүр нь сумд дахь дундаж орлоготой ижил хэмжээний орлогыг сар тутамд олж байна.


Хүснэгт 11 Ченж нарын ашигт малтмалын худалдаанаас олсон орлого –Сумын түвшинд

| Байршил    |           | Ашигт малтмалын худалдаанаас олсон цэвэр дундаж орлого (төгрөг/сар) | Нийт ченж нарын тоо | Нийт цэвэр орлого (мянган төгрөг/сар) |
|------------|-----------|---------------------------------------------------------------------|---------------------|---------------------------------------|
| Аймаг      | Сум       |                                                                     |                     |                                       |
| Баянхонгор | Баян-Овоо | 110,000                                                             | 2                   | 220,000                               |
|            | Бөмбөгөр  | 569,618                                                             | 12                  | 6,835,410                             |
| Говь-Алтай | Есөнбулаг | 732,345                                                             | 5                   | 3,661,723                             |
|            | Бигэр     | 599,333                                                             | NA                  | NA                                    |
| Дорноговь  | Айраг     | 876,634                                                             | 4                   | 3,506,536                             |
| Дундговь   | Хулд      | 122,496                                                             | 1                   | 122,496                               |
|            | Өлзийт    | 198,426                                                             | 4                   | 793,704                               |
| Сэлэнгэ    | Мандал    | 1,186,549                                                           | 4                   | 4,746,196                             |
|            | Шарын гол | 1,499,170                                                           | 5                   | 7,495,850                             |

|             |           |                |           |                   |
|-------------|-----------|----------------|-----------|-------------------|
|             | Орхонтуул | 609,600        | 1         | 609,600           |
| Төв         | Заамар    | 2,447,923      | 20        | 48,958,460        |
|             | Борнуур   | 1,000,000      | 4         | 4,000,000         |
| <b>Нийт</b> |           | <b>829,341</b> | <b>72</b> | <b>80,949,975</b> |


Ашигт малтмалын бүтээгдэхүүний худалдааны ахиуц ашиг нь сум бүр дээр өөр байна. Хамгийн дээд хэмжээний ахиуц ашиг нь Өлзийт суманд нэг грамм алт тутмаас 13,000 төгрөг байсан ба хамгийн бага хэмжээний ахиуц ашиг нь Заамар суманд грамм тутамд ойролцоогоор 267 төгрөг байв. Зураг 7 нь ашигт малтмалын худалдааны ахиуц ашгийг харуулсан.

Дүрс 7 Ашигт малтмалын худалдааны ахиуц ашиг- ченж нарын мэдээлэл



Зураг 8 дээр бичил уурхайчид болон ченжийн сар тутмын дундаж орлогыг харьцуулан харуулсан ба 12 сумын 11 дээр ченжийн сар тутмын дундаж орлого нь бичил уурхай эрхлэгчдээс илүү өндөр буйг харуулжээ. Сар тутмын орлогод гарч буй энэхүү ялгаа нь Заамар, Мандал, Есөнбулаг сумуудад хамгийн өндөр байна. Ялангуяа Заамар суманд бичил уурхайчдын сарын дундаж орлогоос ойролцоогоор 7 дахин өндөр байна. Гэхдээ Өлзийт сумын бичил уурхайчдын дундаж орлого нь ченжийн сарын дундаж орлогоос өндөр байна.

Дүрс 8 Бичил уурхайчид болон ченж нарын дундаж орлогын харьцаа



Хүснэгт 11 дээр байршил нэг бүр дээрх бичил уурхай эрхлэгчид, ченжийн нийт орлоготой холбоотой өмнө харуулсан мэдээллийг тоймлон оруулсан. Мөн үүнд бичил уурхайчид, ченжийн цэвэр орлогын дүнг багтаан оруулсан.

### Ченж болон уурхайчдын уул уурхайн үйл ажиллагааны нийт орлого

Судалгаанд хамрагдсан ченж болон уурхайчдын (96 уурхайчин, 15 ченж) уул уурхайн үйл ажиллагааны нийт орлого нь сард 60.2 сая төгрөг байсан (Хүснэгт 12). Энэхүү утга нь эдгээр 12 сумд дахь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн шууд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлж буй хувь нэмэр байв.

Хүснэгт 12 Бичил уурхайчид болон ченж нарын бичил уурхайн нийт цэвэр орлого - судалгаанд хамрагсадын түвшинд

| Байршил    |           | Бичил уурхайчдын сарын орлого (төгрөг) | Ченж нарын сарын орлого (төгрөг) | Сарын нийт орлого (төгрөг) |
|------------|-----------|----------------------------------------|----------------------------------|----------------------------|
| Аймаг      | Сум       |                                        |                                  |                            |
| Баянхонгор | Баян-Овоо | 2,936,611                              | 110,000                          | 3,046,611                  |
|            | Бөмбөгөр  | 3,357,964                              | 1,139,235                        | 4,497,199                  |
| Говь-Алтай | Есөнбулаг | 1,085,213                              | 1,464,689                        | 2,549,902                  |
|            | Бигэр     | 3,886,480                              | 599,333                          | 4,485,813                  |
| Дорноговь  | Айраг     | 11,058,223                             | 876,634                          | 11,934,857                 |
| Дундговь   | Хулд      | 8,979,211                              | 122,496                          | 9,101,707                  |
|            | Өлзийт    | 4,143,323                              | 198,426                          | 4,341,749                  |
| Сэлэнгэ    | Мандал    | 1,291,124                              | 1,186,549                        | 2,477,673                  |
|            | Шарын гол | 2,472,719                              | 1,499,170                        | 3,971,889                  |
|            | Орхонтуул | 1,903,856                              | 609,600                          | 2,513,456                  |

|                 |         |                   |                   |                   |
|-----------------|---------|-------------------|-------------------|-------------------|
| Төв             | Заамар  | 2,848,484         | 4,895,846         | 7,744,330         |
|                 | Борнуур | 2,590,170         | 1,000,000         | 3,590,170         |
| <b>Нийт дүн</b> |         | <b>46,553,378</b> | <b>13,701,978</b> | <b>60,255,356</b> |

Судалгаанд хамрагдсан ченж болон бичил уурхай эрхлэгчдийн нийт орлого нь (7,845 бичил уурхайчин, 72 ченж) сард 3 тэрбум болж буйг Хүснэгт 13 дээр харуулсан. Энэхүү утга нь эдгээр 11 сумын бичил уурхайчид, ченжийн шууд хөдөлмөр эрхлэлтийг бий болгосноос үүдэн гарч буй хувь нэмэр юм.

**Хүснэгт 13 Бичил уурхайчид болон ченж нарын бичил уурхайн нийт цэвэр орлого - сумын түвшинд**

| <b>Байршил</b>  |            | <b>Бичил уурхайчдын сарын орлого (төгрөг)</b> | <b>Ченж нарын сарын орлого (төгрөг)</b> | <b>Сарын нийт орлого (төгрөг)</b> |
|-----------------|------------|-----------------------------------------------|-----------------------------------------|-----------------------------------|
| <b>Аймаг</b>    | <b>Сум</b> |                                               |                                         |                                   |
| Баянхонгор      | Баян-Овоо  | 247,632,400                                   | 220,000                                 | 247,852,400                       |
|                 | Бөмбөгөр   | 417,740,200                                   | 6,835,410                               | 424,575,610                       |
| Говь-Алтай      | Есөнбулаг  | 861,842,800                                   | 3,661,723                               | 865,504,523                       |
|                 | Бигэр      | NA                                            | NA                                      | Na                                |
| Дорноговь       | Айраг      | 106,750,000                                   | 3,506,536                               | 110,256,536                       |
| Дундговь        | Хулд       | 388,463,900                                   | 122,496                                 | 388,586,396                       |
|                 | Өлзийт     | 340,977,200                                   | 793,704                                 | 341,770,904                       |
| Сэлэнгэ         | Мандал     | 158,792,900                                   | 4,746,196                               | 163,539,096                       |
|                 | Шарын гол  | 208,030,600                                   | 7,495,850                               | 215,526,450                       |
|                 | Орхонтуул  | 118,617,600                                   | 609,600                                 | 119,227,200                       |
| Төв             | Заамар     | 103,644,300                                   | 48,958,460                              | 152,602,760                       |
|                 | Борнуур    | 44,187,000                                    | 4,000,000                               | 48,187,000                        |
| <b>Нийт дүн</b> |            | <b>2,996,679,000</b>                          | <b>80,949,975</b>                       | <b>3,077,629,000</b>              |

**Дүгнэлт:** Бичил уурхай эрхлэгчид болон ченжийн бий болгосон ажлын байрнаас үзүүлэх шууд нөлөөллийг Хүснэгт 14 дээр тусгасан. Юуны өмнө IRIM судалгааны хүрээлэн нь бүх 12 сумын бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс хөдөлмөр эрхлэлтэд үзүүлж буй шууд нөлөөллийг үнэлэн үзсэн. Хүснэгт 14 дээрх эхний мөрүүд нь бичил уурхай эрхлэгчид нийт 7,845 ажлын байр бий болгосон, ченж 72 ажлын байр бий болгосон болохыг харуулан, ойролцоогоор 3 тэрбум төгрөгийг сумд дээрх ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас олж буйг харуулсан. Хоёрдугаарт IRIM судалгааны хүрээлэн нь судалгаанд хамрагдсан бичил уурхайчид, ченжийн шууд үзүүлж буй хөдөлмөр эрхлэлтээс үүдэх эдийн засгийн шууд нөлөөллийг судлан үзсэн. Хүснэгт 14-ийн хоёрдахь мөрүүд нь бичил уурхайчид, ченж нь 145 ажлын байрыг бий болгож (96 уурхайчин + 34 өрхийн гишүүд үйл ажиллагаанд оролцож + 15 ченж) эдгээр хүмүүс сард 60.2 сая төгрөгийн орлого олж буйг харуулжээ.

#### Хүснэгт 14 Ажил эрхлэлтийн шууд хөрөнгө оруулалтын нэгдсэн дүн

| Түвшин                                | Нийт ажлын байрны тоо | Бичил уурхайгаас олсон сарын орлого (төгрөг) |
|---------------------------------------|-----------------------|----------------------------------------------|
| <b>Сумын түвшинд</b>                  | <b>7917</b>           | <b>3,077,629,000</b>                         |
| <b>Судалгаанд хамрагсадын түвшинд</b> | <b>145</b>            | <b>60,255,356</b>                            |

## 5.2 Татвар болон төлбөр хураамж

Татвар, төлбөр хураамж хэлбэрээр хийгдэж буй эдийн засгийн шууд нөлөөллийг хувь хүмүүс болон ажил эрхлэгчдийн зүгээс орон нутгийн татвар, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал хариуцсан болон бусад байгууллагуудад төлсөн татвар, төлбөр, хураамжийн хэмжээг ашиглан тооцон гаргасан. Энэхүү судалгаагаар гар аргаар ашигт малтмал олборлогчид болон бичил уурхайчид, ашигт малтмалын ченжнэр сар тутамд орон нутагт хэдий хэмжээний татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж татвар хураамжаар хэр хэмжээнд шууд нөлөөлөл үзүүлж буйг тооцон гаргасан.

IRIM судалгааны хүрээлэн нь ТББ-ууд, бичил уурхай эрхлэгчид, ченжээс санал асуулгын хуудас болон ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан бөгөөд эдгээр хүмүүсийн төлсөн нийт татвар, төлбөр, хураамжийн хэмжээг Хүснэгт 15 дээр харуулсан. Судалгааны арга зүйн хэсэг дээр дурдсан хязгаарлалтуудын улмаас орон нутгийн татварын болон бусад асуудал хариуцсан байгууллагуудад тэдгээр бичил уурхайчид, ченж сард эсвэл жилд хэдий хэмжээний татвар, хураамж төлж буй талаар тусгайлсан мэдээлэлгүй байсан. Тухайн байгууллагууд нь бичил уурхайчид, ченжээс хураан авсан татвар, хураамжийг уул уурхайн холбогдолтой татвар хэмээх ангилалд хамруулсан тул гар аргаар ашигт малтмал олборлогчид, ченжээс хэдий хэмжээний татвар хураан авсан талаарх дэлгэрэнгүй тайлан мэдээлэл гаргадаггүй ажээ.

### 5.2.1 Татвар

Судалгаагаар албан бус ашигт малтмал олборлогчид, ченж нь орлогын албан татвар огт төлдөггүй болохыг тогтоосон. Гэхдээ албан уурхайчдын хувьд тэд ТББ-аар дамжуулан сар тутам тогтмол хэмжээний татварыг орон нутагт төлдөг байна. Хүснэгт 15 дээр татварын нийт хэмжээг дурдсан бөгөөд энэ нь сард нийт дүнгээр 1,798,198 болж буй нь албан ёсны бичил уурхай эрхлэгчид, ченжийн төлсөн татварын хэмжээ юм. Нөгөө талаар судалгааны

ярилцлагад дурдсанаар албан бусаар ашигт малтмал олборлогчдын хувьд тэд татварын алба эсвэл аль нэг ТББ-д бүртгэлгүй тул татвар төлдөггүй байна. Мөн албан бус ашигт малтмал олборлогчдын хувьд орлого болон ажиллаж буй байршлын хувьд хэлбэлзэл өндөртэй, тухайн олборлолт хийж буй газрын нөөцөөс хамааран нэг газраас нөгөө газарт шилжин явдаг нь байнга татвар төлж байхад саад болдог нэг нөхцөл болж байна.

Судалгааны үр дүнгээс харвал (Хүснэгт 15) албан ёсны бүртгэлтэй бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутагт төлж буй татварын нийт хэмжээ нь 1,645,866 төгрөг байна. Эсрэгээр ашигт малтмал ченжийн хувьд тэдний гуравны нэг нь сар тутам орон нутгийн төсөвт татвар төлж байхыг шаардсан гурван талт гэрээнд (Дундговь, Дорноговь аймгууд) нэгдэн гарын үсэг зурсан тул нийт 143,332 төгрөгийн татварыг орон нутагт төлсөн байна (Хүснэгт 15-ыг үзнэ үү). Харин гурван талт гэрээгүй ченж ямар нэгэн татвар төлдөггүй байна.

Дундговь аймгийн албан ёсны бүртгэлтэй ашигт малтмал олборлогчдын хувьд орон нутгийн захиргаа, компани болон ТББ-уудын хоорондын гурван талт гэрээний дагуу сар тутамд 53,000 төгрөгийг татварыг төлж байна. Бусад сумдын албан ёсны ашигт малтмал олборлогчдын хувьд татварт төлж буй мөнгөн дүн нь ялгаатай 1,000- 20,000 төгрөгийн хооронд буй бөгөөд мөнгөн дүн нь тэдний орлогын түвшин болон тухайн газар дээрх үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээнээс хамаарч байна. Жишээ нь Баянхонгор болон Дундговь аймгийн бичил уурхай эрхлэгчид илүү өндөр хэмжээний мөнгөн дүнг (764,000 болон 689,000 төгрөг) татварт төлдөг бол Төв аймаг, Говь-Алтай аймгийн Бигэр сумын хувьд тухайн орон нутаг дахь ТББ-ууд нь зохион байгуулалтад сайн орж чадаагүй тул харьцангуй бага хэмжээний татварыг төлж байна.


**Хүснэгт 15 Бичил уурхайчид болон ченжийн татвар төлөлт - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                      |                                     | Ченж                                 |                                     |
|----------------------|-----------|--------------------------------------|-------------------------------------|--------------------------------------|-------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж татварын хэмжээ(төгрөг) | Сарын нийт татварын хэмжээ (төгрөг) | Сарын дундаж татварын хэмжээ(төгрөг) | Сарын нийт татварын хэмжээ (төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                      |                                     |                                      |                                     |
| Баянхонгор           | Баян-Овоо | 89,500                               | 716,000                             | -                                    | -                                   |
|                      | Бөмбөгөр  | 6000                                 | 48,000                              | -                                    | -                                   |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 9,417                                | 37,666                              | 20,833                               | 41,600                              |
|                      | Бигэр     | 1,745                                | 19,200                              | -                                    | -                                   |
| Дорноговь            | Айраг     | 5,067                                | 76,000                              | 50,000                               | <b>50,000</b>                       |
| Дундговь             | Хулд      | 33,125                               | 265,000                             | 5,000                                | 5,000                               |
|                      | Өлзийт    | 53,000                               | 424,000                             | 16,666                               | 16,666                              |
| Дархан-Уул           | Шарын гол | 7,600                                | 38,000                              | -                                    | -                                   |
| Сэлэнгэ              | Мандал    | -                                    | -                                   | -                                    | -                                   |

|          |           |       |           |        |           |
|----------|-----------|-------|-----------|--------|-----------|
|          | Орхонтуул | 200   | 1,000     | -      | -         |
| Төв      | Заамар    | 1,250 | 10,000    | 15,000 | 30,000    |
|          | Борнуур   | 1,375 | 11,000    | -      | -         |
| Нийт     |           |       | 1,645,866 |        | 143,332   |
| Нийт дүн |           |       |           |        | 1,789,198 |

ТББ-уудын тодорхой асуудал хариуцсан хүмүүстэй хийсэн ярилцлагаар тухайн ТББ-ууд нь өөрт хамаарах бүх уурхайчдаас татвар хураах оролдлого хийж үзсэн ч тэдний орлого нь тогтворгүйн улмаас энэхүү арга хэмжээ үр дүнд хүрээгүй хэмээн дурджээ. Зураг 9 дээр татвар төлж буй болон төлдөггүй уурхайчид, ченжийн тоог харуулсан. Тус судалгаанд ижил тооны албан болон албан бус бичил уурхай эрхлэгчдийг хамруулсантай Зураг 9 нь ТББ-д бүртгэлтэй хэдий ч татвар төлдөггүй албан бус уурхайчид байгааг харуулж байна. Зураг 9 нь мөн ченжийн гуравны нэг нь гурван талт гэрээнд гарын үсэг зурж, татвар төлдөг болохыг харуулж байна.

Дүрс 9 Татвар төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт



Хүснэгт 16 Бичил уурхайчид болон ченж нарын татвар төлөлт - сумын түвшинд

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                      |                                     | Ченж                                 |                                    |
|----------------------|-----------|--------------------------------------|-------------------------------------|--------------------------------------|------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж татварын хэмжээ(төгрөг) | Сарын нийт татварын хэмжээ (төгрөг) | Сарын дундаж татварын хэмжээ(төгрөг) | Сарын нийт татварын хэмжээ(төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                      |                                     |                                      |                                    |
| Баянхонгор           | Баян-Овоо | 89,500                               | 74,285,000                          | -                                    | 0                                  |
|                      | Бөмбөгөр  | 6,000                                | 12,600,000                          | -                                    | 0                                  |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 9,417                                | 18,080,640                          | 20,833                               | 312,495                            |
|                      | Бигэр     | 1,745                                | 0                                   | -                                    | 0                                  |
| Дорноговь            | Айраг     | 5,067                                | 83,6055                             | 50,000                               | 50,000                             |
| Дундговь             | Хулд      | 33,125                               | 16,165,000                          | 5,000                                | 20,000                             |
|                      | Өлзийт    | 53,000                               | 20,564,000                          | 16,666                               | 66,664                             |
| Дархан-Уул           | Шарын гол | 7,600                                | 4,028,000                           | -                                    | 0                                  |
| Сэлэнгэ              | Мандал    | -                                    | 0                                   | -                                    | 0                                  |
|                      | Орхонтуул | 200                                  | 60,000                              | -                                    | 0                                  |
| Төв                  | Заамар    | 1,250                                | 162,500                             | 15,000                               | 75,000                             |
|                      | Борнуур   | 1,375                                | 203,500                             | -                                    | 0                                  |
| Нийт                 |           |                                      | 146,984,695                         |                                      | 524,159                            |
| Нийт дүн             |           |                                      |                                     |                                      | 147,508,854                        |

Хүснэгт 16 нь уурхайчид, ченжийн зүгээс өөрийн сумын төсөвт сар тутамд төлсөн татварын нийт хэмжээг (147,508,854 төгрөг) харуулж байна. Сумын төсөвт төлсөн татварын хэмжээнд гарч буй зөрүү нь албан болон албан бус бичил уурхай эрхлэгчийн тоо болон ашигт малтмал олборлож буй газруудын тооноос хамаарч байна.

Тоймлон авч үзвэл Хүснэгт 17 дээр судалгаанд хамрагдсан хүмүүсийн төлсөн татварын нийт хэмжээ нь 1,789,198 төгрөг болж буйг харуулж буй бөгөөд бүх сумдын нийт уурхайчид, ченжийн төлсөн татвар нь 147,508,854 төгрөг болж байна.

**Хүснэгт 17 Татвар төлөлтийн нэгдсэн дүн**

| Түвшин                                | Бичил уурхайчид, ченжийн тоо | Сарын нийт татвар төлөлт (төгрөг) |
|---------------------------------------|------------------------------|-----------------------------------|
| <b>Сумын түвшинд</b>                  | <b>7917</b>                  | <b>147,508,854</b>                |
| <b>Судалгаанд хамрагсадын түвшинд</b> | <b>145</b>                   | <b>1,789,198</b>                  |

### 5.2.1 Төлбөр, хураамж

Эдийн засагт үзүүлж буй шууд нөлөөллийг нарийн тооцохын тулд бичил уурхайчдын төлж буй төлбөр, хураамжийг тооцох нь чухал юм. Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь тухайн уурхайчид, ченжийн зүгээс хамаарах төрийн болон төрийн бус байгууллагад төлж буй төлбөр хураамжийг тооцон гаргасан (Хүснэгт 18). ТББ-уудад төлж буй төлбөр хураамжийг нөхөн сэргээлт, гэнэтийн осол, онцгой байдал болон эмзэг бүлгийн уурхайчдын эрүүл мэнд болон амьжиргааг дэмжихэд зарцуулдаг байна. Тоон судалгааны дүнгээс харвал ТББ-д төлж буй төлбөр хураамжийн хэмжээ нь бага (сард 1,000- 5,000 төгрөг) байгаа нь уурхайчдад тухайн төлбөрийг төлөхөд саадгүй байлгах зорилгоор тогтоосон байна. Гэхдээ зарим ТББ өөрт бүртгэлтэй бичил уурхай эрхлэгч нараас төлбөр хураамж авдаггүй. Бичил уурхай эрхлэгчид болон ченжээс сар тутамд орон нутгийн ТББ-уудад төлж буй нийт мөнгөн дүн нь 4,103,332 төгрөг байна (Хүснэгт 8-ыг үзнэ үү). Ченжийн хувьд гурван талт гэрээ бүхий Дундговь аймгийн Хулд сумын хувьд ченжид орон нутгийн захиргаанд ихээхэн өндөр талбөр хураамж төлж байхыг шаарддаг байна.

**Хүснэгт 18 Бичил уурхайчид болон ченж нарын хураамж төлөлт - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                        |                                       | Ченж                                   |                                      |
|----------------------|-----------|----------------------------------------|---------------------------------------|----------------------------------------|--------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж хураамжийн хэмжээ(төгрөг) | Сарын нийт хураамжийн хэмжээ (төгрөг) | Сарын дундаж хураамжийн хэмжээ(төгрөг) | Сарын нийт хураамжийн хэмжээ(төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                        |                                       |                                        |                                      |
| Баянхонгор           | Баян-Овоо | 6,500                                  | 52,000                                | -                                      | -                                    |
|                      | Бөмбөгөр  | 5,750                                  | 46,000                                | 5,500                                  | 11,000                               |

|                 |           |       |         |           |                  |
|-----------------|-----------|-------|---------|-----------|------------------|
| Говь-Алтай      | Есөнбулаг | 1,250 | 5,000   | -         | -                |
|                 | Бигэр     | -     | -       | -         | -                |
| Дорноговь       | Айраг     | 6,250 | 100,000 | -         | -                |
| Дундговь        | Хулд      | 708   | 5,666   | 3,750,000 | 3,750,000        |
|                 | Өлзийт    | 8,500 | 68,000  | -         | -                |
| Дархан-Уул      | Шарын гол | 6,000 | 30,000  | -         | -                |
| Сэлэнгэ         | Мандал    | 167   | 1,000   | 1,000     | 1,000            |
|                 | Орхонтуул | 1,533 | 7666    | -         | -                |
| Төв             | Заамар    | -     | -       | 8,000     | 8,000            |
|                 | Борнуур   | 2,250 | 18,000  | -         | -                |
| Нийт            |           |       | 333,332 |           | 3,770,000        |
| <b>Нийт дүн</b> |           |       |         |           | <b>4,103,332</b> |

Гурван талт гэрээ бүхий сумдын хувьд олборлож буй ашигт малтмалын хувьд өөр өөр байна. Жишээ нь нүүрс, жонш зэрэг нь татвар, хураамж ноогдуулах өөр өөр механизмыг ашиглахад хүргэж байна. Жонш бүхий сумд дахь ченж нь орон нутгийн захиргаад төлбөр хураамж төлдөг бол алтны олборлолт явагдаж буй сумдын хувьд ченж нь ямар нэг бүртгэлгүй үйл ажиллагаа явуулдаг тул татвар, хураамж төлдөггүй байна. Ченжийн зүгээс орон нутагт төлж буй нийт төлбөр хураамж, татварын нийт хэмжээ нь сард 3,770,000 төгрөг байна.

Хүснэгт 19 дээр сум нэг бүрээр бичил уурхайчид, ченжийн төлсөн нийт мөнгөн дүнг харуулсан нь 43,784,936 төгрөг болж байна. Нийт 43 сая төгрөгөөс 28,658,936 төгрөгийг ТББ-ууд төвлөрүүлж, нөхөн сэргээлт, нийгмийн халамж, орон нутгийн хөгжилд зарцуулжээ.

**Хүснэгт 19 Бичил уурхайчид болон ченж нарын хураамж төлөлт - сумын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                        |                                       | Ченж                                   |                                      |
|----------------------|-----------|----------------------------------------|---------------------------------------|----------------------------------------|--------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж хураамжийн хэмжээ(төгрөг) | Сарын нийт хураамжийн хэмжээ (төгрөг) | Сарын дундаж хураамжийн хэмжээ(төгрөг) | Сарын нийт хураамжийн хэмжээ(төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                        |                                       |                                        |                                      |
| Баянхонгор           | Баян-Овоо | 6,500                                  | 5,395,000                             | -                                      | 0                                    |
|                      | Бөмбөгөр  | 5,750                                  | 12,075,000                            | -                                      | 66,000                               |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 1,250                                  | 2,400,000                             | 20,833                                 | 0                                    |
|                      | Бигэр     | -                                      | 0                                     | -                                      | 0                                    |
| Дорноговь            | Айраг     | 6,250                                  | 1,031,250                             | 50,000                                 | 0                                    |
| Дундговь             | Хулд      | 708                                    | 345,504                               | 5,000                                  | 15,000,000                           |
|                      | Өлзийт    | 8,500                                  | 3,298,000                             | 16,666                                 | 0                                    |
| Дархан-Уул           | Шарын гол | 6,000                                  | 3,180,000                             | -                                      | 0                                    |
| Сэлэнгэ              | Мандал    | 167                                    | 141,282                               | -                                      | 20,000                               |
|                      | Орхонтуул | 1,533                                  | 459,900                               | -                                      | 0                                    |
| Төв                  | Заамар    | -                                      | 0                                     | 15,000                                 | 40,000                               |
|                      | Борнуур   | 2,250                                  | 333,000                               | -                                      | 0                                    |
| Нийт                 |           |                                        | 28,658,936                            |                                        | 15,126,000                           |
| <b>Нийт дүн</b>      |           |                                        |                                       |                                        | <b>43,784,936</b>                    |

Ярилцлагын үеэр албан ёсны бүртгэл бүхий уурхайчдын зүгээс тэд ТББ-уудад төлбөр хураамж төлдөг хэмээн хэлсэн бол ТББ-ууд нь уурхайчдаас ямар нэгэн төлбөр хураамж

авдаггүй хэмээн хариулжээ. Бодит байдал дээр тодорхой сумдад 2-оос дээш тооны ТББ үйл ажиллагаа явуулж буй ч судалгааны түүврээр нэг сумаас 1-2 ТББ-ыг л хамруулсан юм. Тухайлбал Заамар суманд 6 ТББ үйл ажиллагаа явуулж буй бөгөөд судалгааны ярилцлагад олон өөр өөр байгууллагад хамрах бичил уурхайчид сонгогдсон байх магадлалтай тул ТББ-уудын төвлөрүүлдэг төлбөр хураамж зөрүүтэй гарсан, мөн ТББ-ууд нь төлбөрийн ялгаатай хувь хэмжээг баримталдаг зэргээс дээрх үр дүн үүдэлтэй байж болно.

Дүрс 10 Хураамж төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт



Зураг 10 нь мөн судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын гуравны нэг хүрэхгүй хувь нь төлбөр хураамж төлдөг, ченжийн дөрөвний нэгээс багахан илүү хувь нь орон нутгийн захиргаа болон ТББ-д сан үүсгэхэд нь зориулан хураамж төлдөг байна.

Үндсэндээ бичил уурхайчид, ченжийн төлж буй нийт төлбөр хураамжийн хэмжээ нь 4,103,332 төгрөг байгаа ба энэ нь улсын төсөвт төвлөрч байна. Зорилтот 7 сумын орон нутгийн захиргаадад хамаарах бүхий бичил уурхайчид, ченжийн төлж буй сумын түвшин дэхь төлбөр хураамжийн нийт хэмжээ нь ойролцоогоор 43,784,936 төгрөг байна (Хүснэгт 20).

Хүснэгт 20 Бичил уурхайчид, ченжийн хураамж төлөлтийн нэгдсэн дүн

| Түвшин                         | Бичил уурхайчид, ченжийн тоо | Сарын нийт хураамж төлөлт (төгрөг) |
|--------------------------------|------------------------------|------------------------------------|
| Сумын түвшинд                  | 7,917                        | 43,784,936                         |
| Судалгаанд хамрагсaдын түвшинд | 145                          | 4,103,332                          |

### 5.2.1 Нийгмийн даатгал

Татвар болон төлбөр хураамжаас ялгаатай нь албан болон албан бус бичил уурхайчид болон ченжийн аль аль нь ТББ-уудын зүгээс нийгийн даатгал төлж байхыг шаарддаг ч

тэдний бараг оролцоогүйгээр өөрсдөө бие даан нийгмийн даатгалын хураамжийг төлж байна. Тоон судалгаа мөн ТББ-ууд нийгмийн даатгалд хамрагдалт дээр оролцоо, хувь нэмэр багатай буйг харуулж байна.

**Хүснэгт 21 Бичил уурхайчид, ченж нарын нийгмийн даатгал төлөлтийн байдал - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                                 |                                               | Ченж                                            |                                               |
|----------------------|-----------|-------------------------------------------------|-----------------------------------------------|-------------------------------------------------|-----------------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж нийгмийн даатгалын төлөлт(төгрөг ) | Сарын нийт нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын дундаж нийгмийн даатгалын төлөлт(төгрөг ) | Сарын нийт нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                                 |                                               |                                                 |                                               |
| Баянхонгор           | Баян-Овоо | 26400                                           | 211,200                                       | -                                               | -                                             |
|                      | Бөмбөгөр  | 6000                                            | 48,000                                        | 12,000                                          | 24,000                                        |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 17500                                           | 70,000                                        | 26,900                                          | 53,800                                        |
|                      | Бигэр     | 6545                                            | 72,000                                        | -                                               | -                                             |
| Дорноговь            | Айраг     | 8940                                            | 143,040                                       | 48,000                                          | 48,000                                        |
| Дундговь             | Хулд      | 11117                                           | 89,420                                        | 23,040                                          | 23,040                                        |
|                      | Өлзийт    | 20160                                           | 161,280                                       | 23,040                                          | 23,040                                        |
| Сэлэнгэ              | Мандал    | 3667                                            | 22,000                                        | -                                               | -                                             |
|                      | Орхонтуул | -                                               | -                                             | -                                               | -                                             |
| Дархан-Уул           | Шарын гол | 9200                                            | 46,000                                        |                                                 |                                               |
| Төв                  | Заамар    | 8640                                            | 69,120                                        | 23,100                                          | 46,200                                        |
|                      | Борнуур   | 7750                                            | 62,000                                        | -                                               | -                                             |
| <b>Нийт</b>          |           |                                                 | <b>884,670</b>                                |                                                 | <b>218,080</b>                                |
| <b>Нийт дүн</b>      |           |                                                 |                                               |                                                 | <b>1,102,750</b>                              |

Бичил уурхайчид, ченж ихэнхдээ нийгмийн даатгалыг хамгийн доод хэмжээгээр нь тооцон төлж буйн зэрэгцээ тэдний орлогын хэмжээ нь хэлбэлзэлтэй улмаас байнга төлж чаддаггүй байна. Хүснэгт 21 дээр харуулсанчлан ихэнх бичил уурхайчид, ченж нийгмийн даатгал хамгийн доод хэмжээгээр тооцон хураамж төлдөг ажээ. ТББ-ын гарган өгсөн мэдээллээс үзвэл гурван талт гэрээ бүхий Дундговь аймагт нийгмийн даатгалын хураамжид төлөгдсөн мөнгөн дүн нь (сард 7,027,200 төгрөг) хавьгүй өндөр байна. Тиймээс гурван талт гэрээ бүхий газруудад бичил уурхайчдын зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлэх хувь нэмэр бусад гурван талт гэрээ хийгдээгүй газруудаас өндөр байна. Нийтэд нь авч үзвэл бичил уурхайчид, ченжийн төлсөн нийгмийн даатгалын нийт шимтгэл нь судалгаанд хамрагдагчдын хариултаас үзвэл 1,102,750 төгрөг байна. Энэхүү шимтгэлийг орон нутгийн нийгмийн даатгалын газруудад шууд төлсөн бөгөөд төвлөрсөн орлогыг орон нутгийн албаны хүмүүс, төрийн байгууллагуудын ажилтнуудын цалин, урамшуулалд зарцуулсан байна.

Хүснэгт 22 дээрээс үзвэл зорилтот 12 сумын бүх бичил уурхайчид, ченжийн төлсөн нийт нийгмийн даатгалын шимтгэл нь 90,703,306 байжээ. Хүснэгт 19 дээр харуулсан үр дүнгийн


нэгэн адил Бигэр болон Орхонтуул сумдын бичил уурхайчид, ченж нийгмийн даатгал төлдөггүй хэмээн хариулсан тул сумын хэмжээний тооцоо эдгээр сумд дээр хийгдээгүй.

**Хүснэгт 22 Бичил уурхайчид, ченж нарын нийгмийн даатгал төлөлтийн байдал – сумын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                                 |                                               | Ченж                                            |                                               |
|----------------------|-----------|-------------------------------------------------|-----------------------------------------------|-------------------------------------------------|-----------------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын дундаж нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт нийгмийн даатгалын төлөлт (төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                                 |                                               |                                                 |                                               |
| Баянхонгор           | Баян-Овоо | 26,400                                          | 21,912,000                                    | -                                               | 0                                             |
|                      | Бөмбөгөр  | 6,000                                           | 12,600,000                                    | 12,000                                          | 144,000                                       |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 17,500                                          | 33,600,000                                    | 26,900                                          | 403,500                                       |
|                      | Бигэр     | 6,545                                           | 0                                             | -                                               | 0                                             |
| Дорноговь            | Айраг     | 8,940                                           | 1,475,100                                     | 48,000                                          | 48,000                                        |
| Дундговь             | Хулд      | 11,117                                          | 5,425,096                                     | 23,040                                          | 92,160                                        |
|                      | Өлзийт    | 20,160                                          | 7,822,080                                     | 23,040                                          | 92,160                                        |
| Сэлэнгэ              | Мандал    | 3,667                                           | 1,943,510                                     | -                                               | 0                                             |
|                      | Орхонтуул | -                                               | 0                                             | -                                               | 0                                             |
| Дархан-Уул           | Шарын гол | 9,200                                           | 2,760,000                                     |                                                 | 0                                             |
| Төв                  | Заамар    | 8,640                                           | 1,123,200                                     | 23,100                                          | 115,500                                       |
|                      | Борнуур   | 7,750                                           | 1,147,000                                     | -                                               | 0                                             |
| <b>Нийт</b>          |           |                                                 | 89,807,986                                    |                                                 | 895,320                                       |
| <b>Нийт дүн</b>      |           |                                                 |                                               | <b>90,703,306</b>                               |                                               |

Зураг 11 дээр нийгмийн даатгал төлдөг болон төлдөггүй оролцогч нарын хувь хэмжээг харуулсан. Татвар болон төлбөр хураамжтай харьцуулбал Зураг 11 дээр илүү олон тооны бичил уурхай эрхлэгчид нийгмийн даатгалын шимтгэл төлж буйг харуулж байна. Гэхдээ нийгмийн даатгалд хамрагдаж буй оролцогчдын хувь хэмжээ нь тэгш 50% байгаагүй. Тиймээс нийгмийн даатгалд хамрагдаж буй бичил уурхай эрхлэгчид, ченжийн тоог нэмэгдүүлэх нь чухал байна. Тоон судалгаагаар нийгмийн даатгал нь бичил уурхайчид, ченжид үзүүлэх шууд нөлөөлөл байдаггүй тул байнга нийгмийн даатгалын хураамж төлөх тал дээр зарим талаар эргэлздэг байна. Тиймээс зорилтот сумд дахь ТББ-ууд болон орон нутгийн захиргаад нь нийгмийн даатгал болон бусад татвар хураамжийн үр шимийн талаар түлхүү мэдээлэл түгээх шаардлагатай байна.

Дүрс 11 Нийгмийн даатгал төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт



Дүгнэж хэлэхэд судалгаанд хамрагдсан хүмүүсийн төлсөн нийгмийн даатгалын нийтшигтгэл нь 1,102,750 төгрөг (Хүснэгт 23), бичил уурхайчид, ченжийн суманд төлсөн нийгмийн даатгал нь 90,703,306 байжээ.

Хүснэгт 23 Бичил уурхайчид, ченжийн нийгмийн даатгал төлөлтийн нэгдсэн дүн

| Түвшин                         | Бичил уурхайчид, ченжийн тоо | Сарын нийт нийгмийн даатгал төлөлт (төгрөг) |
|--------------------------------|------------------------------|---------------------------------------------|
| Сумын түвшинд                  | 7917                         | 90,703,306                                  |
| Судалгаанд хамрагсaдын түвшинд | 145                          | 1,102,750                                   |

### 5.2.1 Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн даатгал нь хүнд, хортой нөхцөлд ажилладаг бичил уурхайчид, ченжийн хувьд ихээхэн чухал ач холбогдолтой билээ. Судалгаанд хамрагдсан хүмүүс өөрсдийн үйл ажиллагаандаа ямар нэгэн химийн болон тэсрэх бодис ашигладаггүй хэмээн хэлж байна. Гэхдээ судалгааны үеийн ажиглалтаас үзвэл тэдгээр бичил уурхайчид химийн бодис, тэсрэх бодисыг үндсэн орд бүхий газруудад ашиглаж байх магадлалтай юм. Ерөнхийдөө бичил уурхайчдын үзэж буйгаар ажлын хортой нөхцөл, олборлолтоос үүдэх тоос шорооны улмаас эрүүл мэндийн нь байдал, ялангуяа амьсгалын зам, уушигны эрүүл мэнд муудаж байгаа хэмээн цохон дурджээ. Тиймээс бичил уурхайчид, ченжийн хувьд эрүүл мэндийн үзлэг, тусламж үйлчилгээг бага зардлаар авахад даатгалын хураамж төлж байх нь чухал ач холбогдолтой юм.

Нийгмийн даатгалын хувьд ихэнх уурхайчид, ченж нь эрүүл мэндийн даатгалын хураамжийг хувиараа төлдөг байна. Гэхдээ ТББ-уудын хувьд өөрт бүртгэлтэй

бичилуурхайчдыг эрүүл мэндийн даатгалын хураамж төлж байхыг шаардахын зэрэгцээ, даатгалд хамрагдахын үр ашиг болон энэхүү боломжийг хэрхэн ашиглаж болох талаар сургалт, семинаруудын үеэр мэдээлэл зтүгээдэг байна. Судалгааны ажиглалтын үеэр эрүүл мэндийн даатгалын санг хэрхэн ашиглах талаар мэдэхгүй бичил уурхайчид, ченж нь ихэнхдээ эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүй болох нь ажиглагдсан. Тиймээс даатгалын үр ашиг болон хэрхэн ашиглах талаар хангалттай хэмжээний мэдээллийг түгээх нь чухал байна.

**Хүснэгт 24 Бичил уурхайчид, ченж нарын эрүүл мэндийн даатгал төлөлтийн байдал – судалгаанд хамрагсадын түвшинд**

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                                      |                                                    | Ченж                                                 |                                                    |
|----------------------|-----------|------------------------------------------------------|----------------------------------------------------|------------------------------------------------------|----------------------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын дундаж эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                                      |                                                    |                                                      |                                                    |
| Баянхонгор           | Баян-Овоо | 335                                                  | 2,680                                              | -                                                    | -                                                  |
|                      | Бөмбөгөр  | 670                                                  | 5,360                                              | 335                                                  | 670                                                |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 335                                                  | 2,680                                              | 670                                                  | 670                                                |
|                      | Бигэр     | -                                                    | -                                                  | -                                                    | -                                                  |
| Дорноговь            | Айраг     | 209                                                  | 3,350                                              | -                                                    | -                                                  |
| Дундговь             | Хулд      | 335                                                  | 2,680                                              | -                                                    | -                                                  |
|                      | Өлзийт    | 670                                                  | 5,360                                              | -                                                    | -                                                  |
| Дархан-Уул           | Шарын гол | -                                                    | -                                                  | -                                                    | -                                                  |
| Сэлэнгэ              | Мандал    | -                                                    | -                                                  | -                                                    | -                                                  |
|                      | Орхонтуул | -                                                    | -                                                  | 600                                                  | 600                                                |
| Төв                  | Заамар    | 335                                                  | 2,680                                              | 335                                                  | 670                                                |
|                      | Борнуур   | 168                                                  | 1,340                                              | -                                                    | -                                                  |
| Нийт                 |           |                                                      | 26,130                                             |                                                      | 2,610                                              |
| Нийт дүн             |           |                                                      |                                                    |                                                      | 562,670                                            |


Эрүүл мэндийн даатгалд жилд төлөх хураамжийн доод хэмжээ нь 8,040 төгрөг байна. Хүснэгт 24 дээр судалгаанд хамрагдсан бичил уурхайчид, ченжийн төлсөн эрүүл мэндийн даатгалын нийт хураамжийн хэмжээг харуулсан. Эдгээр бичил уурхайчид, ченж нь нийт 562,670 төгрөгийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг орон нутагт төлжээ. Сэлэнгэ, Дархан-Уул, Дорноговь болон Дундговь аймгуудын хувьд эрүүл мэндийн даатгалын хураамж төлж буй бичил уурхайчид, ченжийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Чанарын судалгааны үр дүнд ашигт малтмал олборлож буй газрууд дахь осол гэмтлийн тоо их биш, осол гэмтэл гаралт түгээмэл бус буйг харуулж байна. Гэхдээ гар аргаар ашигт малтмал олборлох ажил хийж эхэлснээс хойш 5 жилийн дараагаар өвчилж буй хүмүүсийн тоо нэмэгдэх хандлагатай байна. Тэдний ихэнх нь уушигны эрүүл мэндийн хувьд асуудалтай болж, улмаар сүрьеэ өвчин тусаж байна.

### Хүснэгт 25 Бичил уурхайчид, ченж нарын эрүүл мэндийн даатгал төлөлтийн байдал – сумын түвшинд

| Мэдээллийн эх үүсвэр |           | Бичил уурхайчид                                      |                                                    | Ченж                                                 |                                                    |
|----------------------|-----------|------------------------------------------------------|----------------------------------------------------|------------------------------------------------------|----------------------------------------------------|
| Байршил              |           | Сарын дундаж эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын дундаж эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) | Сарын нийт эрүүл мэндийн даатгалын төлөлт (төгрөг) |
| Аймаг                | Сум       |                                                      |                                                    |                                                      |                                                    |
| Баянхонгор           | Баян-Овоо | 335                                                  | 278,050                                            | -                                                    | 0                                                  |
|                      | Бөмбөгөр  | 670                                                  | 1,407,000                                          | 335                                                  | 4,020                                              |
| Говь-Алтай           | Есөнбулаг | 335                                                  | 643,200                                            | 670                                                  | 10,050                                             |
|                      | Бигэр     | -                                                    | 0                                                  | -                                                    | 0                                                  |
| Дорноговь            | Айраг     | 209                                                  | 34,485                                             | -                                                    | 0                                                  |
| Дундговь             | Хулд      | 335                                                  | 163,480                                            | -                                                    | 0                                                  |
|                      | Өлзийт    | 670                                                  | 259,960                                            | -                                                    | 0                                                  |
| Дархан-Уул           | Шарын гол | -                                                    | 0                                                  | -                                                    | 0                                                  |
| Сэлэнгэ              | Мандал    | -                                                    | 0                                                  | -                                                    | 0                                                  |
|                      | Орхонтуул | -                                                    | 0                                                  | 600                                                  | 2,400                                              |
| Төв                  | Заамар    | 335                                                  | 43,550                                             | 335                                                  | 1,675                                              |
|                      | Борнуур   | 168                                                  | 24,864                                             | -                                                    | 0                                                  |
| Нийт                 |           |                                                      | 2,854,589                                          |                                                      | 18,145                                             |
| Нийт дүн             |           |                                                      |                                                    |                                                      | 2,872,734                                          |

Хүснэгт 25-ын хувьд зорилтот 7 сумын нийт бичил уурхайчид, ченжийн орон нутагт төлсөн эрүүл мэндийн даатгалын нийт шимтгэл 2,872,734 төгрөг буйг харуулж байна. Зураг 12 нь эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлсөн болон төлөөгүй бичил уурхайчид, ченжийн хувь хэмжээг харуулсан. Бусад төрлийн татвар, төлбөр хураамжтай харцуулбал эрүүл мэндийн даатгалын хураамж төлж буй хүмүүсийн тоо хавьгүй доогуур байна. Тиймээс эрүүл мэндийн даатгалд хамрагдагчдын тоог нэмэгдүүлэх нь зөвхөн орон нутгийн эдийн засагт ч бус мөн бичил уурхайчид, ченжийн эрүүл мэндэд ихээхэн тустай байх болно.

Дүрс 12 Эрүүл мэндийн даатгал төлдөг болон төлдөггүй бичил уурхайчид, ченж нарын үзүүлэлт



Хүснэгт 26 дээр харуулсанчлан зорилтот сумдын бүхий л бичил уурхайчид, ченж нь нийт 2,872,734 төгрөгийг эрүүл мэндийн даатгалын хураамжид төлжээ. Бодит хэрэг дээр

судалгаанд хамрагдсан хүмүүсийн төлсөн эрүүл мэндийн даатгалын хураамжийн нийт хэмжээ 562,670 байв.

**Хүснэгт 26 Бичил уурхайчид, ченжийн эрүүл мэндийн даатгал төлөлтийн нэгдсэн дүн**

| Түвшин                                        | Бичил уурхайчид,<br>ченжийн тоо | Сарын нийт эрүүл мэндийн даатгал<br>төлөлт (төгрөг) |
|-----------------------------------------------|---------------------------------|-----------------------------------------------------|
| <b>Сумын түвшинд</b>                          | <b>7917</b>                     | <b>2,872,734</b>                                    |
| <b>Судалгаанд<br/>хамрагсадын<br/>түвшинд</b> | <b>145</b>                      | <b>562,670</b>                                      |

**5.2.1 Роялти (Ашигт малтмалын нөөцийн төлбөр)**

2014 оныг хүртэл гар аргаар ашигт малтмал олборлогчид, бичил уурхайчид, ченж үндсэндээ маш бага хэмжээний роялти төлж иржээ. Үүнд хэд хэдэн шалтгаан байсан бөгөөд эдгээрийн тоонд нөөцийн төлбөрийг зөвхөн Монгол Банкнд төлдөг, олборлосон ашигт малтмалаа албан ёсоор борлуулахын тулд хэд хэдэн баримт бичиг бүрдүүлэх шаардлагатай болдог (ихээхэн саад тотгор учруулдаг) зэрэг багтаж байна. Тиймээс Монгол улсын ЗГ болон Монгол Банкны зүгээс хувь хүмүүсээс ашигт малтмал худалдан авахад ямар нэгэн бичиг баримт шаардахгүй байх шийдвэрийг гаргажээ. Үүний үр дүнд хувь хүмүүсийн зүгээс Монгол Банкнд тушааж буй алтны хэмжээ 2014 онд хоёр дахин нэмэгджээ.

Судалгаанд хамрагдсан албан болон албан бус бичил уурхайчид нөөцийн төлбөрийг шууд төлдөггүй ажээ. Үндсэндээ нөөцийн төлбөрийн ченж төлдөг бөгөөд зөвхөн Монгол Банкнд хувь хүмүүс ашигт малтмал, ялангуяа алт тушаахад л нөөцийн төлбөр төлдөг байна. Ихэнх тохиолдолд бичил уурхайчид өөрсдийн олборлосон түүхий эд, ихэнхдээ алтыг орон нутгийн худалдан авагчдад борлуулдаг бөгөөд улмаар орон нутгийн ченжүүд дараагийн шатанд дамжуулан борлуулж, эцсийн мөчид, цөөн тохиолдолд тухайн алт Монгол Банкнд тушаагддаг байна. Бичил уурхайчид болон Монгол Банкны хооронд 2-3 ченжийн гар дамждаг тул тэдгээр ченж хэдий хэмжээний нөөцийн төлбөр төлж буй тогтооход хүндрэлтэй бөгөөд учир нь тухайн ченж нуугдмал байдалд ажилладаг, судалгаанд хамруулахад хүндрэлтэй хэсэг юм. Тиймээс тухайн зорилтот 12 сумаас хэдий хэмжээний ашигт малтмал Монгол Банкнд тушаагдаж буйг (нийлүүлэлт талаас) тогтоох боломжгүй юм.

Мөн, Монгол Банк нь хувь хүмүүсээс худалдан авсан ашигт малтмалын хувьд дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, худалдан авсан бүтээгдэхүүнийг хаанаас олборлосон талаар бүртгэн авдаггүй болохыг цохон дурдах шаардлагатай. Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь тухайн зорилтот сумдаас хэр хэмжээний нөөцийн төлбөр төлөгддөг талаар тооцож чадаагүй болно.

Түүнчлэн Төв Банкинд төлсөн бүхий нөөцийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн, цаашид бүх сум, төрийн байгууллагуудын төсөвт хуваарилдаг байна. Тиймээс төлсөн нөөцийн төлбөрийн хэдэн хувь нь зорилтот 12 сумдын төсөвт хуваарилагдаж буйг тогтоох боломжгүй байв.

Дээрх шалтгааны улмаас энэхүү судалгаагаар нөөцийн төлбөрийн хэмжээг тооцон гаргах боломжгүй байсан тул суурь судалгаанд энэ талаар оруулаагүй болно.

### 5.2.1 Татвар болон төлбөр хураамжийн нэгтгэл тойм

Хүснэгт 27 дээр судалгаанд хамрагдсан бичил уурхайчид болон ченжийн (нийт 145 оролцогч) зүгээс орон нутагт төлсөн нийт татварын хэмжээг нэгтгэн харуулсан бөгөөд нийт татварын хэмжээ нь 7,133,344 төгрөг байна. Энэхүү татварын нийт хэмжээнд орлогын албан татвар, төлбөр хураамж, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг багтаасан.

Хүснэгт 27 Татвар болон хураамж төлөлтийн нэгдсэн дүн - судалгаанд хамрагсадын түвшинд

| Байршил         |           | Бичил уурхайчдын нийт татвар төлөлт | Ченжийн нийт татвар төлөлт | Бичил уурхайчид болон ченжийн нийт татвар төлөлт |
|-----------------|-----------|-------------------------------------|----------------------------|--------------------------------------------------|
| Аймаг           | Сум       |                                     |                            |                                                  |
| Баянхонгор      | Баян-Овоо | 981,880                             | 0                          | 981,880                                          |
|                 | Бөмбөгөр  | 147,360                             | 35,670                     | 183,030                                          |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 115,346                             | 96,070                     | 211,416                                          |
|                 | Бигэр     | 91,200                              | 0                          | 91,200                                           |
| Дорноговь       | Айраг     | 322,390                             | 98,000                     | 420,390                                          |
| Дундговь        | Хулд      | 362,766                             | 3,778,040                  | 4,140,806                                        |
|                 | Өлзийт    | 658,640                             | 39,706                     | 698,346                                          |
| Дархан-Уул      | Шарын гол | 90,000                              | 0                          | 90,000                                           |
| Сэлэнгэ         | Мандал    | 1,000                               | 1,000                      | 2,000                                            |
|                 | Орхонтуул | 54,666                              | 600                        | 55,266                                           |
| Төв             | Заамар    | 81,800                              | 84,870                     | 166,670                                          |
|                 | Борнуур   | 92,340                              | 0                          | 92,340                                           |
| Нийт            |           | 2,999,388                           | 4,133,956                  | 7,133,344                                        |
| <b>Нийт дүн</b> |           |                                     |                            | <b>7,133,344</b>                                 |

Хүснэгт 28 нь зорилтот 12 сумын нийт бичил уурхайчид, ченжийн (7,917 бичил уурхайчид, ченж) төлсөн нийт татварыг нэгтгэн харуулсан ба нийт дүн нь 138,028,401 төгрөг байна.

**Хүснэгт 28 Татвар болон хураамж төлөлтийн нэгдсэн дүн – сумын түвшинд**


| Байршил         |           | Бичил уурхайчдын<br>нийт татвар төлөлт | Ченжийн нийт татвар<br>төлөлт | Бичил уурхайчид болон<br>ченжийн нийт татвар төлөлт |
|-----------------|-----------|----------------------------------------|-------------------------------|-----------------------------------------------------|
| Аймаг           | Сум       |                                        |                               |                                                     |
| Баянхонгор      | Баян-Овоо | 27,585,050                             | 0                             | 27,585,050                                          |
|                 | Бөмбөгөр  | 26,082,000                             | 214020                        | 26,296,020                                          |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 36,684,800                             | 726045                        | 37,410,845                                          |
|                 | Бигэр     | 0                                      | 0                             | 0                                                   |
| Дорноговь       | Айраг     | 2,590,835                              | 98000                         | 2,688,835                                           |
| Дундговь        | Хулд      | 5,939,080                              | 15112160                      | 21,051,240                                          |
|                 | Өлзийт    | 11,396,706                             | 158824                        | 11,555,530                                          |
| Дархан-Уул      | Шарын гол | 5,123,510                              | 0                             | 5,123,510                                           |
| Сэлэнгэ         | Мандал    | 141,282                                | 20000                         | 161,282                                             |
|                 | Орхонтуул | 3,219,900                              | 2400                          | 3,222,300                                           |
| Төв             | Заамар    | 1,196,750                              | 232175                        | 1,428,925                                           |
|                 | Борнуур   | 1,504,864                              | 0                             | 1,504,864                                           |
| <b>Нийт дүн</b> |           | <b>121,464,777</b>                     | <b>16,563,624</b>             | <b>138,028,401</b>                                  |

## 5.3 Ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт

Худалдан авалтаас үзүүлж буй шууд нөлөөллийг ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой зардлуудыг харгалзах замаар тооцсон. Энэхүү зардлын тоонд тусгайлсан тоног төхөөрөмжийн зардал, гар багаж худалдан авах зардал, түлш шатахуун, ажлын хувцас, тээвэр болон хүнсний хэрэглээ зэргийг багтаан авч үзсэн. Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид нь сард дунджаар 67 сая төгрөгийг ашигт малтмал олборлохтой холбоотой зардалд зарцуулдаг байна. Энэхүү зардлын 72%-ийг орон нутгийн зах зээлээс худалдан авалт хийхэд зарцуулдаг бол 19%-ийг аймгийн хэмжээний зах зээлээс, 9%-ийг нь Улаанбаатар хотын зах зээлээс худалдан авалт хийхэд зарцуулж байна.

Сум, аймаг, Улаанбаатар хотын зах зээлийн түвшинд хийгдэж буй худалдан авалтын хэмжээг Зураг 13 дээр харуулсан. Зураг 13 нь хүнс (хамгийн өндөр зарцуулалттай) болон түлш шатахуун (гуравдахь том хэмжээний зарцуулалт) зэргийг үндсэндээ орон нутгийн зах зээл дээрээс худалдан авдаг болохыг харуулж байна.

Дүрс 13 Худалдан авалтын зардал - ТББ-ын мэдээлэл



Тоног төхөөрөмж худалдан авах нь зарцуулж буй мөнгөн дүнгийн хэмжээгээр хоёрдахь хамгийн өндөр зарцуулалт бүхий (сард 18 сая төгрөг) зүйл бөгөөд нийт тоног төхөөрөмжийн 33%-ийг сумаас, 38%-ийг аймгийн төвөөс худалдан авч байна. Бичил

уурхайд нь ойролцоогоор сард 3 сая төгрөгийг багаж хэрэгсэл худалдан авахад зарцуулдагаас 64%-ийг нь сумын зах зээл дээр, 33%-ийг нь аймгийн зах зээл дээр зарцуулж байна. Ойролцоогоор 13.5 сая төгрөгийг сард түлш шатахуунд зарцуулж буйгаас 81% нь сумын зах зээл дээр, 19% нь аймгийн зах зээлд орж байна. Бичил уурхай эрхлэгчид мөн ойролцоогоор 4 сая төгрөгийг ажлын хувцас худалдан авахад сар бүр зарцуулдаг хэрэгцээнийхээ 97%-ийг нь сумын зах зээлээс үлдэх 3%-ийг нь аймгийн зах зээл дээрээс хангаж байна. Ойролцоогоор 3.5 сая төгрөгийг сар тутамд тээврийн үйлчилгээнд зардаг ба 97% нь сумдын зах зээл, 3% нь аймгийн зах зээлд хамаарч байна. Бичил уурхай эрхлэгчид мөн сард 24 сая төгрөгийг хүнсэнд зарцуулж буй бөгөөд нийт хүнсний 97%-ийг сумаас, 7%-ийг аймгаас худалдан авч байна.

Хүснэгт 29 дээр судалгаанд хамрагдсан байрлал нэг бүрээр сар тутмын нийт худалдан авалтын зардлыг нь харуулсан.

**Хүснэгт 29 Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардал - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Аймаг       | Сум       | Олборлолттой<br>холбоотой нийт<br>зардал (төгрөг/сар) | Судалгаанд<br>хамрагсадын тоо | Олборлолттой<br>холбоотой дундаж<br>зардал (төгрөг/сар) |
|-------------|-----------|-------------------------------------------------------|-------------------------------|---------------------------------------------------------|
| Баянхонгор  | Баян-Овоо | 3,863,100                                             | 8                             | 482,887                                                 |
|             | Бөмбөгөр  | 3,080,300                                             | 8                             | 385,037                                                 |
| Говь-Алтай  | Есөнбулаг | 1,958,400                                             | 4                             | 489,600                                                 |
|             | Бигэр     | 5,641,500                                             | 12                            | 470,125                                                 |
| Дорноговь   | Айраг     | 13,617,631                                            | 16                            | 851,102                                                 |
| Дундговь    | Хулд      | 2,753,200                                             | 8                             | 344,150                                                 |
|             | Өлзийт    | 2,280,996                                             | 8                             | 285,124                                                 |
| Дархан-Уул  | Шарын гол | 1,911,291                                             | 6                             | 318,549                                                 |
| Сэлэнгэ     | Мандал    | 9,536,661                                             | 5                             | 1,907,332                                               |
|             | Орхонтуул | 3,659,996                                             | 5                             | 731,999                                                 |
| Төв         | Заамар    | 15,756,655                                            | 8                             | 1,969,582                                               |
|             | Борнуур   | 3,084,659                                             | 8                             | 385,582                                                 |
| <b>Нийт</b> |           | <b>67,144,389</b>                                     | <b>96</b>                     | <b>718,422</b>                                          |

Нэг хүнд ноогдох худалдан авалт нь Заамар, Шарын-Гол сумдад хамгийн өндөр харин Өлзийт суманд хамгийн бага байна. Шарын-Гол сум нь олборлолтод ихээхэн тоног төхөөрөмж шаардах алтны үндсэн ордтой тул энэ чиглэлд томоохон зардал гарч, түүнчлэн тухайн тоног төхөөрөмжийг ажиллуулахад ихээхэн хэмжээний түлш шатахууныг хэрэглэж байгаа нь бусад сумдаас илүү өндөр зардалтайд тооцогдож байна.

Байршил нэг бүр дээрх бичил уурхай эрхлэгчдийн дундаж худалдан авалтын хэмжээнд суурилан, ТББ-уудын тайлан мэдээллийг ашиглан IRIM судалгааны хүрээлэн нь бүхий л

сумдын худалдан авалтын нийт зардлыг ойролцоогоор тооцон гаргасан. Хүснэгт 30 нь тухайн 12 сумд дээр хийгдэж буй бичил уурхайчдын нийт худалдан авалтыг харуулсан.

**Хүснэгт 30. Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардал - сумын түвшинд**

| Байршил     |           | Бичил уурхайчид,<br>ченжийн нийт тоо | Олборлолттой<br>холбоотой<br>дундаж зардал<br>(төгрөг/сар) | Олборлолттой холбоотой<br>нийт зардал (төгрөг/сар) |
|-------------|-----------|--------------------------------------|------------------------------------------------------------|----------------------------------------------------|
| Аймаг       | Сум       |                                      |                                                            |                                                    |
| Баянхонгор  | Баян-Овоо | 830                                  | 482,887                                                    | 400,796,210                                        |
|             | Бөмбөгөр  | 2,100                                | 385,037                                                    | 808,577,700                                        |
| Говь-Алтай  | Есөнбулаг | 1,920                                | 489,600                                                    | 940,032,000                                        |
|             | Бигэр     | NA                                   | NA                                                         | NA                                                 |
| Дорноговь   | Айраг     | 165                                  | 851,102                                                    | 140,431,830                                        |
| Дундговь    | Хулд      | 488                                  | 344,150                                                    | 167,945,200                                        |
|             | Өлзийт    | 388                                  | 285,124                                                    | 110,628,112                                        |
| Дархан-Уул  | Шарын гол | 530                                  | 318,549                                                    | 168,830,970                                        |
| Сэлэнгэ     | Мандал    | 846                                  | 1,907,332                                                  | 1,613,602,872                                      |
|             | Орхонтуул | 300                                  | 731,999                                                    | 219,599,700                                        |
| Төв         | Заамар    | 130                                  | 1,969,582                                                  | 256,045,660                                        |
|             | Борнуур   | 148                                  | 385,582                                                    | 57,066,136                                         |
| <b>Нийт</b> |           | <b>7,845</b>                         | <b>718,422</b>                                             | <b>4,883,556,390</b>                               |

Дээр дурдсан тооцоон дээр үндэслэн эдгээр 11 сумын бүхий бичил уурхайчид нь ойролцоогоор 4.8 тэрбум төгрөгийг ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтад зарцуулж буй бөгөөд тэдний төлсөн 1.7 тэрбум төгрөгийг албан ёсны бичил уурхайчид, 3.1 тэрбум төгрөгийг албан бус бичил уурхайчид сар тутамд төлж байна. Нийт худалдан авалтын 70%-ийг орон нутгийн зах зээл дээрээс хийдэг гэж үзвэл зорилтот сумдын бичил уурхайчид нь сар тутамд 3.4 тэрбум төгрөгийг орон нутгийн эдийн засагт төлбөр хэлбэрээр оруулж байна.

Хүснэгт 31 дээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтыг тоймон харуулсан.

**Хүснэгт 31. Бичил уурхайчид, ченжийн нийт худалдан авалтын зардалын нэгдсэн дүн**

| Түвшин                               | Бичил уурхайчид,<br>ченжийн тоо | Нийт худалдан<br>авалт, (төгрөг/сар) | Тухайн сумдад<br>хийгдэж буй<br>худалдан авалт,<br>(төгрөг/сар) |
|--------------------------------------|---------------------------------|--------------------------------------|-----------------------------------------------------------------|
| Сумын түвшинд                        | 7,845                           | 4,883,556,390                        | 3,418,489,473                                                   |
| Судалгаанд<br>хамрагсадын<br>түвшинд | 96                              | 67,144,389                           | 47,001,072                                                      |

## 5.4 Олон нийтэд хандсан хөрөнгө оруулалтын зардал

Олон нийтэд зориулан жил тутам хийгдэж буй хөрөнгө оруулалт нь энэхүү хэсэг дээр дурдагдсан. Дурдагдсан мөнгөн утга нь судалгаанд хамрагдсан хүмүүсийн зүгээс бичил, гар аргаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанд тодорхой хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтууд хэмээн дурдсан тэрхүү утгыг илэрхийлсэн болно. Тухайн хөрөнгө оруулалт хэзээ хийгдсэн талаар ямар нэгэн дэлгэрэнгүй мэдээлэл байгаагүй. IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхайн салбарын хийсэн эдгээр хөрөнгө оруулалтыг бүлэглэн авч үзсэн:

1. Орон нутгийн эдийн засагт хийх хөрөнгө оруулалт
2. Нөхөн сэргээлт
3. Сургалт болон бичил уурхай эрхлэгчдийн аюулгүй ажиллагаа
4. Олон нийтэд дэмжлэг үзүүлэх

Орон нутгийн эдийн засагт хийгдэж буй хөрөнгө оруулалт нь сумдад явагдаж буй үйл ажиллагаанд хөрөнгө санхүүжилт гаргахыг мөн багтаасан. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн өгсөн жишээнд доорх зүйлс багтаж байна:

- Нийтийн соёлын төв, сургууль эсвэл сумын төвийг засан сайжруулах хөрөнгө гаргах
- Мод тарих
- Орон нутгийн захиргаанд хандив өгөх
- Орон нутгийн дэд бүтцэд хандив өгөх (жишээ нь зам, гудамжны гэрэлтүүлэг гэх мэт)
- Наадам, тэмдэглэлт ой зэрэг орон нутгийн арга хэмээнд хандив өргөх

Дэд бүтцэд хийгдсэн хөрөнгө оруулалттай холбоотойгоор судалгаанд хамрагдсан хүмүүс ямар нэгэн мөнгөн утгыг илэрхийлээгүй учраас дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалтыг тооцох нь хүндрэлтэй байсныг анхаарна уу.

Олон нийтэд үзүүлэх дэмжлэг нь эмзэг бүлэгт түлхүү тулгуурлаж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүс доор дурдсан жишээг өгүүлж байлаа:

- Эмзэг бүлгийн иргэдэд мал өгөх
- Лаа, шүдэнз хандивлах
- Усны эх үүсвэр гарган өгөх

- Хөгшин настай хүмүүст мод түлээ болон нүүрс өгөх
- Олон нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх
- Өнчин хүүхдүүдэд гэр өгөх
- Эмзэг бүлгийн хүүхдүүдэд хүнсний бүтээгдэхүүн өгөх
- Өвчтэй хүмүүсд мөнгө хандивлах

Нөхөн сэргээлт нь уул уурхайн олборлолт явагдсан газрыг нөхөн сэргээж, байгалийн анхдагч төрхөнд нь оруулах үйл явц хэмээн тодорхойлогдож байна. Энэхүү ажил нь чулуулгын овоолгыг тэгшлэн булах болон дахин ургамалжуулах үйл ажиллагааг багтааж буй юм.

Сургалт, бичил уурхайчдын аюулгүй ажиллагаа нь олборлолт явуулах үйл ажиллагааг сайжруулах чиглэлийн үйл ажиллагаа хэмээн тодорхойлогдоно.

Хүснэгт 32, 33, 34 дээр ТББ-уудын, мөн бичил уурхайчид болон ченжийн хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ, төрлийгсудалгаанд хамрагдсан сум нэг бүрээр харуулсан. Судалгааны үр дүнгээс харвал ченж нь үндэсний эдийн засагт илүү хэмжээнд хөрөнгө оруулалт хийдэг байна. Гэхдээ энэ нь зөвхөн гурван суманд хийгдсэн тус бүр 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалт дээр үндэслэн тооцсон баримжаа тооцоо болно.

ТББ-ууд болон ченж нь бичил уурхайчидтай харьцуулбал олон нийтийн үйл ажиллагаанд илүү томоохон хувь нэмрийг оруулж байна.

**Хүснэгт 32 ТББ-ын олон нийтэд хийсэн хөрөнгө оруулалт**

| Эх сурвалж |           | ТББ-ын хөрөнгө оруулалт (төгрөг)                         |                |                                                            |                                  |            |
|------------|-----------|----------------------------------------------------------|----------------|------------------------------------------------------------|----------------------------------|------------|
| Байршил    |           | Орон нутгийн эдийн засагт хийж буй шууд хөрөнгө оруулалт | Нөхөн сэргээлт | Бичил уурхайчдын аюулгүй байдалд хийж буй хөрөнгө оруулалт | Нийгмийг дэмжих хөрөнгө оруулалт | Нийт дүн   |
| Аймаг      | Сум       |                                                          |                |                                                            |                                  |            |
| Баянхонгор | Баян-Овоо | 600,000                                                  | 1,975,000      | 800,000                                                    | 5,030,000                        | 8,405,000  |
|            | Бөмбөгөр  | 2,130,000                                                | 1,700,000      | 700,000                                                    | 4,010,000                        | 8,540,000  |
| Говь-Алтай | Есөнбулаг |                                                          | 12,500,000     | 80,000                                                     | 5,000,000                        | 17,580,000 |
|            | Бигэр     |                                                          |                |                                                            |                                  |            |
| Дорноговь  | Айраг     | 6,500,000                                                | 6,500,000      | 690,000                                                    | 500,000                          | 14,190,000 |
| Дундговь   | Хулд      | 10,800,000                                               | 3,900,000      |                                                            | 1,000,000                        | 15,700,000 |
|            | Өлзийт    | 53,150,000                                               | 5,000,000      |                                                            | 280,000                          | 58,430,000 |

|                 |           |                   |                   |                  |                   |                    |
|-----------------|-----------|-------------------|-------------------|------------------|-------------------|--------------------|
| Дархан-Уул      | Шарын гол | 3,000,000         | 1,800,000         |                  | 500,000           | 5,300,000          |
| Сэлэнгэ         | Мандал    | 1,200,000         | 10,000,000        | 420,000          | 2,800,000         | 14,420,000         |
|                 | Орхонтуул | 200,000           | 200,000           |                  | 200,000           | 600,000            |
| Төв             | Заамар    |                   |                   | 90,000           |                   | 90,000             |
|                 | Борнуур   |                   |                   |                  |                   |                    |
| <b>Нийт дүн</b> |           | <b>77,580,000</b> | <b>43,575,000</b> | <b>2,780,000</b> | <b>19,320,000</b> | <b>143,255,000</b> |

**Хүснэгт 33 Бичил уурхайчдын орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ**

| Эх сурвалж      |           | Бичил уурхайчдын хийж буй хөрөнгө оруулалт (төгрөг)      |                   |                                                            |                                  |                    |
|-----------------|-----------|----------------------------------------------------------|-------------------|------------------------------------------------------------|----------------------------------|--------------------|
| Байршил         |           | Орон нутгийн эдийн засагт хийж буй шууд хөрөнгө оруулалт | Нөхөн сэргээлт    | Бичил уурхайчдын аюулгүй байдалд хийж буй хөрөнгө оруулалт | Нийгмийг дэмжих хөрөнгө оруулалт | Нийт дүн           |
| Аймаг           | Сум       |                                                          |                   |                                                            |                                  |                    |
| Баянхонгор      | Баян-Овоо | 12,000                                                   | 2,700,000         | 10,000                                                     | 787,200                          | 3,509,200          |
|                 | Бөмбөгөр  |                                                          | 300,000           | 261,000                                                    | 95,000                           | 656,000            |
| Говь-Алтай      | Есөнбулаг |                                                          |                   |                                                            |                                  |                    |
|                 | Бигэр     |                                                          | 4,200,000         |                                                            | 48,000                           | 4,248,000          |
| Дорноговь       | Айраг     | 300,000                                                  | 46,800,000        | 535,000                                                    | 423,000                          | 48,058,000         |
| Дундговь        | Хулд      | 17,700,000                                               | 1,000,000         |                                                            | 7,701,522                        | 26,401,522         |
|                 | Өлзийт    |                                                          | 500,000           |                                                            | 570,000                          | 1,070,000          |
| Дархан-Уул      | Шарын гол | 2,150,000                                                | 7,880,000         |                                                            | 2,500,000                        | 12,530,000         |
| Сэлэнгэ         | Мандал    | 10,000                                                   | 425,000           | 100,000                                                    | 100,000                          | 635,000            |
|                 | Орхонтуул | 860,000                                                  | 260,000           |                                                            | 520,000                          | 1,640,000          |
| Төв             | Заамар    |                                                          | 160,000           | 330,000                                                    | 1,300,000                        | 1,790,000          |
|                 | Борнуур   | 520,000                                                  | 500,000           |                                                            | 550,000                          | 1,570,000          |
| <b>Нийт дүн</b> |           | <b>21,552,000</b>                                        | <b>64,725,000</b> | <b>1,236,000</b>                                           | <b>14,594,722</b>                | <b>102,107,722</b> |

**Хүснэгт 34. Investments made by traders in public activities**


| Эх сурвалж |           | Ченж нарын хийж буй хөрөнгө оруулалт (төгрөг)            |                |                                                            |                                  |          |
|------------|-----------|----------------------------------------------------------|----------------|------------------------------------------------------------|----------------------------------|----------|
| Байршил    |           | Орон нутгийн эдийн засагт хийж буй шууд хөрөнгө оруулалт | Нөхөн сэргээлт | Бичил уурхайчдын аюулгүй байдалд хийж буй хөрөнгө оруулалт | Нийгмийг дэмжих хөрөнгө оруулалт | Нийт дүн |
| Аймаг      | Сум       |                                                          |                |                                                            |                                  |          |
| Баянхонгор | Баян-Овоо |                                                          |                |                                                            | 150,000                          | 150,000  |

|                 |           |                    |                   |                |                  |                    |
|-----------------|-----------|--------------------|-------------------|----------------|------------------|--------------------|
|                 | Бөмбөгөр  | 2,400,000          |                   |                | 80,000           | 2,480,000          |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 80,000,000         |                   |                |                  | 80,000,000         |
|                 | Бигэр     |                    |                   |                | 90,000           | 90,000             |
| Дорноговь       | Айраг     | 1,000,000          |                   |                | 1,150,000        | 2,150,000          |
| Дундговь        | Хулд      |                    | 45,000,000        |                |                  | 45,000,000         |
|                 | Өлзийт    | 20,000,000         |                   |                |                  | 20,000,000         |
| Дархан-Уул      | Шарын гол |                    |                   | 40,000         | 10,000           | 50,000             |
| Сэлэнгэ         | Мандал    |                    |                   |                | 1,800,000        | 1,800,000          |
|                 | Орхонтуул | 200,000            |                   |                | 200,000          | 400,000            |
| Төв             | Заамар    | 396,000            |                   |                |                  | 396,000            |
|                 | Борнуур   |                    |                   | 650,000        | 2,400,000        | 3,050,000          |
| <b>Нийт дүн</b> |           | <b>103,996,000</b> | <b>45,000,000</b> | <b>690,000</b> | <b>5,880,000</b> | <b>155,566,000</b> |

Сум нэг бүр дээр хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээнд дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг Зураг 14, 15 болон 16 дээр харуулсан бөгөөд энэхүү дүн шинжилгээн дээрээс сум бүр дээр хийгдэж буй олон нийтэд зориулсан хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа ялгаатай буйг харж болно.


Ченж, бичил уурхайчид болон ТББ-уудын хооронд гурван талт гэрээ байгуулсан сумдын хувьд (Айраг, Өлзийт, Хулд) бүхий л сумдын дундаас илүү өндөр хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Дүрс 14 ТББ-ын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд




Зураг 15 дээр Өлзийт сум дээр ТББ-уудын зүгээс хамгийн томоохон хөрөнгө оруулалтыг олон нийтийн үйл ажиллагаанд хийсэн нь харагдаж буй бөгөөд энэ нь орон нутгийн эдийн засагт хийх буй хөрөнгө оруулалтын нэг хэлбэр юм. Өлзийт суманда бичил уурхайчид, ченжийн дэмжлэгтэйгээр явагдсан олон нийтийн үйл ажиллагаа нь бусадсумдтай адил байсан ч тухайн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн дүнгийн хувьд хавьгүй өндөр буй юм.

Дүрс 15 Бичил уурхайчдын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд



Зураг 15 нь мөн Айраг сум дээр олон нийтийн үйл ажиллагаанд зориулан хамгийн томоохон хэмжээний хөрөнгө оруулалтыг бичил уурхайчид хийж, байгаль орчны нөхөн сэргээлт хийснийг харуулсан. Түүнчлэн Хулд сум дээр бичил уурхайчид ихээхэн хувь оруулан олон төрлийн нийтэд хандсан үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн байна. Дээр дурдсанчлан гурван талт гэрээний хүрээндбүх талууд нөхөн сэргээлт хийх, олон нийтэд дэмжлэг туслалцаа үзүүлэхийг үүрэг болгожээ. Тухайн үйл ажиллагаанд зарцуулах мөнгөн дүн нь ч эдгээр сумдад хавьгүй өндөр, мөн нөхөн сэргээлтийн ажлыг ч харьцангуй сайн чанартайгаар хийж гүйцэтгэжээ.

Дүрс 16 Ченж нарын хийж буй хөрөнгө оруулалтын хэлбэрүүд



Зураг 16 нь Есөнбулаг, Хулд болон Өлзийт сумд дээр ченж ихээхэн өндөр хэмжээний хөрөнгө оруулалтыг хийсэн болохыг харуулж байна. Энэ нь орон нутгийн эдийн засагт хөрөнгө оруулах, нөхөн сэргээлт хийх зэрэг арга замаар хийгдсэн байна.

Тоймлон авч үзвэл олон нийтийн чиглэлийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх нь сум бүр дээр янз бүрийн хэмжээнд байна. ТББ, бичил уурхайчид болон ченжийн хоорондын гурван талт гэрээг хийсэн сумд нь бусад сумдтай харьцуулбал илүү өндөр хэмжээний хөрөнгө оруулалтыг хийжээ. Түүнчлэн хамгийн өндөр хэмжээний мөнгөн дүнг орон нутгийн эдийн засгийн хөгжилд зарцуулсан ба үүнд орон нутгийн дэд бүтцэд хөрөнгө гаргах, хөгжилд түлхэц үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хамарч байна. Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь мөн хоёрдугаарт эрэмбэлэгдэхүйц хэмжээнд мөнгө, хөрөнгө оруулалт хийгдсэн үйл ажиллагаа байна. Харин бичил уурхайчдын сургалт болон аюулгүй ажиллагаа, олон нийтэд дэмжлэг үзүүлэх зэрэгт харьцангуй бага хэмжээний мөнгө хөрөнгө зарцуулжээ.

## 5.5 Бичил уурхайчид, ченжийн үзүүлж буй эдийн засгийн шууд нөлөөллийн тойм

Дээр дурдсан эдийн засгийн шууд нөлөөлөл буюу татвар, төлбөрийн хэмжээний тооцоолол, мөн цэвэр орлого болон олон нийтийн үйл ажиллагаанд зарцуулж буй мөнгө хөрөнгө зэрэг дээр үндэслэн Хүснэгт 33 нь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн зүгээс

нэг сарын хугацаандорон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд нөлөөллийг харуулсан. Хүснэгт 33 нь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн үзүүлэх боломжит шууд хувь нэмрийг харуулсан бөгөөд тухайн 11 сумын бүхий л бичил уурхайчид болон ченж хамаарах татвар, төлбөр хураамж болон даатгалыг төлөх тохиолдолд гэсэн нөхцөлөөр авч үзсэн. Хөдөлмөр эрхлэлт болон худалдан авалт нь илүү нарийвчилсан байх магадлал өндөртэй бөгөөд учир нь эдгээрийг хөдөлмөр эрхлэлтийн дундаж цалин хөлс, бичил уурхай эрхлэгчдийн дундаж худалдан авалтын хэмжээ зэргийг сум бүр дээр нийт бичил уурхайчид, худалдан авагчдын тоогоор үржүүлэн гаргасан. Говь-Алтай аймгийн Бигэр суманд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ байхгүй, төрийн байгууллагын албан тушаалтнууд нь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн талаар хангалттай мэдээлэл байхгүй байсан нь орон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд хувь нэмрийг тооцоход хүндрэл учруулсан. Тиймээс бичил уурхай эрхлэгчид болон ченжийн боломжит хувь нэмрийг сард 8 сая төгрөг байна хэмээн тооцсон.

**Хүснэгт 35 Бичил уурхайчид, ченжийн шууд нөлөөллийн нэгдсэн дүн - сумын хэмжээнд**

| Байршил               |           | Татвар, хураамж<br>(төгрөг/сар) | Ажил эрхлэлт<br>(төгрөг/сар) |                      | Худалдан авалт<br>(төгрөг/сар) | Нийт<br>(төгрөг/сар) |
|-----------------------|-----------|---------------------------------|------------------------------|----------------------|--------------------------------|----------------------|
| Аймаг                 | Сум       |                                 | Ажлын байр                   | Цэвэр орлого         |                                |                      |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 27,585,050                      | 832                          | 247,852,400          | 400,796,210                    | 676,233,660          |
|                       | Бөмбөгөр  | 26,296,020                      | 2112                         | 424,575,610          | 808,577,700                    | 1,259,449,330        |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 37,410,845                      | 1935                         | 865,504,523          | 940,032,000                    | 1,842,947,368        |
|                       | Бигэр     | Na                              | Na                           | Na                   | Na                             | Na                   |
| Дорноговь             | Айраг     | 2,688,835                       | 169                          | 110,256,536          | 140,431,830                    | 253,377,201          |
| Дундговь              | Хулд      | 21,051,240                      | 489                          | 388,586,396          | 167,945,200                    | 577,582,836          |
|                       | Өлзийт    | 11,555,530                      | 392                          | 341,770,904          | 110,628,112                    | 463,954,546          |
| Сэлэнгэ               | Мандал    | 5,123,510                       | 534                          | 163,539,096          | 168,830,970                    | 337,493,576          |
|                       | Шарын гол | 161,282                         | 851                          | 215,526,450          | 1,613,602,872                  | 1,829,290,604        |
|                       | Орхонтуул | 3,222,300                       | 301                          | 119,227,200          | 219,599,700                    | 342,049,200          |
| Төв                   | Заамар    | 1,428,925                       | 150                          | 152,602,760          | 256,045,660                    | 410,077,345          |
|                       | Борнуур   | 1,504,864                       | 152                          | 48,187,000           | 57,066,136                     | 106,758,000          |
| <b>Нийт</b>           |           | <b>138,028,401</b>              | <b>7917</b>                  | <b>3,077,628,875</b> | <b>4,883,556,390</b>           | <b>8,099,213,666</b> |

Source: Research team calculation

Хүснэгт 36 нь судалгаанд хамрагдсан нийт бичил уурхай эрхлэгчид болон ченжийн үзүүлж буй эдийн засгийн шууд нөлөөллийг тоймлон харуулсан. Тус судалгаанд нийт 111 бичил уурхай эрхлэгч, ченж хамрагдсан бөгөөд тэдний үзүүлж буй эдийн засгийн шууд

нөлөөллийг Хүснэгт 36 дээр тооцон оруулсан. Сар тутмын нийт шууд нөлөөлөл нь 134,533,089 төгрөг байна. Биет хөрөнгө оруулалт, дэд бүтэц, нөхөн сэргээлт болон бусад төрлийн олон нийтэд хандсан хөрөнгө оруулалтыг сар тутмын дүнгээр тооцох боломжгүй байв. Бүхий л хөрөнгө оруулалтыг хэдэн жилийн хугацаанд нэг удаа хийсэн бөгөөд энэхүү хөрөнгө оруулалт нь тогтворгүй юм. Тухайлбал, чанарын судалгааны дүнгээс зарим бичил уурхай эрхлэгч, ченж 10 гаруй жил бичил уурхайн үйл ажиллагааг эрхлэхдээ зөвхөн нэг удаа л нөхөн сэргээлтэд хөрөнгө оруулалт хийсэн бол зарим бичил уурхай эрхлэгчид болон ченж нь тухайн хугацаанд нэгээс илүү удаа нөхөн сэргээлтэд хөрөнгө оруулалт хийж байжээ. Тийм учраас IRIM судалгааны хүрээлэн нь олон нийтэд хандсан үйл ажиллагааг тусад нь тооцож, тухайн нийт хугацаанд нийт 801,857,444 төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн болохыг тооцон гаргасан.

**Хүснэгт 36. Бичил уурхайчид, ченжийн шууд нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсaдын хэмжээнд**

| Байршил               |           | Татвар,<br>хураамж<br>(төгрөг/сар) | Ажил<br>эрхлэлт<br>(төгрөг/сар) | Худалдан<br>авалт<br>(төгрөг/сар) | Нийт<br>(төгрөг/сар) | Олон нийтийн<br>хөрөнгө<br>оруулалт |
|-----------------------|-----------|------------------------------------|---------------------------------|-----------------------------------|----------------------|-------------------------------------|
| Аймаг                 | Сум       |                                    |                                 |                                   |                      |                                     |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 981,880                            | 3,046,611                       | 3,863,100                         | <b>7,891,591</b>     | 24,128                              |
|                       | Бөмбөгөр  | 183,030                            | 4,497,199                       | 3,080,300                         | <b>7,760,529</b>     | 23,352                              |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 211,416                            | 2,549,902                       | 1,958,400                         | <b>4,719,718</b>     | 195,160                             |
|                       | Бигэр     | 91,200                             | 4,485,813                       | 5,641,500                         | <b>10,218,513</b>    | 8,676                               |
| Дорноговь             | Айраг     | 420,390                            | 11,934,857                      | 13,617,631                        | <b>25,972,878</b>    | 128,796                             |
| Дундговь              | Хулд      | 4,140,806                          | 9,101,707                       | 2,753,200                         | <b>15,995,713</b>    | 174,203                             |
|                       | Өлзийт    | 698,346                            | 4,341,749                       | 2,280,996                         | <b>7,321,091</b>     | 159,000                             |
| Сэлэнгэ               | Мандал    | 90,000                             | 2,477,673                       | 1,911,291                         | <b>4,478,964</b>     | 35,760                              |
|                       | Шарын гол | 2,000                              | 3,971,889                       | 9,536,661                         | <b>13,510,550</b>    | 33,710                              |
|                       | Орхонтуул | 55,266                             | 2,513,456                       | 3,659,996                         | <b>6,228,718</b>     | 5,280                               |
| Төв                   | Заамар    | 166,670                            | 7,744,330                       | 15,756,655                        | <b>23,667,655</b>    | 4,552                               |
|                       | Борнуур   | 92,340                             | 3,590,170                       | 3,084,659                         | <b>6,767,169</b>     | 9,240                               |
| <b>Нийт</b>           |           | <b>7,133,344</b>                   | <b>60,255,356</b>               | <b>67,144,389</b>                 | <b>134,533,089</b>   | <b>801,857</b>                      |

## 6.ЭДИЙН ЗАСГИЙН ШУУД БУС ХУВЬ НЭМЭР

Шууд бус эдийн засгийн хувь нэмэр гэдэгт ханган нийлүүлэгчдийн бий болгосон ажлын байр, төлсөн татвар хураамж, зарцуулсан үйл ажиллагааны зардал, бичил уурхайчид болон ченжтэй хамтран ажиллах явцдаа бий болгосон ажлын байрны тоо зэргийг харгалзан үзсэн.

Энэхүү судалгаанд судалгааны баг нь жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчид болон малчдын дунд судалгаа явуулан, бичил уурхайчид болон ченжийн үзүүлж буй шуудбус эдийн засгийн нөлөөллийг тооцон гаргасан. Энэхүү судалгаа нь 24 бизнес эрхлэгч болон 36 малчны өгсөн хариултыг багтаасан. Тайлангийн энэхүү хэсэг нь ханган нийлүүлэгч талын доор дурдсан бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарсан:

- ЖД бизнесүүдийн ажлын байран дээрх хөдөлмөр эрхлэлт
- ЖД бизнесүүд болон малчид худалдан авалт хийх замаар орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмэр
- ЖДҮ болон малчдын төлж буй татвар, төлбөр хураамж

### Ханган нийлүүлэгчдийн тухай тойм мэдээлэл

Судалгаанд хамрагдсан жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгч нар нь дунджаар тухайн бизнесийг 11 жил эрхлэж буй бөгөөд хамгийн удаан нь 22 жил, хамгийн богино нь 1 жил байна. Тэд өдөрт дунджаар 70 хүнд үйлчилгээ үзүүлдэг байна. Тухайн жижиг, дунд бизнесүүд нь үндсэндээ жижиг хэмжээний хүнсний дэлгүүрүүд, зарим тохиолдолд бичил уурхайчдад зориулсан тоног төхөөрөмж борлуулагч нарыг багтааж байна. Эдийн засгийн шууд нөлөөллийн хэсэгт дурдсанчлан хүнс болон тоног төхөөрөмж нь бичил уурхай эрхлэгчдийн хувьд хамгийн том зардалтай худалдан авалт болдог тул эдгээр жижиг хүнсний дэлгүүрүүд нь гар аргаар ашигт малтмал олборлох салбартай хамгийн нягт уялдаатай ажилладаг байна.

### 6.1 Ажил эрхлэлт

37 дугаар хүснэгтийн хувьд судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчид нь нийт 42 байнгын ажлын байр, 5 цагийн ажлын байрыг бий болгож, нийт 9.1 сая төгрөгийг сар тутамд цалинд хөлсөнд зарцуулж байна. Нийтдээ бүхий л судалгаанд хамрагдсан хүмүүсийг оруулаад хамрагдсан 24 жижиг, дунд бизнес эрхлэгчид нь 71 ажлын байрыг бий болгожээ. Тухайн бизнес нэг бүр нь дунджаар 2 ажлын байрыг бий болгосон байна.

### Хүснэгт 37 Жижиг дунд бизнесд бий болсон ажлын байр, цалин хөлс

| Байршил               |           | Аж ахуйн нэгжийн ажлын байр                                     |                                                  |                                | Нийт цалин<br>(төгрөг/сар) |
|-----------------------|-----------|-----------------------------------------------------------------|--------------------------------------------------|--------------------------------|----------------------------|
| Аймаг                 | Сум       | Бүтэн<br>цагаар<br>ажилладаг<br>ажилчидын<br>тоо <sup>(a)</sup> | Хагас<br>цагаар<br>ажилладаг<br>ажилчидын<br>тоо | Нийт<br>ажлын<br>байрны<br>тоо |                            |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 1                                                               | 0                                                | 1                              | 0                          |
|                       | Бөмбөгөр  | 6                                                               | 0                                                | 6                              | 950,000                    |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 2                                                               | 0                                                | 2                              | 0                          |
|                       | Бигэр     | 3                                                               | 0                                                | 3                              | 200,000                    |
| Дорноговь             | Айраг     | 15                                                              | 1                                                | 16                             | 900,000                    |
| Дундговь              | Хулд      | 5                                                               | 0                                                | 5                              | 1,920,000                  |
|                       | Өлзийт    | 6                                                               | 1                                                | 7                              | 0                          |
| Сэлэнгэ               | Мандал    | 1                                                               | 2                                                | 3                              | 500,000                    |
|                       | Шарын гол | 5                                                               | 0                                                | 5                              | 192,000                    |
|                       | Орхонтуул | 2                                                               | 0                                                | 2                              | 483,000                    |
| Төв                   | Заамар    | 8                                                               | 0                                                | 8                              | 1,000,000                  |
|                       | Борнуур   | 12                                                              | 1                                                | 13                             | 3,000,000                  |
| <b>Нийт</b>           |           | <b>66</b>                                                       | <b>5</b>                                         | <b>71</b>                      | <b>9,145,000</b>           |

(a) Судалгаанд хамрагдсаныг хамт оруулан тооцсон

## 6.2 Ханган нийлүүлэгчдийн үйлчлүүлэгчид болон орлогын байдал

Жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаагаар тэдний нийт үйлчлүүлэгчдийн 30% нь малчид, 34% нь бичил уурхай эрхлэгчид, 36% нь орон нутгийн иргэд байдаг ажээ. Хүснэгт 38 дээр хэрэглэгчдийн ангилал болон нийт үйлчлүүлэгчдийн тоонд хамаарах хувь хэмжээг дэлгэрэнгүй харуулсан.

### Хүснэгт 38 ЖДБ эрхлэгчдийн худалдан авагчдын ангилал

| Худалдан<br>авагчдын<br>ангилал | Худалдан авагчидын үзүүлэлт |              |            |              |
|---------------------------------|-----------------------------|--------------|------------|--------------|
|                                 | Дундаж                      | Медиан       | Хамгийн их | Хамгийн бага |
| Малчид                          | <b>30%</b>                  | <b>22.5%</b> | <b>60%</b> | <b>5%</b>    |
| Бичил<br>уурхайчид              | <b>34%</b>                  | <b>30%</b>   | <b>90%</b> | <b>5%</b>    |
| Нутгийн иргэд                   | <b>36%</b>                  | <b>32.5</b>  | <b>80%</b> | <b>0%</b>    |

Хүснэгт 38 нь бичил уурхай эрхлэгчид нь тухайн бизнес эрхлэгчдийн гол үйлчлүүлэгч болохыг харуулсан. Нийт үйлчлүүлэгчдийн 50-иас дээш хувь нь бичил уурхайчдаас бүрдэх 6 жижиг, дунд бизнесийн байгууллага байна. Уурхайчид ихэнхдээ бэлэн мөнгөөр эсвэл богино хугацаат зээлээр бараа бүтээгдэхүүн худалдан авч байна.


Малчдын дунд хийсэн судалгаагаар тэдний 36% нь бичил уурхайчидтай наймаа арилжаа хийдэг байна. Ихэнх нь мах болон сүүн бүтээгдэхүүнийг бичил уурхайчдад бэлэн мөнгөөр арилжаалдаг ажээ.

Жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн дунд хийсэн судалгаанд дурдсанчлан бичил уурхайчдын хийж буй худалдан авалт нь тэдний нийт борлуулалтын орлогын 33 орчим хувийг дунджаар эзэлдэг ба хамгийн дээд хувь хэмжээ нь 100%, хамгийн доод хэмжээ нь 1% байна.

Импортлогчид болон өөрийн ханган нийлүүлэгч нараас худалдан авалт, бараа таталт хийх нь сард дунджаар 2.5 удаа байсан бол хамгийн ихдээ сард 12, хамгийн багадаа сард эсвэл улиралд нэг удаа хийгддэг байна. Судалгааны дүнгээс харвал бизнес эрхлэгчдийн 42% нь бичил уурхайчдын тоо нэмэгдсэн хоёр жилийн хугацаанд тэдний үйлчлүүлэгч нарын тоо мөн нэмэгдсэн хэмээн үзжээ. Гэхдээ бизнес эрхлэгчдийн 46% нь сүүлийн хоёр жилийн хугацаанд орлого нь буурсан хэмээн үзсэн ба үлдэх хэсэг нь сүүлийн хоёр жилийн хугацаанд орлогын хэмжээнд нь өөрчлөлт ороогүй хэмээн хэлжээ.

Жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны мөчлөгийн хувьд бичил уурхайчдын ашигт малтмал олборлох болон ченжийн ашигт малтмал борлуулах цикл мөчлөгтэй яг ижил нөхцөл байдал ажиглагдаж байна. Тиймээс бизнесийн үйл ажиллагаа хавраас эхлэн сэргэж, зун огцом нэмэгдэж, намар удаашран, өвөл зогсдог байна. Зураг 17 дээр эдгээр байршлууддээрх бизнесийн мөчлөгийг тоймлон харуулсан.

Дүрс 17. Улирлын чанартай ЖДБ эрхлэгчдийн бизнесийн мөчлөгүүд




Өвлийн улирал бичил уурхайн үйл ажиллагаа хумигдаж, ченжийн үйл ажиллагаа зогсох үеэр уурхайн ойролцоо ажиллаж буй жижиг, дунд бизнесүүд ч мөн зогсолт хийж байна. Бизнесийн үйл ажиллагаа удаашрах эсвэл зогсох тохиолдолд тэдний 58 орчим хувь нь ямар нэгэн ажил хийдэггүй, 29% нь бусад хувийн бизнесээ хийдэг, үлдэх хэсэг нь төрийн болон хувийн байгууллагад ажилладаг байна.

Малчдын дунд хийсэн судалгаагаар малчдын дундаж орлого нь сард 566,140 төгрөг байснаас хамгийн өндөр нь 2,250,000 төгрөг хамгийн бага нь 80,000 төгрөг байна. Бичил уурхай эрхлэгчидтэй наймаа худалдаа хийж буй малчдын хувьд тэдний хийсэн худалдан авалт нь нийт орлогынх нь дунджаар 31%-ийг эзэлж буй бол хамгийн дээд хувь хэмжээ нь 80%, хамгийн доод хувь нь 5% байна.

Малчдын 20% нь сүүлийн хоёр жил бичил уурхайчдын тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор тэдний мөнгөн орлого нэмэгдсэн гэсэн ч малчдын 26% нь сүүлийн 2 жил тэдний орлого буурсан, 54% нь сүүлийн хоёр жилд орлогод нь ажиглагдахуйц өөрчлөлт гараагүй хэмээжээ.

Зураг 18 дээр үзүүлсэнчлэн бичил уурхайчдын зүгээс малчидтай наймаа арилжаа хийх худалдааны мөчлөгт хийсэн үнэлгээ нь бичил уурхай эрхлэгчид, ченж болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэлж байсантай ижил хандлагатай байна. Малчдын ихэнх нь бичил уурхайчид, ченжтэй өвлийн улирал бараг худалдаа арилжаа хийдэггүй гэсэн ижил логик ажиглагдаж байна.

Дүрс 18. Улирлын чанартай бичил уурхайчид болон малчидын хоорондох худалдааны мөчлөгүүд



Судалгаагаар бичил уурхай эрхлэгчидтэй хийх худалдаа удааршах эсвэл зогсвол малчдын 91% нь малаа хариулах ажлаа үргэлжлүүлэн хийдэг байна. Мөн малчдын 31% нь бичил уурхай тэдний орлогоод эерэг нөлөө үзүүлдэг гэсэн бол 34% нь бичил уурхай ямар нэгэн нөлөө байхгүй хэмээжээ. Гэхдээ малчдын 28% нь бичил уурхайчид тэдний орлогод сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн хариуг мөн өгчээ.

### 6.3 Жижиг, дунд хэмжээний бизнесүүдийн үйл ажиллагааны зардлууд

Ханган нийлүүлэгч нарын үйл ажиллагааны зардлыг үнэлэхийн тулд IRIM судалгааны хүрээлэн нь ханган нийлүүлэгчдийн зардлын задаргааг тооцон гаргасан. Эрчим хүч, дулаан, ус, тээвэр, цалин хөлс, түрээс зэрэг зардлуудыг үйл ажиллагааны зардалд хамруулсан.

Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчид нь ойролцоогоор 23 сая төгрөгийг сар тутам өөрийн үйл ажиллагаанд зарцуулдаг болохыг Хүснэгт 39 дээр харуулсан. Үйл ажиллагааны зардлын дотроос хамгийн өндөр зардал нь тээвэр дээр гарч байна. Дараагийн хамгийн өндөр зардал нь ажиллагсадын цалин байгаа бол хамгийн бага зардал нь түрээс дээр байна. Байршлын хувд Борнуур сумын жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчид хамгийн өндөр үйл ажиллагааны зардлыг гаргаж буй бол Баян-Овоо сумын бизнес эрхлэгчид хамгийн бага үйл ажиллагааны зардалтай байна. Үүний шалтгаан нь Баян-Овоо сумын бизнес эрхлэгчид нь уурхайн талбар дээр байршдаг, эрчим хүч, дулаан болон цалин (нэмэлт хүн ажилуулахгүй тохиолдолд) зэрэгт зардал гаргадаггүй байна.

Хүснэгт 39. ЖДБ эрхлэгчдийн үйл ажиллагааны зардал

| Байршил               |           | Үйл ажиллагааны зардал (төгрөг/сар) |           |         |            |           |         | Нийт       |
|-----------------------|-----------|-------------------------------------|-----------|---------|------------|-----------|---------|------------|
| Аймаг                 | Сум       | Тог, цахилгаан                      | Дулаан    | Ус      | Тээвэр     | Цалин     | Түрээс  |            |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 0                                   | 0         | 0       | 700,000    | 0         | 0       | 700,000    |
|                       | Бөмбөгөр  | 130,000                             | 0         | 15,500  | 1,150,000  | 950,000   | 0       | 2,245,500  |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 10,000                              | 0         | 0       | 2,150,000  | 0         | 0       | 2,160,000  |
|                       | Бигэр     | 69,000                              | 0         | 4,000   | 280,000    | 200,000   | 0       | 553,000    |
| Дорноговь             | Айраг     | 345,000                             | 125,000   | 121,200 | 690,000    | 900,000   | 0       | 2,181,200  |
| Дундговь              | Хулд      | 240,000                             | 98,300    | 7,500   | 1,350,000  | 1,920,000 | 0       | 3,615,800  |
|                       | Өлзийт    | 110,000                             | 36,600    | 2,400   | 400,000    | 0         | 0       | 549,000    |
| Сэлэнгэ               | Мандал    | 90,000                              | 200,000   | 7,000   | 1,000,000  | 500,000   | 0       | 1,797,000  |
|                       | Шарын гол | 150,000                             | 0         | 20,000  | 300,000    | 192,000   | 0       | 662,000    |
|                       | Орхонтуул | 70,000                              | 150,000   | 0       | 120,000    | 483,000   | 150,000 | 973,000    |
| Төв                   | Заамар    | 135,000                             | 0         | 40,000  | 1,300,000  | 1,000,000 | 0       | 2,475,000  |
|                       | Борнуур   | 1,200,000                           | 500,000   | 0       | 650,000    | 3,000,000 | 0       | 5,350,000  |
| Нийт                  |           | 2,549,000                           | 1,109,900 | 217,600 | 10,090,000 | 9,145,000 | 150,000 | 23,261,500 |

## 6.4 Татвар, төлбөр хураамж

Бичил уурхайчид, ченжийн үүсгэн бий болгосон бизнесийн боломжуудыг жижиг, дунд бизнес эрхлэгчид бодит хэрэг болгон ашиглаж, үүний үр дүнд тэд мөн орон нутагт төлбөр, хураамж төлж байна. Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнесийн байгууллагууд нь сард ойролцоогоор 3 сая төгрөгийн татварыг сумандаа төлдөг байна. Тэдний төлсөн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл болон төлбөр хураамжийг Хүснэгт 40 дээр харууллаа.

Хүснэгт 40. ЖДБ эрхлэгчдийн татвар, хураамж төлөлт

| Байршил               |           | Татвар хураамж (төгрөг/сар) |                       |         |         |                             |           |
|-----------------------|-----------|-----------------------------|-----------------------|---------|---------|-----------------------------|-----------|
| Аймаг                 | Сум       | Татвар                      | Эрүүл мэндийн даатгал | Хураамж | Хандив  | Нийгмийн туст үйл ажиллагаа | Нийт      |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 0                           | 0                     | 0       | 0       | 0                           | 0         |
|                       | Бөмбөгөр  | 42,000                      | 87,800                | 0       | 4,166   | 0                           | 133,966   |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 22,000                      | 85,500                | 128,000 | 0       | 0                           | 235,500   |
|                       | Бигэр     | 10,000                      | 61,500                | 0       | 0       | 0                           | 71,500    |
| Дорноговь             | Айраг     | 75,333                      | 288,000               | 43,183  | 125,000 | 35,833                      | 567,349   |
| Дундговь              | Хулд      | 33,333                      | 507,000               | 0       | 125,000 | 0                           | 665,333   |
|                       | Өлзийт    | 45,583                      | 323,080               | 0       | 50,000  | 13,330                      | 431,993   |
| Сэлэнгэ               | Мандал    | 35,000                      | 80,000                | 0       | 3,300   | 20,000                      | 138,300   |
|                       | Шарын гол | 63,330                      | 62,330                | 4,166   | 7,500   | 2,500                       | 139,826   |
|                       | Орхонтуул | 0                           | 100,000               | 6,000   | 0       | 0                           | 106,000   |
| Төв                   | Заамар    | 20,000                      | 70,000                | 13,000  | 183,330 | 0                           | 286,330   |
|                       | Борнуур   | 90,000                      | 170,000               | 0       | 83,300  | 0                           | 343,300   |
| Нийт                  |           | 436,579                     | 1,835,210             | 194,349 | 581,596 | 71,663                      | 3,119,397 |

Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчид нийгмийн даатгалын шимтгэлийг идэвхтэйгээр төлдөг байна. Тэд сар тутамд 1.8 сая төгрөгийг нийгмийн даатгалд төлдөг бол дундаж нь сард 152,934 төгрөг болж байна. Мөн тухайн бизнес эрхлэгчид ижил хэмжээний мөнгийг орлогын албан татвар болон хандивт зарцуулж байна.

Бичил уурхай эрхлэгчид, ченж болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн төлсөн татвар нь мөн орон нутгийн захиргааны худалдан авалт, төсвийн зарцуулалт зэрэгтэй нийлэн нэмэлт нөлөөллийг үзүүлж буй юм. Эдгээр төрлийн нөлөөллийг дам нөлөөллийн хэсэг дээр дурдсан.

## 6.5 Шууд бус нөлөөллийн тойм

Дээр дурдсан ханган нийлүүлэгч нарын төлсөн татвар хураамж, тэдний үйл ажиллагааны зардал, бий болгосон ажлын байр зэрэг дээр үндэслэн Хүснэгт 41 дээр судалгаанд оролцогчдын хувьд сар тутам орон нутгийн эдийн засагт зарцуулж буй нийт зардлыг нь тооцон гаргасан.

**Хүснэгт 41 Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Байршил               |           | Татвар,<br>хураамж<br>(төгрөг/сар) | Ажил эрхлэлт  |                                   | Үйл<br>ажиллашаагы<br>зардал<br>(төгрөг/сар) | Нийт<br>(төгрөг/сар) |
|-----------------------|-----------|------------------------------------|---------------|-----------------------------------|----------------------------------------------|----------------------|
| Аймаг                 | Сум       |                                    | Ажлын<br>байр | Ажилчдын<br>цалин<br>(төгрөг/сар) |                                              |                      |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 0                                  | 1             | 0                                 | 700,000                                      | 700,000              |
|                       | Бөмбөгөр  | 133,966                            | 6             | 950,000                           | 1,295,500                                    | 2,379,466            |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 235,500                            | 2             | 0                                 | 2,160,000                                    | 2,395,500            |
|                       | Бигэр     | 71,500                             | 3             | 200,000                           | 353,000                                      | 624,500              |
| Дорноговь             | Айраг     | 567,349                            | 16            | 900,000                           | 1,281,200                                    | 2,748,549            |
| Дундговь              | Хулд      | 665,333                            | 5             | 1,920,000                         | 1,695,800                                    | 4,281,133            |
|                       | Өлзийт    | 431,993                            | 7             | 0                                 | 549,000                                      | 980,993              |
| Сэлэнгэ               | Мандал    | 138,300                            | 3             | 500,000                           | 1,297,000                                    | 1,935,300            |
|                       | Шарын гол | 139,826                            | 5             | 192,000                           | 470,000                                      | 801,826              |
|                       | Орхонтуул | 106,000                            | 2             | 483,000                           | 490,000                                      | 1,079,000            |
| Төв                   | Заамар    | 286,330                            | 8             | 1,000,000                         | 1,475,000                                    | 2,761,330            |
|                       | Борнуур   | 343,300                            | 13            | 3,000,000                         | 2,350,000                                    | 5,693,300            |
| <b>Нийт</b>           |           | <b>3,119,397</b>                   | <b>71</b>     | <b>9,145,000</b>                  | <b>14,116,500</b>                            | <b>26,380,897</b>    |

Хүснэгт 41-ийн хувьд судалгаанд хамрагдсан хүмүүсийн сар тутмын нийт зардал нь ханган нийлүүлэгчдийн төлсөн татвар, хураамжийн хувьд 3.1 сая, өөрийн ажилтнуудад өгсөн цалингийн хувьд 9.1 сая, үйл ажиллагааны зардлын хувьд 14.1 сая төгрөг болж байна. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн нийт зардал нь сард 26.3 сая төгрөг байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн үзүүлж буй шууд бус нөлөөллийг тооцохын тулд IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхайчид болон ченжтэй хийсэн арилжаанаасолсон орлогыг л хамруулан авч үзсн. Хүснэгт 42 нь жижиг, дунд хэмжээний бизнес эрхлэгчдийн оруулж буй шууд бус нөлөөллийг тоймлон харуулсан.

**Хүснэгт 42. Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсадын түвшинд**

| Байршил               |           | Татвар,<br>хураамж<br>(төгрөг/сар) | Ажил эрхлэлт  |                                   | Үйл<br>ажиллагааны<br>зардал<br>(төгрөг/сар) | Нийт<br>(төгрөг/сар) |
|-----------------------|-----------|------------------------------------|---------------|-----------------------------------|----------------------------------------------|----------------------|
| Аймаг                 | Сум       |                                    | Ажлын<br>байр | Ажилчдын<br>цалин<br>(төгрөг/сар) |                                              |                      |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 0                                  | 1             | 0                                 | 630,000                                      | 630,000              |
|                       | Бөмбөгөр  | 21434.56                           | 6             | 152000                            | 207,280                                      | 380,715              |

|             |           |                  |           |                  |                  |                   |
|-------------|-----------|------------------|-----------|------------------|------------------|-------------------|
| Говь-Алтай  | Есөнбулаг | 17662.5          | 2         | 0                | 162,000          | 179,663           |
|             | Бигэр     | 17875            | 3         | 50000            | 88,250           | 156,125           |
| Дорноговь   | Айраг     | 241123.3         | 16        | 382500           | 544,510          | 1,168,133         |
| Дундговь    | Хулд      | 259479.9         | 5         | 748800           | 661,362          | 1,669,642         |
|             | Өлзийт    | 172797.2         | 7         | 0                | 219,600          | 392,397           |
| Сэлэнгэ     | Мандал    | 96810            | 3         | 350000           | 907,900          | 1,354,710         |
|             | Шарын гол | 62921.7          | 5         | 86400            | 211,500          | 360,822           |
|             | Орхонтуул | 31800            | 2         | 144900           | 147,000          | 323,700           |
| Төв         | Заамар    | 42949.5          | 8         | 150000           | 221,250          | 414,200           |
|             | Борнуур   | 120155           | 13        | 1050000          | 822,500          | 5,693,300         |
| <b>Нийт</b> |           | <b>1,085,009</b> | <b>71</b> | <b>3,114,600</b> | <b>4,823,152</b> | <b>12,723,406</b> |

Дээрх хүснэгтийн хувьд судалгаанд хамрагсан хүмүүсийн оруулж буй шууд бус хувь нэмэр нь ханган нийлүүлэгчдийн төлсөн нийт 1.085 сая төгрөгийн татвар хураамж, 4.8 сая төгрөгийн үйл ажиллагаанд зарцуулсан зардал, 3.1 сая төгрөгийн цалингийн зардлын нийлбэрээр тодорхойлогдож байна. Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнесийн байгууллагуудын нийт шууд бус хувь нэмэр нь 12.7 сая төгрөг байна. Байршлын хувьд хамгийн өндөр шууд бус нөлөөлөл Борнуур суманд буй бол бол дарагийнх нь Хулд суманд ажиглагдаж байна.

Жижиг дунд бизнесийн газруудын үйл ажиллагааны дундаж зардал, төлсөн татвар хураамж дээр үндэслэн, мөн сум бүр дээрх жижиг дунд бизнесийн газруудын тоог харгалзан IRIM судалгааны хүрээлэн нь судалгаанд хамрагдсан бүх сумдын нийт шууд бус нөлөөг тооцон гаргасан. Хүснэгт 43 нь энэхүү судалгааны үр дүнг тоймлон харуулсан болно.

**Хүснэгт 43 Шууд бус нөлөөллийн нэгдсэн дүн – сумын түвшинд**

| Байршил               |           | ЖДБ эрхлэгчид <sup>a</sup> | Татвар, хураамжийн дундаж төлөлт (төгрөг/сар) <sup>b</sup> | Ажил эрхлэлт            |                                                 | Үйл ажиллагааны дундаж зардал (төгрөг/сар) <sup>e</sup> | Нийт (төгрөг/сар) |
|-----------------------|-----------|----------------------------|------------------------------------------------------------|-------------------------|-------------------------------------------------|---------------------------------------------------------|-------------------|
| Аймаг                 | Сум       |                            |                                                            | Ажлын байр <sup>c</sup> | Ажилчдын дундаж цалин (төгрөг/сар) <sup>d</sup> |                                                         |                   |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 1                          | 0                                                          | 1                       | 0                                               | 630,000                                                 | 630,000           |
|                       | Бөмбөгөр  | 1                          | 7144.8                                                     | 6                       | 50666.72                                        | 69,093                                                  | 380,238           |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 199                        | 8831.25                                                    | 199                     | 14400                                           | 81,000                                                  | 20,742,019        |
|                       | Бигэр     | 10                         | 8937.5                                                     | 20                      | 25000                                           | 44,125                                                  | 1,030,625         |
| Дорноговь             | Айраг     | 18                         | 60280.73                                                   | 36                      | 95625                                           | 136,128                                                 | 6,977,857         |

|                    |           |            |               |            |                |                |                    |
|--------------------|-----------|------------|---------------|------------|----------------|----------------|--------------------|
| Дундговь           | Хулд      | 8          | 129740.1      | 16         | 374400         | 330,681        | 9,673,769          |
|                    | Өлзийт    | 6          | 86398.8       | 12         | 0              | 109,800        | 1,177,193          |
| Сэлэнгэ            | Мандал    | 85         | 96810         | 170        | 350000         | 907,900        | 144,900,350        |
|                    | Шарын гол | 24         | 31460.85      | 48         | 43200          | 105,750        | 5,366,660          |
|                    | Орхонтуул | 12         | 31800         | 24         | 144900         | 147,000        | 5,623,200          |
| Төв                | Заамар    | 16         | 21474.75      | 32         | 75000          | 110,625        | 4,513,596          |
|                    | Борнуур   | 4          | 60077.5       | 8          | 525000         | 411,250        | 6,085,310          |
| <b>Нийт/дундаж</b> |           | <b>384</b> | <b>45,246</b> | <b>572</b> | <b>141,516</b> | <b>256,946</b> | <b>207,100,817</b> |

(а)-Эх сурвалж: Орон нутгийн статистикийн хороо

(b)-Татвар, хураамжийн дунджийг бодохдоо судалгаанд хамрагдсан ЖДБ эрхлэгчдийн төлдөг татварын хэмжээний дунджаар бодсон

(c)-Судалгаанд хамрагдсан ЖДБ дунджаар 2 ажлын байр бий болгосон байсан бөгөөд үүнийг тухайн орон нутгийн нийт ЖДБ эрхлэгчдийн тоогоор үржүүлж бодсон

(d)-Ажилчдын сарын дундаж цалинг бодохдоо судалгаанд хамрагдсан ЖДБ эрхлэгчдийн сарын дундаж цалин дээр үндэслэж бодсон

(e)-Сарын үйл ажиллагааны дундаж зардлыг бодохдоо судалгаанд хамрагдсан ЖДБ эрхлэгчдийн мэдээлэл дээр үндэслэн бодсон

Эдгээр сумдад нийт 384 жижиг дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулан, бичил уурхай эрхлэгчид болон ченжтэй наймаа арилжаа хийж байна. Тэдгээр бизнесүүд нь нийт 572 шинэ ажлын байрыг бий болгож, сард ойролцоогоор 141,516 төгрөгийг цалинд зарцуулж буй нь бичил уурхайн, ченжтэй хамтран ажилласны хүрээнд гарч буй нөлөөлөл юм. Бичил уурхайчид, ченжтэй хамтран ажиллаж буй бизнесийн байгууллагууд нь сард ойролцоогоор 45,246 төгрөгийг татвар, төлбөр хураамжид төлж байна. Мөн тэд сар тутамд ойролцоогоор 256,946 төгрөгийг өөрийн үйл ажиллагаанд зориулан зарцуулж байна.

Тиймээс бичил уурхайн үйл ажиллагаанаас эдгээр судалгаанд хамрагдсан бизнесүүдийн сумдад үзүүлэх боломжит шууд бус нөлөөлөл нь сард ойролцоогоор 207 сая төгрөг болж байна.

## 7. ЭДИЙН ЗАСГИЙН ДАМ НӨЛӨӨЛӨЛ

Орон нутгийн эдийн засагт бичил уурхайчид, ченжийн үзүүлж буй нөлөөлөл нь тэдний зүгээс худалдан авалт, татвар болон ажил эрхлэлтэд зарцуулж буй нийт дүнгээс ч илүү байна. Үүний шалтгаан нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн зарцуулсан мөнгийг хүлээн авсан этгээд эргүүлээд тухайн мөнгийг орон нутгийн эдийн засагт зарцуулж буйтай холбоотой. Эдийн засгийн дам нөлөө гэдэг нь ажилчид, ханган нийлүүлэгчид, малчид болон бусад талууд тухайн олсон орлогоо эдийн засагт эргүүлэн зарцуулан оруулж, үүний зэрэгцээ бичил уурхайчид, ченж, бизнес эрхлэгчид татвар төлсөнөөр төрийн худалдан авалтын үйл ажиллагаа хийгдэж, эдийн засгийн эргэлт явагдаж байхыг хэлнэ.

Үндсэндээ дам нөлөө гэдэг нь нэмэлт үйлдвэрлэл явуулсанаас үүдэн өрхийн түвшин дэхь зарцуулалтад гарч буй өөрчлөлтийг илэрхийлнэ. Энэ нь бичил уурхай эрхлэгчид, ченжтэй шууд хамаарал бүхий өрхийн гишүүд эсвэл нийгмийн бусад салбар, эдийн засгийн салбарынхан олсон орлогоо дахин зарцуулсанаас үүдэн гарах нөлөөлөл юм. Бид орон нутгийн эдийн засаг дахь өрхийн зардлыг ашиглан дам нөлөөллийг тооцон гаргасан. Үүний хүрээнд өрхийн зардлын гурван төрлийг тооцон үзсэн болно. Бичил уурхай эрхлэгчид, ченжийн гэр бүлийн гишүүдийн зарцуулж буй мөнгөн дүн, бичил уурхай эрхлэгчид, ченжтэй мах, сүүний наймаа арилжаа хийн орлого олсон малчдын цаашдын мөнгө зарцуулалт зэргийг эдийн засгийн дам нөлөөнд хамруулан тооцон үзсэн.

### 7.1 Өрхийн хэрэглээ

Ашигтмалтмал олборлох үйл ажиллагаанаас олсон өрхийн орлогыг дараагийн шатанд нь өрхийн хэрэглээнд зарцуулж байна. Бичил уурхай эрхлэгчийн өрхийн зардал нь орон нутгийн эдийн засагт шууд болон шууд бусаар оруулж буй хувьнэмэр бус, харин эдийн засгийн үүднээс энэ нь тодорхой нэгэн эдийн засгийн үйл ажиллагаанаас үзүүлж буй дам нөлөөлөл юм. Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь энэхүү хэсэг дээр бичил уурхайчдын өрхийн зүгээс үзүүлж буй дам нөлөөллийг энэхүү хэсэг дээр дурдлаа.

Хүснэгт 44 нь бичил уурхайчдын гэр бүл, өрхийн хэрэглээнд зарцуулж буй мөнгөн дүнг харуулсан. Энэхүү тооцооллоор хоёр өөр дам нөлөөллийг тооцсон бөгөөд үүнд сар тутмын өрхийн нийт хэрэглээ болон өрх доторх нийт хөрөнгө оруулалт хоёр юм. Бичил уурхай эрхлэгчийн зүгээс орон нутгийн эдийн засагт оруулж буй хөрөнгө оруулалтыг Эдийн засгийн шууд нөлөөлөл гэсэн хэсэг дээр үзүүлсэн. Гэхдээ өрхийн дотор хийгдэж буй хөрөнгө

оруулалтыг үүнд тооцоогүй тул тухайн хөрөнгө оруулалтыг (орон нутгийн эдийн засагт шууд нөлөө үзүүлдэггүй тул) энэхүү хэсэг дээр өрхийн хөрөнгө оруулалт хэмээн тооцож шаардлагатай болсон. Энэхүү хөрөнгө оруулалт нь бусад үйл ажиллагаагаар дамжуулан орон нутгийн эдийн засагт нөлөөлж байдаг. Хүснэгт 44 дээр үзүүлсэнчлэн өрхийн сарын нийт хэрэглээ нь 53,373,322 төгрөг буй бөгөөд өрх дотор нэг жилд хийгдэж буй нийт хөрөнгө оруулалт 223,340,000 төгрөг байна. Өрх дотор хийгдсэн хөрөнгө оруулалт нь өрхөд шинээр орлого олох боломжийг хангах бөгөөд орон нутгийн эдийн засагт чухал үүрэг бүхий шинэ ажлын байрыг бий болгодог. Сар тутмын өрхийн зарцуулалт болон дээр буй ялгаа нь тухайн гэр бүлийн гишүүдийн тоо, орлогын түвшин, орон нутгийн дэлгүүрийн үнэ, хүнсний үнэ зэргээс хамааралтай байна. Гэхдээ Айраг суман дахь нийт зарцуулалт өндөр байгаа нь юуны өмнө Айраг сум нь Дорноговь аймгаас сонгосон цорын ганц сум, харин үлдэх аймгуудаас хоёр сум сонгогдсонд оршино. Энгийн үгээр хэлбэл аймгийн түвшин дэхь зарцуулалтын хэмжээ нь бусад аймгуудаас бодит хэрэг дээр тийм ч өндөр бус юм.

**Хүснэгт 44 Бичил уурхайчин, ченжийн дам нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд**

| Эх сурвалж      |           | Бичил уурхайчид, ченж      |                          |                                                    |                                      |
|-----------------|-----------|----------------------------|--------------------------|----------------------------------------------------|--------------------------------------|
| Байршил         |           | Өрхийн сарын дундаж зардал | Өрхийн сарын нийт зардал | Өрхөд оруулсан сүүлийн нэг жилийн хөрөнгө оруулалт | Нийт өрхөд оруулсан хөрөнгө оруулалт |
| Аймаг           | Сум       |                            |                          |                                                    |                                      |
| Баянхонгор      | Баян-Овоо | 123193                     | 6,898,815                | 2,433,300                                          | 7,300,000                            |
|                 | Бөмбөгөр  | 76110                      | 4,186,050                | 1,963,750                                          | 15,710,000                           |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 82657                      | 2,893,000                | 1,536,600                                          | 4,610,000                            |
|                 | Бигэр     | 79056                      | 6,008,233                | 3,233,300                                          | 9,700,000                            |
| Дорноговь       | Айраг     | 103032                     | 11,539,515               | 9,550,000                                          | <b>66,850,000</b>                    |
| Дундговь        | Хулд      | 102892                     | 5,659,031                | 9,960,000                                          | 49,800,000                           |
|                 | Өлзийт    | 79278                      | 3,805,361                | 3,647,500                                          | 14,590,000                           |
| Дархан-Уул      | Шарын гол | 100907                     | 1,107,000                | -                                                  | <b>20,000,000</b>                    |
| Сэлэнгэ         | Мандал    | 41472                      | 1,741,825                | -                                                  | 8,780,000                            |
|                 | Орхонтуул | 83411                      | 2,919,388                | -                                                  | -                                    |
| Төв             | Заамар    | 71932                      | 4,028,198                | 1,360,000                                          | 6,800,000                            |
|                 | Борнуур   | 46195                      | 2,586,906                | 3,200,000                                          | 19,200,000                           |
| <b>Нийт дүн</b> |           |                            | <b>53,373,322</b>        |                                                    | <b>223,340,000</b>                   |

Хүснэгт 45 дээр бичил уурхайчид болон ченжийн сумын түвшинд үзүүлж буй эдийн засгийн дам нөлөөллийг харуулсан. Сар тутмын нийт дам нөлөөлөл нь мөнгөн дүнгээр 648,530,283 төгрөг болж байна. Жилд өрх дотор хийгдэж буй хөрөнгө нь судалгаанд хамрагдсан

хүмүүсийн тооцон хэлсэнтэй буй бөгөөд учир нь бичил уурхайчиннь гэр бүлийн доторх хөрөнгө оруулалтыг бүхий л жилийн туршид хийж байна. Хэрэв үүнийг сумын түвшинд тооцон үзвэл өрх доторх хөрөнгө оруулалтыг хэт өндрөөр тооцсон болно.

#### Хүснэгт 45 Бичил уурхайчин, ченжийн дам нөлөөлөл - сумын түвшинд

| Эх сурвалж      |           | Бичил уурхайчид, ченж      |                          |                                                    |                                      |
|-----------------|-----------|----------------------------|--------------------------|----------------------------------------------------|--------------------------------------|
| Байршил         |           | Өрхийн сарын дундаж зардал | Өрхийн сарын нийт зардал | Өрхөд оруулсан сүүлийн нэг жилийн хөрөнгө оруулалт | Нийт өрхөд оруулсан хөрөнгө оруулалт |
| Аймаг           | Сум       |                            |                          |                                                    |                                      |
| Баянхонгор      | Баян-Овоо | 123193                     | 102,250,088              | 2,433,300                                          | 7,300,000                            |
|                 | Бөмбөгөр  | 76110                      | 159,830,055              | 1,963,750                                          | 15,710,000                           |
| Говь-Алтай      | Есөнбулаг | 82657                      | 158,702,016              | 1,536,600                                          | 4,610,000                            |
|                 | Бигэр     | 79056                      | 0                        | 3,233,300                                          | 9,700,000                            |
| Дорноговь       | Айраг     | 103032                     | 17,000,205               | 9,550,000                                          | <b>66,850,000</b>                    |
| Дундговь        | Хулд      | 102892                     | 50,211,133               | 9,960,000                                          | 49,800,000                           |
|                 | Өлзийт    | 79278                      | 30,759,909               | 3,647,500                                          | 14,590,000                           |
| Дархан-Уул      | Шарын гол | 100907                     | 53,480,572               | -                                                  | <b>20,000,000</b>                    |
| Сэлэнгэ         | Мандал    | 41472                      | 35,085,122               | -                                                  | 8,780,000                            |
|                 | Орхонтуул | 83411                      | 25,023,233               | -                                                  | -                                    |
| Төв             | Заамар    | 71932                      | 9,351,127                | 1,360,000                                          | 6,800,000                            |
|                 | Борнуур   | 46195                      | 6,836,823                | 3,200,000                                          | 19,200,000                           |
| <b>Нийт дүн</b> |           |                            | <b>648,530,283</b>       |                                                    | <b>223,340,000</b>                   |

## 7.2 Малчдын хэрэглээ

Малчид нь уул уурхайн үйл ажиллагааны эерэг болон сөрөг нөлөөнд зэрэг өртөж буй хүн амын нэг хэсэг юм. Чанарын судалгааны тайлангаас харвал бичил болон гар аргаар ашигт малтмал олборлох үйл явцын эерэг нөлөө нь малчид тухайн үйл ажиллагаанд оролцох эсвэл бичил уурхайчид малчдаас худалдан авалт хийх замаар малчдын орлогын эх үүсвэрийг нөхөх нэг эх үүсвэр болдог байна. Өөрсдийн уламжлалт мал аж ахуйг эрхлэхийн зэрэгцээ малчид мөн бичил уурхай эрхлэх үйл ажиллагаа явуулж буй нь тэдний хувьд орлогын томоохон эх үүсвэр болж байна. Худалдан авалтын хувьд өөр сумаас ирсэн бичил уурхай эрхлэгчид эсвэл өөр ямар нэгэн ажил хийдэггүй бичил уурхайчид нь мах болон сүүн бүтээгдэхүүнийг малчдаас худалдан авч байна. Судалгаанд хамрагдсан малчдын 36% нь бичил уурхайчид болон ченжтэй наймаа арилжаа хийдэг хэмээн хэлсэн байна. Тэдний хоорондын наймаа арилжаанд махны худалдаа хамгийн томоохон үүргийг гүйцэтгэж байна.

Тоон судалгааны дүнгээс харвал малчдын үзэж буйгаар бичил уурхайчид, ченж байнга бэлэн мөнгөөр мах, сүү худалдан авдаг ажээ. Бичил уурхайчид, ченжтэй наймаа арилжаа хийдэг хэмээн мэдүүлсэн 36%-ийн дотор дунджаар 31% нь өрхийн орлогоо бичил уурхай эрхлэгчид, ченжийн худалдан авалтаас бүрдүүлдэг хэмээн үзжээ. Бичил уурхай, гар аргаар ашигт малтмалолборлох үйл ажиллагаа нь хэдийн малчдын өрхийн амьжиргаанд нөлөөлөх чухал хүчин зүйлболоод буйг эндээс харж болно.

**Хүснэгт46. Малчидын дам нөлөөлөл – судалгаанд хамрагсадын түвшинд**

| Эх сурвалж |           | Малчид                     |                          |
|------------|-----------|----------------------------|--------------------------|
| Байршил    |           | Өрхийн сарын дундаж зардал | Өрхийн сарын нийт зардал |
| Аймаг      | Сум       |                            |                          |
| Баянхонгор | Баян-Овоо | 266,458                    | 6,395,000                |
|            | Бөмбөгөр  | 222,777                    | 4,010,000                |
| Говь-Алтай | Есөнбулаг | 121,666                    | 1,460,000                |
|            | Бигэр     | 118,888                    | 2,140,000                |
| Дорноговь  | Айраг     | 204,361                    | 7,357,000                |
| Дундговь   | Хулд      | 196,200                    | 3,924,000                |
|            | Өлзийт    | 321,428                    | 6,750,000                |
| Дархан-Уул | Шарын гол | 128,833                    | 1,546,000                |
| Сэлэнгэ    | Мандал    | 311,250                    | 3,735,000                |
|            | Орхонтуул | 79,166                     | 950,000                  |
| Төв        | Заамар    | 144,277                    | 2,597,000                |
|            | Борнуур   | 129,444                    | 2,330,000                |
| Нийт дүн   |           |                            | 43,194,000               |

Үүнээс үзвэл зорилтот 12 сумын малчдын нийт өрхийн хэрэглээ сард 43,194,000 төгрөг болж буй нь бичил болон гар аргаар ашигт малтмал ашиглах үйл ажиллагаанаас орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дам нөлөөлөл болоод буйг харуулж байна. Малчдын өрхийн зардал нь сард 950,000- 6,395,000 төгрөгийн хооронд хэлбэлзэж буй бөгөөд зарцуулалтын хэмжээ нь гэр бүлийн гишүүдийн тоо, орлогын түвшин, сум эсвэл багийн төв хүртэлх зай зэрэг хүчин зүйлсээс хамааралтай байна (Хүснэгт 46-г үзнэ үү).

**Хүснэгт47Малчидын дам нөлөөлөл – сумын түвшинд**

| Эх сурвалж |     | Малчид                     |                          |
|------------|-----|----------------------------|--------------------------|
| Байршил    |     | Өрхийн сарын дундаж зардал | Өрхийн сарын нийт зардал |
| Аймаг      | Сум |                            |                          |

|            |           |        |             |
|------------|-----------|--------|-------------|
| Баянхонгор | Баян-Овоо | 266458 | 95924880    |
|            | Бөмбөгөр  | 222777 | 90447462    |
| Говь-Алтай | Есөнбулаг | 121666 | 51586384    |
|            | Бигэр     | 118888 | 62891752    |
| Дорноговь  | Айраг     | 204361 | 59060329    |
| Дундговь   | Хулд      | 196200 | 64353600    |
|            | Өлзийт    | 321428 | 131142624   |
| Дархан-Уул | Шарын гол | 128833 | 59907345    |
| Сэлэнгэ    | Мандал    | 311250 | 117030000   |
|            | Орхонтуул | 79166  | 11320738    |
| Төв        | Заамар    | 144277 | 72282777    |
|            | Борнуур   | 129444 | 60450348    |
| Нийт дүн   |           |        | 876,398,239 |

Хүснэгт 47 дээр малчдын өрхийн хэрэглээнээс сумын түвшинд үзүүлж буй дам нөлөөллийг сумын түвшинд харуулсан. Тухайн хэрэглээнд бичил уурхайчид, ченжтэй хийсэн арилжаа наймаанаас олсон мөнгийг түлхүү ашиглаж байна. Бүх зорилтот сумд дахь малчдын өрхийн нийт хэрэглээ нь 876,398,239 төгрөг байна.

### 7.3 Дам нөлөөллийн тойм

Хүснэгт 48 дээр үзүүлсэнчлэн, бичил уурхай эрхлэгчид, ченжийн өрхийн сарын дундаж зардал дээр суурилан авч үзсэний үр дүнд IRIM судалгааны хүрээлэн нь судалгаанд хамрагдсан бүх сумдын эдийн засагт оруулж буй нийт дам нөлөөллийг тооцон гаргасан (оролцогчдын түвшинд). Гар аргаар болон бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааны нийт дам нөлөөлөл нь сард 96.5 сая төгрөг байна. Мөн бичил уурхай эрхлэгчид, ченжийн хувь нэмэр оруулсан өрхийн түвшний нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 223.3 сая төгрөг бөгөөд үүнд биет болон төсвийн хөрөнгө оруулалт, шинэ бизнес эрхлэх зорилгоор хийсэн хөрөнгө оруулалт, эрхэлж буй бизнесээ сайжруулах зорилгоор хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авалт болонгэр бүлийн дотор хийсэн бусад хөрөнгө оруулалт зэргийг хамарч байна.

Байршлын хувьд бичил уурхай эрхлэгчдийн зүгээс үзүүлж буй хамгийн өндөр хэмжээний дам нөлөө нь Айраг сумын эдийн засагт ажиглагдаж буй бол дараагийн хамгийн өндөр шууд бус нөлөөлөл нь Хулдсумын эдийн засагт харагдаж байна.

**Хүснэгт 48. Дам нөлөөллийн нэгдсэн дүн – судалгаанд хамрагсадын түвшинд**

| Байршил    |           | Бичил уурхайчид, ченж           | Малчид                          | Нийт дүн (төгрөг/сар) | Бичил уурхайчид, ченж                             |
|------------|-----------|---------------------------------|---------------------------------|-----------------------|---------------------------------------------------|
| Аймаг      | Сум       | Өрхийн нийт зардал (төгрөг/сар) | Өрхийн нийт зардал (төгрөг/сар) |                       | Нийт өрхөд оруулсан хөрөнгө оруулалт (төгрөг/сар) |
| Баянхонгор | Баян-Овоо | 6,898,815                       | 6395000                         | 13,293,815            | 15,264,000                                        |
|            | Бөмбөгөр  | 4,186,050                       | 4010000                         | 8,196,050             | 20,318,000                                        |
| Говь-Алтай | Есөнбулаг | 2,893,000                       | 1460000                         | 4,353,000             | 8,890,000                                         |
|            | Бигэр     | 6,008,233                       | 2140000                         | 8,148,233             | 21,827,000                                        |
| Дорноговь  | Айраг     | 11,539,515                      | 7357000                         | 18,896,515            | 83,227,399                                        |
| Дундговь   | Хулд      | 5,659,031                       | 3924000                         | 9,583,031             | 57,957,750                                        |
|            | Өлзийт    | 3,805,361                       | 6750000                         | 10,555,361            | 20,075,600                                        |
| Дархан-Уул | Шарын гол | 1,107,000                       | 1546000                         | 2,653,000             | 21,350,000                                        |
| Сэлэнгэ    | Мандал    | 1,741,825                       | 3735000                         | 5,476,825             | 12,447,000                                        |
|            | Орхонтуул | 2,919,388                       | 950000                          | 3,869,388             | 4,066,000                                         |
| Төв        | Заамар    | 4,028,198                       | 2597000                         | 6,625,198             | 13,271,000                                        |
|            | Борнуур   | 2,586,906                       | 2330000                         | 4,916,906             | 22,540,000                                        |
| Нийт дүн   |           | 53,373,322                      | 43,194,000                      | 96,567,322            | 223,340,000                                       |

Зорилтот 12 суманд нийт 7845 бичил уурхайчин, 4696 малчин байна (Хүснэгт 49-ийг харна уу). Тиймээс IRIM судалгааны хүрээлэн нь сумын түвшний нийт дам нөлөөг малчид, бичил уурхай эрхлэгчид болон ченжийн тоог сар тутмын өрхийн дундаж зардлаар үржүүлэх замаар тооцон гаргасан. Зорилтот сум дахь бичил уурхайн үйл ажиллагаанаас сумын түвшинд үзүүлж буй дам нөлөөлөл нь сард ойролцоогоор 1.524 тэрбум төгрөг байна.

**Хүснэгт 49. Дам нөлөөллийн нэгдсэн дүн – сумын түвшинд**

| Байршил    |           | Бичил уурхайчид, ченжийн тоо <sup>a</sup> | Малчидын тоо <sup>b</sup> | Бичил уурхайчид, ченж                   | Малчид                                  | Нийт (төгрөг/сар) |
|------------|-----------|-------------------------------------------|---------------------------|-----------------------------------------|-----------------------------------------|-------------------|
| Аймаг      | Сум       |                                           |                           | Өрхийн сарын дундаж зардал <sup>c</sup> | Өрхийн сарын дундаж зардал <sup>d</sup> |                   |
| Баянхонгор | Баян-Овоо | 830                                       | 360                       | 123,193                                 | 266,458                                 | 198,174,968       |
|            | Бөмбөгөр  | 2,100                                     | 406                       | 76,110                                  | 222,777                                 | 250,277,517       |
| Говь-Алтай | Есөнбулаг | 1,920                                     | 424                       | 82,657                                  | 121,666                                 | 210,288,400       |
|            | Бигэр     | NA                                        | 529                       | 79,056                                  | 118,888                                 | 62,891,752        |
| Дорноговь  | Айраг     | 165                                       | 289                       | 103,032                                 | 204,361                                 | 76,060,534        |
| Дундговь   | Хулд      | 488                                       | 328                       | 102,892                                 | 196,200                                 | 114,564,733       |
|            | Өлзийт    | 388                                       | 408                       | 79,278                                  | 321,428                                 | 161,902,533       |
| Сэлэнгэ    | Мандал    | 530                                       | 465                       | 100,907                                 | 128,833                                 | 113,387,917       |
|            | Шарын гол | 846                                       | 376                       | 41,472                                  | 311,250                                 | 152,115,122       |
|            | Орхонтуул | 300                                       | 143                       | 83,411                                  | 79,166                                  | 36,343,971        |
| Төв        | Заамар    | 130                                       | 501                       | 71,932                                  | 144,277                                 | 81,633,904        |
|            | Борнуур   | 148                                       | 467                       | 46,195                                  | 129,444                                 | 67,287,171        |
| Нийт       |           | 7845                                      | 4696                      |                                         |                                         | 1,524,928,522     |

- (a)-ТББ-ын мэдээлэл дээр үндэслэв
- (b)-Эх сурвалж: Орон нутгийн статистикийн хороо
- (c)-Өрхийн сарын дундаж зардлыг судалгаанд хамрагдсан уурхайчдын мэдээлэл дээр үндэслэсэн
- (d)-Малчидын өрхийн сарын дундаж зардлыг судалгаанд хамрагдсан малчидын мэдээлэл дээр үндэслэсэн

## **8. Бичил уурхайчид, ченжийн үзүүлж буй үржигдэх нөлөөний орон нутгийн эдийн засаг дахь нөлөөлөл**

Судалгааг хийж гүйцэтгэх явцад IRIM судалгааны хүрээлэн нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй боловч хараахан хэмжиж тооцоогүй эерэг болон сөрөг нөлөөллүүд буй болохыг ажигласан юм. Эдгээр эерэг нөлөөллийн заримыг нь мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй юм. Судалгаанд хамрагдсан малчдын бараг тал хувь нь бичил уурхай эрхлэгчидтэй хийдэг арилжаа, худалдаанд сэтгэл хангалуун байсан. Мөн судалгаанд хамрагдсан бүх бизнес эрхлэгчид ч бичил уурхайчидтай мөн худалдаа арилжаа хийдэг байна. Түүнчлэн бичил уурхай эрхлэгчид, ченж нь орон нутгийн эдийн засгийн гол оролцогч болдог ажээ.

Өмнөх гурван хэсэгт бичил уурхай эрхлэгчид, ченжээс үзүүлж буй шууд, шууд бус болон дам нөлөөллүүдэд дүн шинжилгээ хийж, тооцон гаргасан. Шуд, шууд бус болон дам нөлөөллүүдийг нийлүүлээд үржүүлэгч нөлөө хэмээн үзнэ. Үржигдэх нөлөөллийн цар хүрээ шууд, шууд бус болон дам нөлөө нэг бүрээр юуны өмнө тооцон гаргаж, улмаар эдгээрийн нийлбэрээр үржигдэх нөлөөллийн цар хүрээг гарган тооцдог. Энэхүү хэсэг дээр судалгаанд хамрагдсан хүмүүсийн нөлөөллийн тооцоолол дээр үндэслэн сум нэг бүрээр үржигдэх нөлөөллийг тооцон гаргасан.

Бичил уурхай эрхлэгчид, ченжийн үзүүлж буй тооцон гаргасан эдийн засгийн нөлөөлөл нь сард 243 сая төгрөг байна. Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид, ченж нь шууд болон шууд бусаар зорилтот сумдад ойролцоогоор 218 ажлын байрыг бий болгосон байна. 218 ажлын байрнаас 145 ажлын байр нь шууд хөдөлмөр эрхлүүлэн ажиллуулах байдлаар 71 нь бичил уурхайчдын ханган нийлүүлэгч нар дээр үүссэн байна. Эдгээр ажлын байрыг тооцон үзвэл сар тутамд 38.5 сая төгрөгийг цалинд зарцуулж байна. Бичил уурхай эрхлэгчид, ченж нь шууд болон шууд бусаар сар тутам 32,5 сая төгрөгийг татвар, хураамжид төлж байна. Энэхүү 32.5 сая төгрөгөөс 29 саяыг нь бичил уурхай эрхлэгчид, ченж шууд төлдөг бол 3.1 сая төгрөгийг нь ханган нийлүүлэгчид шууд бусаар төлдөг байна.

Бичил уурхай эрхлэгчид, ченжийн эдийн засгийн үржигдэх нөлөө нь 1,81 байх тооцоо гарсан (Хүснэгт 50). Энэ нь тэдний хөрөнгө оруулалт хийж буй 100 төгрөг тутам нь орон нутгийн эдийн засагт сар тутамд 181 төгрөг болж үржигдэж буй гэсэн үг юм.

**Хүснэгт 50** Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд

| Нөлөөллийн хэлбэр | Эдийн засгийн нөлөөлөл (төгрөг/сар) | Эдийн засгийн үржүүлэх |
|-------------------|-------------------------------------|------------------------|
| Шууд              | 134,533,089                         | 1                      |
| Шууд бус          | 12,723,406                          | 0.09                   |
| Дам нөлөө         | 96,567,322                          | 0.72                   |
| <b>Нийт</b>       | <b>243,823,817</b>                  | <b>1.81</b>            |

Хүснэгт 51 дээр сар тутам бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс үзүүлж буй эдийн засгийн нөлөөллийг харууллаа.

**Хүснэгт 51.** Бичил уурхайчид, ченжийн нэг сарынэдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - судалгаанд хамрагсадын түвшинд

| Байршил     |           | Эдийн засгийн нөлөөлөл (төгрөг/сар) |                   |                   | Эдийн засгийн үржүүлэх |             |             | Нийт        |
|-------------|-----------|-------------------------------------|-------------------|-------------------|------------------------|-------------|-------------|-------------|
|             |           | Шууд                                | Шууд бус          | Дам нөлөө         | Шууд                   | Шууд бус    | Дам нөлөө   |             |
| Аймаг       | Сум       |                                     |                   |                   |                        |             |             |             |
| Баянхонгор  | Баян-Овоо | 7,891,591                           | 630,000           | 13,293,815        | 1                      | 0.08        | 1.68        | 2.76        |
| khongor     | Бөмбөгөр  | 7,760,529                           | 380,715           | 8,196,050         | 1                      | 0.05        | 1.06        | 2.11        |
| Говь-Алтай  | Есөнбулаг | 4,719,718                           | 179,663           | 4,353,000         | 1                      | 0.04        | 0.92        | 1.96        |
|             | Бигэр     | 10,218,513                          | 156,125           | 8,148,233         | 1                      | 0.02        | 0.80        | 1.81        |
| Дорноговь   | Айраг     | 25,972,878                          | 1,168,133         | 18,896,515        | 1                      | 0.04        | 0.73        | 1.77        |
| Дундговь    | Хулд      | 15,995,713                          | 1,669,642         | 9,583,031         | 1                      | 0.10        | 0.60        | 1.70        |
|             | Өлзийт    | 7,321,091                           | 392,397           | 10,555,361        | 1                      | 0.05        | 1.44        | 2.50        |
| Сэлэнгэ     | Мандал    | 4,478,964                           | 1,354,710         | 2,653,000         | 1                      | 0.30        | 0.59        | 1.89        |
|             | Шарын гол | 13,510,550                          | 360,822           | 5,476,825         | 1                      | 0.03        | 0.41        | 1.43        |
|             | Орхонтуул | 6,228,718                           | 323,700           | 3,869,388         | 1                      | 0.05        | 0.62        | 1.67        |
| Төв         | Заамар    | 23,667,655                          | 414,200           | 6,625,198         | 1                      | 0.02        | 0.28        | 1.30        |
|             | Борнуур   | 6,767,169                           | 5,693,300         | 4,916,906         | 1                      | 0.84        | 0.73        | 2.57        |
| <b>Нийт</b> |           | <b>134,533,089</b>                  | <b>12,723,406</b> | <b>96,567,322</b> | <b>1</b>               | <b>0.09</b> | <b>0.72</b> | <b>1.81</b> |

Бусад сумдтай харьцуулбал Баян-Овоо сумын бичил уурхайчид, ченж хамгийн өндөр эдийн засгийн нөлөөг үзүүлж буй бөгөөд үржигдэх нөлөө нь 1.81 байна. Энэ нь тус сумын бичилуурхай эрхлэгчид, ченжийн орон нутгийн эдийн засагт оруулсан 100 төгрөг нь сард 181 төгрөгийг бий болгож байна гэсэн үг юм. Эсрэгээр Заамар сумын бичил уурхай

эрхлэгчид, ченж хамгийн бага эдийн засгийн нөлөөг үзүүлж буй бөгөөд үржигдэх нөлөө 1.31 байгаа нь тэдний хөрөнгө оруулсан 100 төгрөг тутам нь орон нутгийн эдийн засагт сар тутам 131 төгрөгийг бий болгож байна.

Бүхий л сумдын хувьд судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид, ченжийн тооцон гаргасан эдийн засгийн үр нөлөө сард 9.6 тэрбум төгрөг байна. Бүх сумдын бичил уурхайчид, ченж ойролцоогоор 8489 ажлын байрыг шууд болон шууд бусаар бий болгожээ. Эдгээр 8489 ажлын байрнаас 7917 ажлын байрыг шууд албан болон албан хэлбэрээр бий болгосон бол 572 ажлын байрыг тэдний ханган нийлүүлэгч нар бий болгожээ.

Судалгаанд хамрагдсан бичил уурхай эрхлэгчид, ченжийн үржигдэх нөлөө нь 1.18 байх тооцоо гарсан бөгөөд тэдний хөрөнгө оруулалт хийсэн 100 төгрөг тутам нь сард 118 төгрөгийг орон нутгийн эдийн засагт бий болгож байна (Хүснэгт 52-ыг үзнэ үү).

Хүснэгт 52. Бичил уурхайчид, ченжийн нэг сарын эдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - сумын түвшинд

| Нөлөөллийн хэлбэр | Эдийн засгийн нөлөөлөл<br>(төгрөг/сар) | Эдийн засгийн үржүүлэх |
|-------------------|----------------------------------------|------------------------|
| Шууд              | 8,099,213,666                          | 1                      |
| Шууд бус          | 207,100,817                            | 0.026                  |
| Дам нөлөө         | 1,326,753,554                          | 0.164                  |
| <b>Нийт</b>       | <b>9,633,068,037</b>                   | <b>1.189</b>           |

Хүснэгт 53 дээр сум нэг бүрийн бичил уурхай эрхлэгч болон ченжийн үзүүлж буй эдийн засгийн нөлөөллийг тоймлон харууллаа.

Хүснэгт 53. Бичил уурхайчид, ченжийн нэг сарын эдийн засгийн нөлөөлөл, үржүүлэхийн нөлөөлөл - сумын түвшинд

| Байршил               |           | Эдийн засгийн нөлөөлөл (төгрөг/сар) |            |             | Эдийн засгийн үржүүлэх |          |           | Нийт  |
|-----------------------|-----------|-------------------------------------|------------|-------------|------------------------|----------|-----------|-------|
|                       |           | Шууд                                | Шууд бус   | Дам нөлөө   | Шууд                   | Шууд бус | Дам нөлөө |       |
| Аймаг                 | Сум       |                                     |            |             |                        |          |           |       |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 676,233,660                         | 630,000    | 198,174,968 | 1                      | 0.001    | 0.293     | 1.294 |
|                       | Бөмбөгөр  | 1,259,449,330                       | 380,238    | 250,277,517 | 1                      | 0.000    | 0.199     | 1.199 |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 1,842,947,368                       | 20,742,019 | 210,288,400 | 1                      | 0.011    | 0.114     | 1.125 |
|                       | Бигэр     | Na                                  | 1,030,625  | 62,891,752  | 1                      | Na       | Na        | Na    |
| Дорноговь             | Айраг     | 253,377,201                         | 6,977,857  | 76,060,534  | 1                      | 0.028    | 0.300     | 1.328 |
| Дундговь              | Хулд      | 577,582,836                         | 9,673,769  | 114,564,733 | 1                      | 0.017    | 0.198     | 1.215 |
|                       | Өлзийт    | 463,954,546                         | 1,177,193  | 161,902,533 | 1                      | 0.003    | 0.349     | 1.351 |

|         |           |               |             |               |   |       |       |       |
|---------|-----------|---------------|-------------|---------------|---|-------|-------|-------|
| Сэлэнгэ | Мандал    | 337,493,576   | 144,900,350 | 113,387,917   | 1 | 0.429 | 0.336 | 1.765 |
|         | Шарын гол | 1,829,290,604 | 5,366,660   | 152,115,122   | 1 | 0.003 | 0.083 | 1.086 |
|         | Орхонтуул | 342,049,200   | 5,623,200   | 36,343,971    | 1 | 0.016 | 0.106 | 1.123 |
| Төв     | Заамар    | 410,077,345   | 4,513,596   | 81,633,904    | 1 | 0.011 | 0.199 | 1.210 |
|         | Борнуур   | 106,758,000   | 6,085,310   | 67,287,171    | 1 | 0.057 | 0.630 | 1.687 |
| Нийт    |           | 8,099,213,666 | 207,100,817 | 1,326,753,554 | 1 | 0.026 | 0.164 | 1.189 |

Мандал сумын бичил уурхай эрхлэгчид, ченж бусад сумтай харьцуулбал хэсгийн өндөр хэмжээний эдийн засгийн нөлөөллийг үзүүлж байна. Тэдний үржигдэх нөлөө нь 1.18 байгаа бөгөөд тэдний оруулсан 100 төгрөгийн хөрөнгө оруулалт нь сар тутамд орон нутгийн эдийн засагт 118 төгрөгийг бий болгож байна. Эсрэгээр Шарын-Гол сумын бичил уурхайчид, ченж эдийн засгийн хувь хамгийн бага нөлөөллийг үзүүлж байна. Тэдний үржигдэх нөлөө нь 1.08 байгаа бөгөөд дээрхийн адил 100 төгрөг тутам нь орон нутгийн эдийн засагт 108 төгрөгийг сард бий болгож буй юм.

## 9. ДҮГНЭЛТ

Суурь судалгааны үндсэн зорилго нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн оруулж буй хувь нэмэр, хийж буй хөрөнгө оруулалтын хэмжээ болон төрлийг тодорхойлох явдал байсан. Эдийн засгийн хувь нэмэр болон хөрөнгө оруулалтыг шууд, шууд бус болон дам нөлөөлөл гэсэн үзүүлэлтүүдээр хэмжин тооцохын зэрэгцээ бичил уурхай эрхлэгчид, ченжийн эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй хувь нэмрийг тооцохын тулд үржигдэх нөлөөг мөн тооцож үзсэн. Тогтвортой бичил уурхай төслийн 4 дүгээр үе шатны суурь судалгаагаар доор дурдсан үр дүн гарлаа:

### **Эдийн засгийн шууд нөлөөлөл:**

Шууд үзүүлж буй хувь нэмрийг дөрвөн өөр сувгийн хүрээнд буюу хөдөлмөр эрхлэлт, татвар хураамж, худалдан авалт болон олон нийтэд хандсан хөрөнгө оруулалт гэсэн үзүүлэлтүүдээр тооцон гаргасан. Судалгааны дүнгээс харвал зорилтот 7 сумдад бичил уурхай эрхлэгчид, ченж нийт 7917 ажлын байрыг бий болгож, сар тутам гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас 3 тэрбум төгрөгийн орлого олж байна. Татвар, төлбөр хураамж, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал зэргээр дамжуулан орон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд хувь нэмэр нь сард 138 сая төгрөгт хүрээд байна. Бичил уурхай эрхлэгчид нь олборлолтын тоног төхөөрөмж худалдан авах, багаж хэрэгсэл худалдан авах болон бусад зардлуудаар дамжуулан орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ мөн оруулж буй бөгөөд энэ хэмжээ сар тутамд 4.8 тэрбум төгрөгт хүрээд байна. Нөхөн сэргээлт, биет бүтээн байгуулалт, дэд бүтэц болон олон нийтэд дэмжлэг үзүүлэх чиглэл бүхий төсвийн хөрөнгө оруулалтыг сар тутмын хэмжээгээр нь хэмжин тогтоох боломжгүй байсан. Гэхдээ бичил уурхай эрхлэгчид, ченжийн хийсэн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 801 сая төгрөг байв. Тиймээс зорилтот 7 аймаг дахь орон нутгийн эдийн засагт хийгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь сар тутам 8 тэрбум төгрөгт хүрээд байна.

### **Эдийн засгийн шууд бус нөлөөлөл:**

Эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмрийг төлсөн татвар, үйл ажиллагаандаа зарцуулсан зардал, бичил уурхай эрхлэгчид, ченжтэй хийж буй бизнес, арилжаанаас үүдэлтэйгээр ханган нийлүүлэгчдийн бий болгосон ажлын байрны тоо зэргээр тодорхойлно. Бичил уурхай эрхлэгчид/ченж болон жижиг дунд бизнес эрхлэгчид/малчдын хооронд хийгдэж буй худалдаа арилжаа нь сар тутам 84 сая төгрөгийн үнэлгээ бүхий

хөдөлмөр эрхлэлтийн боломжийг бий болгож байна. Сар тутмын үйл ажиллагааны зардал нь 107 сая, сар тутам төлж буй татвар, хураамжийн хэмжээ нь 14 сая төгрөг байна. Бичил уурхайчид болон ченж нь орон нутгийн эдийн засагт сар тутамд 207 сая төгрөгийн хувь нэмрийг оруулж байна. Энэхүү тооцооллыг хийхдээ судалгаагаар тогтоогдсон орон нутгийн бичил уурхайчид/ченж болон жижиг дунд бизнес эрхлэгчдийн олж буй орлогын хувь хэмжээгээр тооцсон.

#### **Эдийн засгийн дам нөлөөлөл:**

Эдийн засгийн дам нөлөөлөл гэдэг нь бичил уурхай эрхэгчид болон ченж өөрсдийн олсон орлогыг зарцуулахад тухайн зорилтот эдийн засаг доторх мөнгөний урсгал нэмэгдэж буй нөлөөллийг хэлнэ. Дам нөлөөлөл нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй, шууд болон шууд бус нөлөөллийн улмаас үүдэн гарч буй хоёрдогч нөлөөлөл юм. Дам нөлөөлөл нь орон нутгийн захиргааны зардал, төсвийн бүтцийг судлан тооцох зориулалттай ч нутгийн захиргааны хувьд бичил уурхай эрхлэгчид, ченжтэй холбоотой ямар нэгэн мэдээллийг бүртгэн тайлагнадаггүй байна. Бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутгийн эдийн засагт үзүүлж буй дам нөлөөлөл нь сарын 1.5 тэрбум төгрөгөөр тооцогдож байна. Үүнээс гадна бичил уурхай эрхлэгчид, ченж ашигт малтмал олборлох үйл ажиллагаанаас олсон орлогоосоо өөрийн гэр бүлд хөрөнгө оруулалт хийж буй ч үүнийг сар тутмын хэмжээгээр нь тооцон гаргах боломжгүй байв. Үндсэндээ бичил уурхай эрхлэгчид, ченжийн өрхийн сарын зардал нь 648 сая төгрөг байгаа бол малчин өрхүүдийн зардал нь сард 876 сая байна. Мөн бичил уурхай эрхлэгчид, ченж нь өөрийн гэр бүлд хийж буй хөрөнгө оруулалтын томоохон хэсгийг (жилд 648 сая) өөрийн гэр бүлийн бизнесийг дэмжих эсвэл хоолны газар, хүнсний дэлгүүр байгуулах зэргээр ажлын байр бий болгоход зарцуулж байна.

#### **Эдийн засгийн өсөлт болон үржүүлэгч нөлөө:**

Эдийн засгийн өсөлтийг тухайн жилийн ДНБ-ийг өмнөх жилийн ДНБ-тэй харьцуулах замаар тооцдог. Гэхдээ орон нутгийн эдийн засгийн өмнөх жилийн ДНБ-ний тухай мэдээлэл байхгүй, гар аргаар ашигт малтмал олборлох салбараас орон нутгийн эдийн засагт оруулж буй мөнгөн дүнгийн хэмжээ тодорхойгүй байна.

Бичил уурхай эрхлэгчид, ченжийн үзүүлж буй үржүүлэгч нөлөө нь 1.18 байх тооцоо гарсан. Энэ нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн хөрөнгө оруулалт хийсэн 100 төгрөг нь орон нутгийн эдийн засагт сард 118 төгрөгийг бий болгож байна гэсэн үг юм.

#### **Ирээдүйн хөрөнгө оруулалтын сонирхлууд:**

Бичил уурхай эрхлэгчид, ченж нь өөрийн орон нутгийн эдийн засаг, олон нийтэд цаашид ирээдүйд хөрөнгө оруулалт хийх сонирхол өндөр байна. Гэхдээ ярилцлагын үеэр тэдний дурдсанаар хөрөнгө оруулалт хийхэд тулгарч буй гол хүндрэл, саад тотгор нь бичил уурхай эрхлэх замаараа олох орлого нь ихээхэн хэлбэлзэлтэй байдаг явдал байна. Гар аргаар ашигт малтмал олборлогчид, ченжийн орлого нь тогтмол бус, олон тооны саад тотгор, хүндрэлээс хамааран байнга хэлбэлзэж байдаг ажээ. Бичил уурхай эрхлэгчид, ченжийн үзэж буйгаар тэд өөрийн орон нутгийн эдийн засаг, олон нийтэд 191,150,000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийх хандлагатай байна. Тэдний ирээдүйн хөрөнгө оруулалтын сонирхол нь олон янз буй ч судалгаанд оролцогчдын дийлэнх нь авто засварын газар, хоолны газар, жижиг болон дунд хэмжээний үйлдвэр зэрэг шинэ бизнесийг өөрийн өрхийн хэмжээнд үүсгэн, гэр бүлийн гишүүдээ ажилтай болгох чиглэлд хөрөнгө оруулалт хийх сонирхол өндөр байгаа юм. Түүнчлэн зарим оролцогч эрчим хүч, цэвэр усны нөөц, зам, сургууль эмнэлэг сэргээн засаварлах, орон нутгийн хөгжлийн төвд хандив өгөх зэрэг дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх хүсэлтэй буйгаа онцгойлон дурдсан. Тэд мөн зарим биет хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт хийх боломжтой жишээ нь орон нутгийн эмнэлэг, сургуулийн засвар, мод тарих, орчныг цэвэрлэх зэрэг ажлыш төрийн зүгээс хамаарах төсвийн хуваарилан өгөх тохиолдолд хийж гүйцэтгэх боломжтой тухай хэлж байв. Тиймээс нөхцөл байдал тогтвортой байж, сайжрах тохиолдолд бичил уурхай эрхлэгчид өөрийн орон нутагт хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ байна.

## 10. ЗӨВЛӨМЖҮҮД

Суурь судалгааны үр дүндүндэслэн судалгааны багийн зүгээс доор дурдсан зөвлөмжүүдийг өгч байна:

- Судалгаанаас ажиглагдсан нэг зүйл нь Тогтвортой бичил уурхай төсөл нь орон нутгийн төрийн байгууллагуудтай тэр бүр хамтран ажилладаггүй бөгөөд орон нутгийн төрийн байгууллагын ажилтнуудад төсөл болон гар аргаар ашигт малтмал олборлохтой холбоотой мэдээлэл маш хомс байна. Жишээ нь орон нутгийн төрийн байгууллагууд нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн талаар ямар нэгэн бүртгэл мэдээлэлгүй буй бөгөөд тэдний ихэнх нь өөрсдийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл, хураамжийг хувиараа төлж байна. Түүнчлэн ТББ-уудаар дамжуулан төлсөн татвар, төлбөр хураамжийг төрийн байгууллагууд өөрийн мэдээлэлдээ бүртгэхгүй байна.
- Хязгаарлалт хэсэг дээр дурдсанчлан, орон нутгийн төрийн байгууллагуудад ямар нэгэн бүртгэл, мэдээлэл байхгүйн улмаас судалгааны баг нь бичил уурхай эрхлэгчид болон ченжийн зүгээс орон нутгийн эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмрийг тооцох боломжгүй байсан. Тиймээс судалгааны багийн зүгээс Тогтвортой бичил уурхай төсөлд хандан дараа дараагийн судалгаануудад шаардлагатай мэдээллийг хүртээмж, хангамжийн чиглэлээр сайтар судлан үзэж, арга хэмжээ авахыг зөвлөмж болгож байна. Дараа дараагийн судлаачдад орон нутгийн захиргаанаас дэлгэрэнгүй мэдээлэл шаардагдах бөгөөд жишээ нь бичил уурхай эрхлэгчид, ченж татвар, хураамж, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалаар дамжуулан орон нутагт хэдий хэмжээний орлого төвлөрүүлж буй, мөн нутгийн захиргааны зүгээс хэр хэмжээний хөрөнгийг гар аргаар ашигт малтмал олборлогчдод зориулан зарцуулж буй (тухайлбал эмнэлгийн зардал, цагдаад гэх мэт) зэрэг мэдээлэл ихээхэн шаардлагатай байх юм. Мөн сумын хэмжээний ДНБ-ийг тооцох дэлгэрэнгүй мэдээлэл мөн байх шаардлагатай бөгөөд үүнийг ашиглан эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмрийг тооцох боломжтой юм. Хэрэв мэдээлэл байгаа бол дараагийн судалгаа нь **“ДНБ (2014) – ДНБ (2013) = Эдийн засгийн өсөлт”** хэмээх томъёог ашиглан эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмрийг тооцох боломжтой байх юм. Эдийн засгийн өсөлтийг тооцсон тохиолдолд үүнд ашигласан дэлгэрэнгүй багц

мэдээллийг ашиглан бичил уурхай эрхлэгчид болон ченж хэр хэмжээнд үүнд хувь нэмрээ оруулж буй болохыг нарийн тооцон гаргах шаардлагатай болно.

- Суурь судалгаа хийхэд зориулан хуваарилсан төсөв хэт бага, хязгаартай байсан нь судалгааны үйл ажиллагаанд ихээхэн хүндрэлийг учруулсан. Тиймээс Тогтвортой бичил уурхай төсөл нь цаашид хийгдэх судалгаанд зарцуулах төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх талаар судлан үзэх шаардлагатай. Эс бөгөөс бичил уурхай эрхлэгчид, ченжийн зүгээс орон нутагт үзүүлж буй хувь нэмрийг дэлгэрэнгүй, гүнзгийрүүлсэн байдлаар судлан тогтоох боломжгүй юм.
- Судалгаа хийх хугацаа нь Наадам болон орон нутгийн тэмдэглэлт ой зэрэгтэй давхацсаны улмаас судалгааны хугацаа нь зохистой байж чадаагүй. Мөн 7,8 дугаар саруудад ихэнх төрийн албан хаагчид амралтаа авдаг тул төрийн байгууллагууд дээр шаардлагатай мэдээллийг гарган өгөх ажилтнууд байсангүй. Тиймээс Тогтвортой бичил уурхай төсөл нь дараа дараагийн судалгааг хийхдээ өөр хугацааг сонгон авах шаардлагатай.
- Төсөв болон цаг хугацааны хязгаарлалтаас хамааран энэхүү суурь судалгааг зөвхөн 195 оролцогчийн хүрээнд хийж гүйцэтгэх шаардлага тулгарсан. Гэхдээ үндсэн оролцогч нарыг хэсэглэн бүлэглэснээр нэг сегментэд цөөн тооны оролцогч хамаарагдах болсон нь тухайн зорилтот бүлгийг бүрэн төлөөлөх хэмжээнд хүрээгүй. Судалгааг статистикын хувьд ач холбогдолтой болгох үүднээс дараагийн судалгаануудад хамгийн багадаа 300 оролцогчийг хамруулах шаардлагатай.
- Суурь судалгааг хийж гүйцэтгэх явцад албан болон албан бус гар аргаар ашигт малтмал олборлогчдын орлогын түвшний ялгааг харьцуулан судлах нь судлаачдын сонирхлыг татсан асуудал байлаа. Тус судалгаа нь эдийн засаг болон орлогын түвшний үүднээс албан ёсны зохион байгуулалтад хамрагдах нь үр дүнтэй байх, үгүй эсэхийг илтгэн харуулах боломжтой юм. Хэрэв үр дүн нь эерэг байвал Тогтвортой бичил уурхай төсөл нь илүү олон тооны албан бус бичил уурхайчдыг албан ёсны болгон бүртгэлжүүлэх боломжтой болно.
- ТББ-уудад бүртгүүлэх нь ихээхэн ярвигтай байдаг бөгөөд ажиглалтаас үзвэл ТББ-ууд нь өөрсдийн найз, хамтран ажиллагч эсвэл гэр бүлийнхнээ л бүртгэн авдаг ажээ. Хэрэв тухайн нэг бичил уурхай эрхлэгч ТББ-ын ажилтнуудын хэн нэгнийг танихгүй бол тэднийг бүртгэн авдаггүй байна. Тиймээс энэ нь чухал асуудал бөгөөд ТББ-ууд нь бичил уурхайчдын өөрсдийн үзэмжээр ялгаварлан гадуурхаж байна хэмээн үзэж болно.

- Ченжийг ТББ-уудын үйл ажиллагаанд татан оруулах нь тэдний албан ёсны болгож, гар аргаар болон бичил уурхайгаар олборлолт хийж буй үйл ажиллагаанаас орон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд нөлөөллийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байх юм.
- Судалгааны баг нь олон тооны бичил уурхайчид хоёрдогч ажил эрхлэж буйг тогтоосон. Судалгаанд хамрагдсан бичил уурхайчдын ойролцоогоор 30 орчим хувь нь мал аж ахуй, газар тариалан, хөлсөөр хүн тээвэрлэх болон хувийн бизнес зэрэг хоёрдогч ажлыг эрхэлж байна. Тиймээс ашигт малтмалын олборлолт нь улирлаас хамааралтай орлого, ажлын байрны боломж зэргийг орлож байна. Улирлын ялгааны хувьд бичил уурхайчдын 80 илүү хувь нь, ченжийн 90 гаруй хувь нь өвлийн улирал ямар нэгэн байдлаар ашигт малтмал олборлодоггүй хэмээн хариулжээ. Судалгаанаас үзвэл өвлийн улирал уул уурхайн олборлолт удааширдаг эсвэл зогсдог бөгөөд тэдний 37% нь хувийн бизнесээ эрхэлдэг, 6% нь малаа хариулдаг, 4% нь өөр бусад газарт шилжин олборлолт хийдэг, үлдэх хэсэг нь төрийн эсвэл хувийн байгууллагуудад ажилладаг хэмэжээ. Ченжийн хувьд ашигт малтмалын олборлолт удааширсан эсвэл зогссон үед 60% нь хувийн бизнесээ эрхэлдэг бол 23% нь ямар нэгэн ажил хийдэггүй, үлдэх хувь нь мал малладаг байна. Тиймээс орон нутгийн албаны хүмүүстэй нягт холбоотойгоор тэдгээр хүмүүсд бизнесийн сургалт, семинарыг явуулах нь бичил уурхай эрхлэгчид, ченжийн бусад улирлын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдлыг сайжруулан, улмаар тэдний амьжиргаа, орлогын түвшинд ч сайн нөлөө үзүүлэх боломжтой юм. Өөр нэгэн боломжит шийдэл нь хөдөлмөр эрхлэлтийн боломжийг ханган өгдөгбусад төслүүдтэй хамтран ажиллаж, хөдөлмөр эрхлэх эсвэл бизнес эрхлэхэд шаардлагатай ур чадваруудыг ханган өгөх явдал байж болно. Гэр бүлийн гишүүдэд жишээ нь эхнэр, нөхөр эсвэл насандхүрсэн хүүхдүүдэд бизнесийн сургалт, хичээлийг зохион байгуулах нь тэдний орлогыг төрөлжүүлэх хамгийн үр дүнтэй арга байх болно.
- Судалгаанд хамрагдсан олон тооны хүмүүс гар аргаар ашигт малтмал олборлож эхэлсэнээс хойш эрүүл мэндийн бадал нь ихээхэн муудсан талаар цохон дурдаж байсан. Тоосжилт бүхий, хүйтэн нөхцөлд ажилладаг тул өвчлөх тохиолдол улам илүү болж, эрт нас баралт улам нэмэгдэж байна. Одоогоор бичил уурхайчдын эрүүл мэндтэй холбоотой цорын ганц бүртгэл мэдээлэл нь гарсан осол болон гэмтлийн тоо л байна. Өөрөөр энэ асуудлаар ямар нэгэн

бүртгэл мэдээлэл байхгүй буй юм. Тиймээс бичил уурхайчдын орлогын түвшнийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэхийн тулд төслийн зүгээс бичил уурхайчдын эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэх шаардлагатай байна.

## 11. ХАВСРАЛТ

### 11.1 Суурь судалгааны хураангуй

Бичил уурхайчид болон ченж нарын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй шууд, шууд бус, дам нөлөөллийг дараах байдлаар тооцоолон бодов.

#### Шууд эдийн засгийн нөлөөлөл – Сумын түвшинд

| Байршил               |           | Татвар, хураамж<br>(төгрөг/сар) | Ажил эрхлэлт<br>(төгрөг/сар) |               | Худалдан авалт<br>(төгрөг/сар) | Нийт<br>(төгрөг/сар) |
|-----------------------|-----------|---------------------------------|------------------------------|---------------|--------------------------------|----------------------|
| Аймаг                 | Сум       |                                 | Ажлын байр                   | Цэвэр орлого  |                                |                      |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 27,585,050                      | 832                          | 247,852,400   | 400,796,210                    | 676,233,660          |
|                       | Бөмбөгөр  | 26,296,020                      | 2112                         | 424,575,610   | 808,577,700                    | 1,259,449,330        |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 37,410,845                      | 1935                         | 865,504,523   | 940,032,000                    | 1,842,947,368        |
|                       | Бигэр     | Na                              | Na                           | Na            | Na                             | Na                   |
| Дорноговь             | Айраг     | 2,688,835                       | 169                          | 110,256,536   | 140,431,830                    | 253,377,201          |
| Дундговь              | Хулд      | 21,051,240                      | 489                          | 388,586,396   | 167,945,200                    | 577,582,836          |
|                       | Өлзийт    | 11,555,530                      | 392                          | 341,770,904   | 110,628,112                    | 463,954,546          |
| Сэлэнгэ               | Мандал    | 5,123,510                       | 534                          | 163,539,096   | 168,830,970                    | 337,493,576          |
|                       | Шарын гол | 161,282                         | 851                          | 215,526,450   | 1,613,602,872                  | 1,829,290,604        |
|                       | Орхонтуул | 3,222,300                       | 301                          | 119,227,200   | 219,599,700                    | 342,049,200          |
| Төв                   | Заамар    | 1,428,925                       | 150                          | 152,602,760   | 256,045,660                    | 410,077,345          |
|                       | Борнуур   | 1,504,864                       | 152                          | 48,187,000    | 57,066,136                     | 106,758,000          |
| Нийт                  |           | 138,028,401                     | 7917                         | 3,077,628,875 | 4,883,556,390                  | 8,099,213,666        |

Бичил уурхайчид болон ченж нар шууд болон шууд бус нөлөөллийн замаар дээрх 12 суманд ойролцоогоор 8489 ажлын байрыг бий болгосон байна. Үүнээс 7917 ажлын байрыг албан болон албан бус бичил уурхайчид, 572 ажлын байрыг ЖДБ эрхлэгчид бичил уурхайн нөлөөллөөр бий болгосон байна.

### Эдийн засгийн шууд бус нөлөөлөл – сумын түвшинд

| Байршил               |           | ЖДБ-ын тоо | Дундаж татвар, хураамж (төгрөг/сар) | Ажил эрхлэлт |                                    | Үйл ажиллагааны дундаж зардал (төгрөг/сар) | Нийт (төгрөг/сар) |
|-----------------------|-----------|------------|-------------------------------------|--------------|------------------------------------|--------------------------------------------|-------------------|
| Аймаг                 | Сум       |            |                                     | Ажлын байр   | Ажилчдын дундаж цалин (төгрөг/сар) |                                            |                   |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 1          | 0                                   | 1            | 0                                  | 630,000                                    | 630,000           |
|                       | Бөмбөгөр  | 1          | 7144.8                              | 6            | 50666.72                           | 69,093                                     | 380,238           |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 199        | 8831.25                             | 199          | 14400                              | 81,000                                     | 20,742,019        |
|                       | Бигэр     | 10         | 8937.5                              | 20           | 25000                              | 44,125                                     | 1,030,625         |
| Дорноговь             | Айраг     | 18         | 60280.73                            | 36           | 95625                              | 136,128                                    | 6,977,857         |
| Дундговь              | Хулд      | 8          | 129740.1                            | 16           | 374400                             | 330,681                                    | 9,673,769         |
|                       | Өлзийт    | 6          | 86398.8                             | 12           | 0                                  | 109,800                                    | 1,177,193         |
| Сэлэнгэ               | Мандал    | 85         | 96810                               | 170          | 350000                             | 907,900                                    | 144,900,350       |
|                       | Шарын гол | 24         | 31460.85                            | 48           | 43200                              | 105,750                                    | 5,366,660         |
|                       | Орхонтуул | 12         | 31800                               | 24           | 144900                             | 147,000                                    | 5,623,200         |
| Төв                   | Заамар    | 16         | 21474.75                            | 32           | 75000                              | 110,625                                    | 4,513,596         |
|                       | Борнуур   | 4          | 60077.5                             | 8            | 525000                             | 411,250                                    | 6,085,310         |
| Нийт/дундаж           |           | 384        | 45,246                              | 572          | 141,516                            | 256,946                                    | 207,100,817       |

### Эдийн засгийн дам нөлөөлөл – Сумын түвшинд

| Байршил               |           | Бичил уурхайчин, ченжийн тоо | Малчидын тоо | Бичил уурхайчид, ченж      | Малчид                     | Нийт (төгрөг/сар) |
|-----------------------|-----------|------------------------------|--------------|----------------------------|----------------------------|-------------------|
| Аймаг                 | Сум       |                              |              | Өрхийн сарын дундаж зардал | Өрхийн сарын дундаж зардал |                   |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 830                          | 360          | 123,193                    | 266,458                    | 198,174,968       |
|                       | Бөмбөгөр  | 2,100                        | 406          | 76,110                     | 222,777                    | 250,277,517       |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 1,920                        | 424          | 82,657                     | 121,666                    | 210,288,400       |
|                       | Бигэр     | NA                           | 529          | 79,056                     | 118,888                    | 62,891,752        |
| Дорноговь             | Айраг     | 165                          | 289          | 103,032                    | 204,361                    | 76,060,534        |
| Дундговь              | Хулд      | 488                          | 328          | 102,892                    | 196,200                    | 114,564,733       |
|                       | Өлзийт    | 388                          | 408          | 79,278                     | 321,428                    | 161,902,533       |
| Сэлэнгэ               | Мандал    | 530                          | 465          | 100,907                    | 128,833                    | 113,387,917       |
|                       | Шарын гол | 846                          | 376          | 41,472                     | 311,250                    | 152,115,122       |
|                       | Орхонтуул | 300                          | 143          | 83,411                     | 79,166                     | 36,343,971        |
| Төв                   | Заамар    | 130                          | 501          | 71,932                     | 144,277                    | 81,633,904        |
|                       | Борнуур   | 148                          | 467          | 46,195                     | 129,444                    | 67,287,171        |
| Нийт                  |           | 7845                         | 4696         |                            |                            | 1,524,928,522     |

## Эдийн засгийн үржүүлэхийн арга – Сумын түвшинд

Эдийн засгийн шууд, шууд бус, дам нөлөөллүүд нь эдийн засгийн үржүүлэхийн аргын нэг цөм хэсэг юм. Үржүүлэхийн аргыг бодож гаргахдаа шууд, шууд бус, дам нөлөөллүүдийн үр дүнг ашиглан гаргадаг. Судалгааны үр дүнд бичил уурхайчид болон ченж нарын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр нь 1.189 байна. Энэ нь бичил уурхайчид болон ченжийн тухайн эдийн засагт оруулж буй 100 төгрөг нь 118.9 төгрөг болон нөлөөлөл үзүүлж байгааг илэрхийлж байна.

| Нөлөөллийн хэлбэр | Эдийн засгийн нөлөөлөл (төгрөг/сар) | Үржүүлэх     |
|-------------------|-------------------------------------|--------------|
| Шууд              | 8,099,213,666                       | 1            |
| Шууд бус          | 207,100,817                         | 0.026        |
| Дам нөлөөлөл      | 1,326,753,554                       | 0.164        |
| <b>Нийт</b>       | <b>9,633,068,037</b>                | <b>1.189</b> |

## Эдийн засгийн нөлөөллийн нэгдсэн дүн – Сумын түвшинд

| Байршил               |           | Эдийн засгийн нөлөөлөл (төгрөг/сар) |                    |                      | Эдийн засгийн үржүүлэх |              |              | Нийт         |
|-----------------------|-----------|-------------------------------------|--------------------|----------------------|------------------------|--------------|--------------|--------------|
| Аймаг                 | Сум       | Шууд                                | Шууд бус           | Дам нөлөөлөл         | Шууд                   | Шууд бус     | Дам нөлөөлөл |              |
| Баянхонгор<br>khongor | Баян-Овоо | 676,233,660                         | 630,000            | 198,174,968          | 1                      | 0.001        | 0.293        | 1.294        |
|                       | Бөмбөгөр  | 1,259,449,330                       | 380,238            | 250,277,517          | 1                      | 0.000        | 0.199        | 1.199        |
| Говь-Алтай            | Есөнбулаг | 1,842,947,368                       | 20,742,019         | 210,288,400          | 1                      | 0.011        | 0.114        | 1.125        |
|                       | Бигэр     | Na                                  | 1,030,625          | 62,891,752           | 1                      | Na           | Na           | Na           |
| Дорноговь             | Айраг     | 253,377,201                         | 6,977,857          | 76,060,534           | 1                      | 0.028        | 0.300        | 1.328        |
| Дундговь              | Хулд      | 577,582,836                         | 9,673,769          | 114,564,733          | 1                      | 0.017        | 0.198        | 1.215        |
|                       | Өлзийт    | 463,954,546                         | 1,177,193          | 161,902,533          | 1                      | 0.003        | 0.349        | 1.351        |
| Сэлэнгэ               | Мандал    | 337,493,576                         | 144,900,350        | 113,387,917          | 1                      | 0.429        | 0.336        | 1.765        |
|                       | Шарын гол | 1,829,290,604                       | 5,366,660          | 152,115,122          | 1                      | 0.003        | 0.083        | 1.086        |
|                       | Орхонтуул | 342,049,200                         | 5,623,200          | 36,343,971           | 1                      | 0.016        | 0.106        | 1.123        |
| Төв                   | Заамар    | 410,077,345                         | 4,513,596          | 81,633,904           | 1                      | 0.011        | 0.199        | 1.210        |
|                       | Борнуур   | 106,758,000                         | 6,085,310          | 67,287,171           | 1                      | 0.057        | 0.630        | 1.687        |
| <b>Нийт</b>           |           | <b>8,099,213,666</b>                | <b>207,100,817</b> | <b>1,326,753,554</b> | <b>1</b>               | <b>0.026</b> | <b>0.164</b> | <b>1.189</b> |

## 11.2 Terms of Reference

### **Terms of Reference for conducting a baseline study on the value of investment made by miners and traders into local economic sector and their contribution to economic growth in ASM dependant aimags.**

Place of mission: In ASM Aimags: Bayankhongor, Gobi-Altai, Dornogobi, Dundgobi, Tuv, Selenge, and Uvs

Duration of mission: Two months: June 15- Aug 14, 2015

Total budget: CHF10,000 as a maximum. (However, a proposal with the highest quality and the lowest cost will be selected).

## **1 Background**

In Phase 4 of its implementation, one of broad Outcome areas of the Sustainable Artisanal Mining (SAM) Project is focusing on maximizing commodities contributions from Artisanal and Small-scale Mining (ASM) to economic strengthening and improved livelihoods at local, regional and national levels. Therefore, the main factors SAM project believes to be important towards reaching this goal would comprise of:

- formalizing ASM activities
- formalizing minerals supply chains to increase the contribution of ASM sub-sector into treasury funds of the state and payment of royalties,
- building supply chain resiliency through formalising all actors enabling participation of more ASMers and traders.
- expanding economic choice and freedom to support ASM miners and traders for creation of business models and alternative income generation activities, and
- rural economic strengthening by stimulating contributions of miners and traders to rural livelihoods and economic diversification and resilience.

In order to indicate ASM contributions to local economy after project interventions, the current level of contributions should be identified for the purpose of making comparison of project impact and scenarios at the end of this phase. Miners and traders are considered to be main economic players and contributors in the local areas in addition to their monthly income tax payment of 53,000MNT to local governments. This baseline study to be undertaken in project intervention areas aims at assessing value of investments made by the ASM sub-sector into local economic sectors and their contribution to economic growth in ASM aimags. Investments can be physical and/or intellectual as well as taxes, social security and health insurance paid by miners and traders. Income diversification by both miners and traders will be determined. The study will also determine current economic growth rate of the aimags and classify the key contributors and define the level of contribution from ASM where appropriate, especially for ASM dependant aimags.

## **2 Objectives and Tasks**

The main objective of this baseline study is to indicate current level of value of investments made by miners and traders into local economic sectors and their contribution to economic growth in ASM dependant aimags.

### **Specific tasks:**

The followings would be main tasks of the service provider, but not limited to:

- Define economic output by ASM in specific soums and aimags
- Identify main areas/fields of investments made by ASM sub-sector
- Determine the amount of investment in each of the areas/fields identified above
